

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
05 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1 – 2
Хуралдааны товч тэмдэглэл:	3 – 42
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	43 – 233
1. Хуулийн төслүүдийг эцэслэн батлах	46 – 47
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/	47 – 49
3. Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2025.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	49 – 50
4. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	50
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	51 – 52
6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	52 – 63
7. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хог хаягдлын менежментийн санхүүжилтийн тогтолцоо, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах талаар/	63
8. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар/	64
9. Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл /“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/	64 – 68
10. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	68 – 105
11. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	106 – 124

12.	<i>Улсын Их Хурлын асуулгын цаг</i>	124 – 173
13.	<i>Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	173 – 184
14.	<i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	184 – 198
15.	<i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	198 – 201
16.	<i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	201 – 208
17.	<i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг, санал хураалтаар үргэлжлэв./</i>	208 – 209
18.	<i>Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, санал хураалтаар үргэлжлэв./</i>	209 – 210
19.	<i>Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл /“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх, санал хураалтаар үргэлжлэв./</i>	210 – 211
20.	<i>“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал хураалтаар үргэлжлэв./</i>	211 – 231
21.	<i>Хууль, тогтоолын эцсийн найруулга таницуулах</i>	231
22.	<i>“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, санал хураалтаар үргэлжлэв.</i>	232 – 233

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 29-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Дэлгэрсайхан, Ц.Идэрбат, Ч.Лодойсамбуу, Н.Номтойбаяр, У.Отгонбаяр, Ц.Туваан, Б.Тулга, А.Ундраа, Ч.Ундрэм, Б.Уянга, Б.Хэрлэн, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Ж.Баясгалан, Г.Дамдинням;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батцэцэг, С.Замира, Э.Одбаяр, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Д.Амарбаясгалан;

Хоцорсон: С.Амарсайхан–04 минут, Ч.Анар–08 минут, Т.Аубакир–5 цаг 26 минут, Ц.Баатархүү–45 минут, М.Бадамсүрэн–22 минут, Э.Бат-Амгалан–01 минут, Н.Батсүмбэрэл–06 минут, Х.Баттулга–10 минут, Х.Болормаа–04 минут, Э.Болормаа–1 цаг 48 минут, Ш.Бямбасүрэн–18 минут, Ж.Галбадрах–24 минут, С.Ганбаатар–10 минут, Д.Ганбат–2 цаг 58 минут, Л.Гантөмөр–1 цаг 59 минут, Х.Ганхуяг–14 минут, Ц.Даваасүрэн–21 минут, Т.Доржханд–42 минут, Б.Жавхлан–4 цаг 04 минут, Б.Жаргалан–13 минут, Ж.Золжаргал–04 минут, Ц.Мөнхбат–1 цаг 44 минут, Л.Мөнхбаясгалан–24 минут, П.Мөнхтулга–10 минут, З.Мэндсайхан–23 минут, Б.Найдалаа–07 минут, С.Одонтуяа–23 минут, Л.Оюун-Эрдэнэ–3 цаг 15 минут, Ц.Сандаг-Очир–5 цаг 27 минут, Р.Сэддорж–07 минут, Б.Түвшин–23 минут, Г.Тэмүүлэн–6 цаг 18 минут, Н.Учрал–28 минут, Б.Уянгахишиг–07 минут, Да.Цогтбаатар–01 минут, Д.Цогтбаатар–3 цаг 11 минут, О.Цогтгэрэл–16 минут, Б.Энхбаяр–02 минут, Ж.Энхбаяр–05 минут, Р.Эрдэнэбүрэн–30 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан нараас 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хассан талаар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Б.Жаргалан, Л.Мөнхбаясгалан нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 75 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн нар байлцав.

С.Бямбацогт: Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 13
Бүгд: 81
84.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

С.Бямбацогт: Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 12
Бүгд: 82
85.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

С.Бямбацогт: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 20
Бүгд: 83
75.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, О.Амгаланбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, О.Амгаланбаатар нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 26
Бүгд: 84
69.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /10:20/

Гурав.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2025.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр, Ц.Долгормаа нар байлцав.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 26
Бүгд: 89
70.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: Хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 51
Бүгд: 89
42.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид буцаах тухай тогтоол батлагдсанд тооцов.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, Б.Баярсайхан нар байлцав.

“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 18
Бүгд: 91
80.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 27 минутад хэлэлцэж дууслаа.

Тав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье” гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 46
Бүгд: 92
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 43

Бүгд: 92

53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /10:30/

Зургаа.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, Б.Баярсайхан нар байлцав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Нэг.ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ ТОМЬЁОЛОЛ

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, О.Алтангэрэл, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд /цаашид “Ажын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн “цахилгаан дугуй, цахилгаан скүүтер, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгсэл” гэсэн нэр томьёог хуулийн төслийн тохиолдол бүрд “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 18

Бүгд: 93

80.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11¹ дүгээр зүйл.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээний хяналт, зохицуулалт

11¹.1.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлнэ.

11¹.2.Энэ хуулийн 11¹.1-д заасан гэрээнд нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой төлбөр, хураамж, зорчих бүсчлэл, зогсоолын талбайн байршил зэрэг талуудын эрх, үүргийн харилцааг зохицуулсан байна.

11¹.3.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 11¹.1-д заасан гэрээний нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга нь үйл ажиллагааг нь түр хязгаарлах, эсхүл гэрээг цуцлах арга хэмжээг авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 20

Бүгд: 93

78.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“12¹ дүгээр зүйл.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн эрх, үүрэг

12¹.1.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн энэ хуульд тусгайлан зааснаас бусад эрх, үүргийг Замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох хуульд заасан журмын дагуу зохицуулна.

12¹.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 18 буюу түүнээс дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцох эрхтэй.

12¹.3.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн жолооч нь энэ хуулийн 14.2-т заасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

12¹.4.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгслээ Автотээврийн тухай хуулийн 17¹.2-т заасан журмын дагуу бүртгүүлэх үүрэгтэй.

12¹.5.Эцэг, эх, асран хамгаалагч нь 18 нас хүрээгүй хүүхдийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Г.Уянгахишиг, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 34

Бүгд: 94

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13¹.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 29

Бүгд: 95

69.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13¹.2.2 дахь заалтын “цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг улсын бүртгэлд” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг” гэж өөрчилж, 13¹.2.10, 13¹.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13¹.2.10.18 нас хүрээгүй хүүхэд болон энэ хуулийн 12¹.3-т заасан сургалтад хамрагдаж, бүртгүүлээгүй хүнийг нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах;

13¹.2.11.нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 29

Бүгд: 95

69.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13¹.2.9 дэх заалтын “, цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг зүй зохистой ашиглах хэрэглээний соёлыг эзэмшүүлэх” гэснийг болон 13¹.2.3, 13¹.2.4, 13¹.2.5, 13¹.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 30

Бүгд: 95

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.12.“мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр, эсхүл хэд хэдэн дугуйтай тээврийн хэрэгслийг;

3.1.13.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг нийтэд төлбөртэйгээр ашиглуулах үйл ажиллагааг;

3.1.14.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг гэрээний үндсэн дээр хэрэглэгчид төлбөртэйгээр, тодорхой хугацаагаар ашиглуулах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг хуулийн этгээдийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 29

Бүгд: 95

69.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “мопедоос” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээс” гэж, 3.1.11 дэх заалтын “мопед” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 35
Бүгд: 95
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 32
Бүгд: 95
66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 12¹.4 дэх хэсэг болон 3 дахь заалтын 13¹.2.11 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 30
Бүгд: 95
68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 31
Бүгд: 95
67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “58, 59, 60, 61, 62, 63, 64 дахь” гэснийг “59, 60, 61 дэх” гэж өөрчилж, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 59 дэх хэсэг болгох:

“59.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодож явган хүний гарцаар зам хөндлөн гарсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 33
Бүгд: 95

65.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 62 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“62.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцсон арван найман нас хүрээгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 35
Бүгд: 95

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 63.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.4.арван найман нас хүрээгүй хүүхэд болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2-т заасан сургалтад хамрагдаагүй хүнийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 38

Бүгд: 95

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 59, 60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4, 63.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Гурав.ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 39

Бүгд: 95

58.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хог хаягдлын менежментийн санхүүжилтийн тогтолцоо, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах талаар/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Энхгэрэл, Ц.Рэнцэнтогтох, Б.Бадралт нар байлцав.

С.Бямбацогт: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 34
Бүгд: 95
64.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Бат-Эрдэнэ нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Найм. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Зулцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга, Б.Батцэцэг нар байлцав.

С.Бямбацогт: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 30
Бүгд: 95
68.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Ес. Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл /“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Соёлын өвийн хэлтсийн дарга Б.Даваацэрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, С.Дунжидмаа, референт А.Наранцэцэг, Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нар танилцуулав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /11:06/

Арав. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон

гүйцэтгэгч М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Баттуяа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Эрсдэлийн удирдлага, хяналтын газрын дарга Л.Наранчимэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Баянзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль, эрх зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Отгонбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 12 цаг 05 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Пүрэвдорж, С.Эрдэнэболд, Д.Рэгдэл, С.Зулпхар, Ч.Анар, Б.Түвшин, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Төсвийн байнгын хорооны дарга Б.Заяабал, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /12:32/

Арван нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Д.Энхтүвшин, Б.Жаргалан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Р.Эрдэнэбүрэн нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /13:12/

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 13 минут үргэлжилж, 13 цаг 13 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14 цаг 01 минутаас хуралдааныг даргалав.

Арван хоёр.Улсын Их Хурлын асуулгын цаг

Улсын Их Хурлын асуулгын цагт Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1-д “Ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна.”, 112.5-д “Улсын Их Хурлын асуулгын нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй. Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа цөөнхийн бүлэгт 75 минутаас, олонхын бүлэгт 15 минутаас, цөөнхийн гишүүдэд 30 минутаас хэтрэхгүй байна.” гэж тус тус заасныг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал нарыг “Их хуралдай” танхимын голд тусгайлан бэлдсэн индэрт урив.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 14 цаг 08 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Г.Очирбат, С.Эрдэнэболд, Ө.Шижир, Г.Ганбаатар, Д.Батбаяр, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, С.Ганбаатар, Ц.Баатархүү нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, О.Саранчулуун, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдээс Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын асуулгын цагт Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн бүлгийн гишүүд болон Улсын Их Хурлын цөөнхийн гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авч дууслаа.

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 15 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Арван гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Р.Эрдэнэбүрэн нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /16:15/

Арван дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, С.Эрдэнэболд, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /16:49/

Арван тав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /16:55/

Арван зургаа.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /17:07/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

С.Бямбацогт: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 77
Татгалзсан: 27
Бүгд: 104

74.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

С.Бямбацогт: Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 44
Бүгд: 104
57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх, хэлэлцүүлэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, С.Дунжидмаа, референт А.Наранцэцэг, Б.Гандиймаа нар байлцав.

С.Бямбацогт: “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 24
Бүгд: 104
76.9 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, Х.Шижирмөнх нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 1.Тогтоолын төслийн 1 дэх дэд заалтын “төсөл, арга хэмжээг” гэсний дараа “эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлэн өндөр үр өгөөжтэй төсөл, арга хэмжээг тэргүүн ээлжид” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 47

Бүгд: 104

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Х.Баасанжаргал нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 56.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх;

“3/Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлал, үнэлгээний үзүүлэлтийг боловсруулж, 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 36

Бүгд: 104

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх;

4/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-ийг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө болон улсын төсвийн төслийг боловсруулахдаа бүрэн тусгасан байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 35

Бүгд: 104

66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх;

Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Нийт гишүүдийн олонхын саналаар эцэслэн батлагдах заалттай. Гишүүд санал хураалтдаа бүгд бэлэн болсон уу? Санал хураалтыг явуулъя. Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулъя.

“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя” гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Т.Мөнхсайхан гишүүний горимын санал.

Т.Мөнхсайхан: Саяын санал хураалтад оролцсон төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

С.Бямбацогт: Улсын Их Хурал эцэслэн баталсан байх. 6 дугаар сарын 01-нд хуультай. Улсын Их Хурал эцэслэн батлахгүй бол дэгийн тухай хуулиа зөрчинө.

О.Амгаланбаатар гишүүн горимын санал.

О.Амгаланбаатар: Би санал хураалтад миний буруугаас амжсангүй. Тэгээд энэ санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү.

С.Бямбацогт: О.Амгаланбаатар, Т.Мөнхсайхан нарын горимын саналыг дэмжье гэсэн, санал хураалтыг хүчингүй болгох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал дэмжигдлээ. /алх цохив/

Дараагийн санал хураалтыг явуулж байя. Гишүүд, бүлгүүд хоорондоо бас ярилцаач. Ж.Батжаргал дарга, О.Цогтгэрэл дарга.

Улсын Их Хурал 6-р сарын 01-ний дотор төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан байх Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай.

Үүнийг батлахгүй бол дэгийн хууль зөрчигдөх гээд байна. Тийм болохоор хоёр бүлгийн дарга бас энэ асуудал дээр нь ярилцаад, ойлголцох талаар ажиллаадхаач.

Дараагийн санал хураалт. Дараагийн асуудалдаа орьё.

**Гурав.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн
2025.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. /алх цохив/

Санал хураалтыг явуулъя. Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 89 гишүүн оролцоноос 63 гишүүн дэмжиж, 70.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 89 гишүүн оролцоноос 38 гишүүн дэмжиж, 42.7 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль дэмжигдсэн. Үүнийг хэлэлцээд явна. Баялгийн сан руу гар дүрэх хуулийг дэмжсэнгүй. Энэ буцаагдлаа шүү.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

**Дөрөв. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Дараагийн асуудалдаа оръё. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэж дууслаа. Санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооны саналаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 73 гишүүн дэмжиж, 80.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. /алх цохив/

Хүний эрх, эрх чөлөөний тайланг бас хэлэлцэж, Засгийн газарт нэлээн өргөн хүрээтэй хүний эрхийг хамгаалах, хангах чиглэлээр тогтоол өгсөн. Тогтоолоо дагалдуулж тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, тогтоолын хэрэгжилтийг хянах, хэмжих, дүгнэх ийм хавсралттай тогтоол батлагдсан их онцлогтой болж байгаа шүү.

Тогтоолын төслийг боловсруулсан ажлын хэсэгт баярлалаа. Баталсан Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлье.

Тав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Үг хэлэх дэг байхгүй. Цаашдаа бидний хэлэлцэх эсэх нь шийдсэн хэлэлцэж байгаа дэгийн хуульд яг энэ үед хууль санаачлагч хуулиа тайлбарлаж үг хэлэх заалт орж байгаа. Одоо бол тийм зохицуулалт байхгүй учраас үг хэлэх боломжгүй байгаа.

Өчигдөр бид нэлээн ярьсан. Тийм ээ. Шаталсан болгож болох уу, болохгүй юу гээд нэлээн ярилцсан байгаа. Тэгээд гишүүд өөрсдөө итгэл үнэмшлээрээ саналаа өгөх байх.

Одоо Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя.

“Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье” гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 46 гишүүн дэмжиж, 50 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Горимын санал гаргах гэж байна уу? Л.Мөнхбаясгалан гишүүний горимын санал.

Л.Мөнхбаясгалан: Энэ кноп ажилласангүй. Тийм учраас саналыг хүчингүй болгож өгнө үү.

С.Бямбацогт: Л.Мөнхбаясгалан гишүүний саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 49 гишүүн дэмжиж, 53.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хүчингүй болгох.

Энэ санал хураалтаа хоёр бүлгийн дарга бас нэг ярилцаадах. Тэгэх үү? Ойлголцоод явцгаая аа, хэдүүлээ. Заавал одоо юу яахгүй. Энэ санал хураалтыг хойшлууллаа.

Хураахаар уначих гээд байна шүү дээ. Наадах чинь.

Зургаа.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн
2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй 17 санал байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалтыг явуулъя. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн “цахилгаан дугуй, цахилгаан скүүтер, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгсэл” гэсэн нэр томъёог хуулийн төслийн тохиолдол бүрд “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, О.Алтангэрэл, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд. Цаашид “Ажын хэсэг” гэх.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 75 гишүүн буюу 80.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11¹ дүгээр зүйл.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээний хяналт, зохицуулалт

11^{1.1}.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлнэ.

11^{1.2}.Энэ хуулийн 11^{1.1}-д заасан гэрээнд нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой төлбөр, хураамж, зорчих бүсчлэл, зогсоолын талбайн байршил зэрэг талуудын эрх, үүргийн харилцааг зохицуулсан байна.

11^{1.3}.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 11^{1.1}-д заасан гэрээний нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга нь үйл ажиллагааг нь түр хязгаарлах, эсхүл гэрээг цуцлах арга хэмжээг авна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 73 гишүүн буюу 78.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“12¹ дүгээр зүйл.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн эрх, үүрэг

12^{1.1}.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн энэ хуульд

тусгайлан зааснаас бусад эрх, үүргийг Замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох хуульд заасан журмын дагуу зохицуулна.

12¹.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 18 буюу түүнээс дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцох эрхтэй.

12¹.3.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн жолооч нь энэ хуулийн 14.2-т заасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

12¹.4.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгслээ Автотээврийн тухай хуулийн 17¹.2-т заасан журмын дагуу бүртгүүлэх үүрэгтэй.

12¹.5.Эцэг, эх, асран хамгаалагч нь 18 нас хүрээгүй хүүхдийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэгтэй.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

Энэ дээр Г.Лувсанжамц гишүүн үг хэлэхээр нэр авсан байгаа юм байна шүү. Энэ санал хураалтыг хүчингүй болгоё. Дэгээрээ Г.Лувсанжамц гишүүн нэрээ өгсөн байгаа юм байна. Энэ санал хураалт хүчингүй. Г.Лувсанжамц гишүүн саналаа хэлье. Дэмжсэн, дэмжээгүй.

Г.Лувсанжамц: Гишүүд ээ, өдрийн мэнд хүргэе.

Энэ хуулийн төслийг П.Батчимэг гишүүний хамтаар өргөн барьсан.

Шийдэх гэж байгаа гол асуудал нь өнөөдөр хүүхдүүд бэртэж гэмтээд байгаа, сундалж унаж яваад байгаа, хаа сайгүй скүүтэр, мопедод тавиад байгаа асуудлуудыг нь шийдье гэсэн.

11¹, 12¹, 21¹ заалтуудыг бүгдийг нь хасаад, өөрчлөөд ороод ирсэн буюу хуулийн төслийг өргөн барьснаас 70 хувийн өөрчлөлтийг оруулж ирсэн.

Ажлын хэсэг дээр ажилласан Г.Уянгахишиг гишүүний саналуудыг заримыг нь дэмжиж байгаа. Мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, зөвлөмжийг авч байгаад оруулсан гэсэн санал хэлсэн.

Гэхдээ энэ дээр 12^{1.3} дээр байгаа. 14.2-т заасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлсэн байна гэж байгаа юм.

Шинэ бизнес гаргаж ирэх гээд байгаа гэсэн үг. Жолооны “А” үнэмлэхтэй, эсвэл “В” үнэмлэхтэй байх юм бол мопед ашигладаг болъё. E-Mongolia ашиглаад л шууд тэр нь хэрэгжээд явдаг боломж нь байгаа.

Энэ зарчмаараа явах юм бол төрөөс үзүүлж байгаа энэ данхар бүтэц ч байдаг юм уу, олон шат дамжлагуудыг нь байхгүйгээр хариуцлагтай жолооч нар нь өөрсдөө авто замаараа унаад явдаг ийм боломжийг бүрдүүлье гэсэн заалтуудыг оруулсныг “сургалтад хамрагдсан байх” гэсэн шинэ зүйл, заалт оруулж ирж байгаа юм.

Аливаа нэг байгууллага ч юм уу, хүний бизнесийг дэмжих гээд байгаа юм шиг ийм санал байгаа юм. Үүнийг дэмжихгүй байгаа саналтай байна.

Хоёрдугаарт, саяын санал хураахад хамгийн эхний санал хураалт дээр энэ скүүтрийг мопедын төрөлд оруулж байгаа.

Скүүтэр бол техникийн стандартаараа 25 километр цаг хүртэл хурдтай явдаг. Мопед бол 50 километр цагаар явдаг. Одоо энэ агуулгаараа баталгаадаад явах юм бол юу болох вэ гэхээр “Жет” (Jet Sharing Mongolia), “Тапа” (Tapatrip) гээд скүүтэр оруулж ирж байгаа компаниуд маань 50 километр цагийн хурдтай явдаг тоног төхөөрөмжүүдийг оруулаад ирнэ гэсэн үг. Ирэх жилээс эхлээд.

Одоо 25 километр цагаараа ийм их осол аваар гарч байхад жолооны үнэмлэхгүй хүн 50 километр цагийн хурдтай явдаг мопедыг унаад явах юм бол өнөөдөр үүсээд байгаа осол аваар, Гэмтэлийн эмнэлгээр дүүрэн байгаа шилбэ нь хугарсан, шагай нь хагарсан ийм хүмүүс улам ихсээд явна гэсэн үг.

Тэгэхээр саяын гаргаж байгаа, энэ ажлын хэсгээс гаргаж байгаа саналуудыг дэмжихгүй байр суурьтай байгаа. Тэгээд гишүүд маань саяын тайлбарыг сонссон хүмүүс маань тунгааж бодоод саналаа өгөхийг хүсье.

С.Бямбацогт: Ажлын хэсэг тайлбарлах уу? Сая нэлээн үндэслэл сонсогдож байна шүү дээ. Гүйцээн боловсруулах юм уу? Тийм ээ. Ажлын хэсэг. Г.Уянгахишиг гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

Г.Уянгахишиг: Энэ дээр бас нэг ойлголцлын зөрүү л гарч байх шиг байна.

Юу гэхээр яг энэ замын хөдөлгөөний дүрмээрээ 50 километр цаг хүртэлх хурдтай мопед бол өөрөө ямар ч ангилалгүйгээр 16 настай хүүхэд унаад явдаг ийм дүрэмтэй байгаа.

Тэгээд одоо энэ цахилгаан скүүтрийг мопедтой адилтгана гэж оруулдаг нь энэ цахилгаан скүүтэр унаад байгаа хүмүүс замын хөдөлгөөний дүрмийн зохицуулалт руу орох шаардлагатай гэж үзсэн учраас. Яг энэ дүрмийн зохицуулалтууд нь тусгайлан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль руу 13, 14-өөр шигтгэж оруулсан байсан.

Тэгэхээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль гэдэг болохоор өөрөө ерөнхийлөн зохицуулалтаа аваад явдаг. Замын хөдөлгөөний дүрэм бол яг тухайлан тэр дүрмийн зохицуулалтуудаа, ангиллаа аваад явдаг. Ямар ангилалдаа байх вэ, жолооч ямар үүрэгтэй байх вэ, аль эгнээгээр явах вэ, ямар тээврийн хэрэгсэл яаж явах вэ гэдгээ зохицуулдаг бичиг баримт.

Энэ утгаараа зөвхөн мопедынх нь зохицуулалтыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль руугаа оруулахаар тэгвэл нөгөө дүрэм дээр зохицуулсан мотоциклынхоо зохицуулалтыг оруулж ирэх, автомашиныхаа зохицуулалтыг оруулж ирэх, нөгөө ачааны машины чинь зохицуулалтыг оруулж ирэх бүх зохицуулалт чинь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиараа зохицуулалтаа авч явах ёстой болчихож байгаа байхгүй юу.

Тэгэхээр хуулийн техникийн хувьд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд ерөнхий зохицуулалтаа аваад, яг дүрэм дээр тодорхойлогдсон тодорхойлолтынхоо дагуу аваад явах юм бол энэ нь зөв явах юм байна гээд.

Яг 13, 14 дүгээр зүйл дээр хууль санаачлагчийн оруулж ирсэн зохицуулалтууд бүгд замын хөдөлгөөний дүрэм дээрээ байгаа буюу мопед, түүнтэй адилтгах гэж орж ирснээрээ яг замын хөдөлгөөний дүрмээ мөрдөөд явах “тээврийн хэрэгсэл” гэдэг утгаараа зохицуулалтад орох, “жолооч” гэдгээрээ эрх, үүргээ аваад явах энэ боломжууд нь бий болж байгаа юм.

Энэ сургалттай холбоотой дээр тийм янз бүрийн бизнес гэсэн юм ерөөсөө ажлын хэсэг дээр хэнийх нь ч толгойд ороогүй. Яг үнэндээ нэгэнт хэдийгээр 18-аас дээш нас ч гэсэн авто зам дээр унах болох юм бол тодорхой хэмжээнд дүрмийн мэдлэгтэй байх ёстой юм байна. Мопедын жолооч бол дүрмийн сургалтад суудаггүй, ангилал авдаггүй. Гэвчиг нэгэнт маш олноороо орж ирж байгаа бол сургалт байх ёстой юм байна гэдэг утгаар “сургалт” гэж орж ирсэн.

Тэгэхээр хэрвээ жишээлбэл гишүүдийн зүгээс, Байнгын хорооны зүгээс яг энэн дээр, сургалт биш юм, зөвхөн “А”-тай, “В”-тэй буюу яг замын сургалт, жолооны ангилал руу орно гэвэл бид хөндөөгүй учраас дүрэм руу бас оруулж чадахгүй.

Тийм учраас замын хөдөлгөөний дүрэмд дараа нь яг энэ өөрчлөлтийг тусгаад мопед унаж байгаа бол, скүүтэр унаж байгаа бол “А”, “В” ангилалтай

байна гэдэг зохицуулалтыг дүрмээрээ зохицуулах ёстой. Хууль дээр тэр зохицуулалт орж чадахгүй байхгүй юу.

С.Бямбацогт: Хоёр хүртэл гишүүн үг хэлэх ёстой. Ажлын хэсэг нэмж тайлбарлая. Б.Баасанжаргал гишүүн.

Б.Баасанжаргал: Бид нарт ерөөсөө хоёр, гуравхан сонголт байгаа юм.

Насанд хүрээгүй хүүхдүүдээ мопед унуулаад замын хөдөлгөөнд оруулах юм уу, явган хүний зам дээр явуулах юм уу гэдэг.

Явган хүний зам дээр явуулахгүй ээ. Явган хүнээ хамгийн түрүүнд хамгаалах ёстой гэдэг олон улсын дүрмийн дагуу явган хүнээ хамгаалъя гэхээр нөгөө хүүхдүүдийг бид авто зам руу оруулах гээд байгаа юм. Авто зам руу бид ямар ч сургалтад хамрагдаагүй, ямар ч хамгаалалтгүй, насанд хүрээгүй хүүхдүүдийг бид явган хүнээ хамгаалж байгаа гээд авто зам руу оруулахаар энэ чинь өөрөө дахиад эрсдэл үүснэ.

Тийм учраас 18 насанд хүрсэн хүн нэгдүгээрт энэ тээврийн хэрэгслийг жолоодно.

Хоёрдугаарт, нэгэнт автомашинуудтай зэрэгцээд замын хөдөлгөөнд орж байгаа учраас сургалт, үйл ажиллагаанд заавал хамрагдана гэж байгаа юм.

Үүнийг заавал бизнесийн байдлаар ч юм уу ингэж ойлгох шаардлагагүй. Яагаад гэвэл түрээсийн компаниуд өөрсдийнхөө аппликэйшнээр энэ үйлчилгээгээ явуулж байгаа. Апликэйшн дээрээ ядаж наад захын ойлголт өгөх сургалтуудаа оруулаад, тэрийгээ тестээ өгөөд, түүндээ тэнцсэн хүмүүстээ түрээслээд явах.

Хоёрдугаарт, замын маршрутаа яг техникийн шийдлээр шийдэх бүрэн боломжтой. Зориулалтын зам байхгүй газар мопед хэрвээ явах юм бол мопед нь өөрөө зогсдог, явах боломжгүй болдог гээд энэ техникийн шийдэл нь бүрэн боломжтой юм билээ.

Тэгэхээр энэ бүх эрсдэлийг тооцож үзэж байгаад хамгийн боломжит хувилбараар оруулж ирсэн. Энд ямарваа нэгэн бизнесийн ашиг сонирхол огтоосоо манай ажлын хэсэгт байгаагүй шүү гэдгийг хариуцлагатай хэлье.

Зүгээр ойлголтын зөрүү л байна. Хэрвээ ийм асуудал байсан бол манай ажлын хэсэгтэй уулзах, ярилцах бүрэн боломж байсан шүү. Дэмжээрэй гишүүд ээ. Одоо энэ асуудлыг зохицуулахгүй бол энэ чинь одоо бүр замбараагаа алдлаа шүү дээ.

С.Бямбацогт: Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэллээ. Ажлын хэсэг бас тайлбар хийлээ.

Сая уншсан. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 60 гишүүн дэмжиж, 63.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гэхдээ эцсийн хэлэлцүүлэг дээр сая Г.Лувсанжамц гишүүний хэлж байгаа тэр 50 километр цагийн хурдтай скүүтэр ороод ирвэл яах вэ. Улам эрсдэл нэмэгдэх үү. Энэ мэтээ зохицуулаарай, бас анхаараарай. Ажлын хэсэг эцсийн хэлэлцүүлэг дээрээ.

Дараагийн санал хураалт.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13^{1.1.2} дахь заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 69.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13^{1.2.2} дахь заалтын “цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг улсын бүртгэлд” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг” гэж өөрчилж, 13^{1.2.10}, 13^{1.2.11} дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13^{1.2.10.18} нас хүрээгүй хүүхэд болон энэ хуулийн 12^{1.3}-т заасан сургалтад хамрагдаж, бүртгүүлээгүй хүнийг нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах.

13^{1.2.11}.нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдах.”

Зөвхөн 18 нас хүрээгүй хүүхдийг эцэг, эхээс гадна тэр мопед, скүүтер түрээсэлж байгаа байгууллага бас хариуцлага хүлээх нь байна. Тийм үү? 18 нас хүрээгүй хүүхдээ. Ийм зохицуулалт гэж ойлгож байгаа. Зөв үү?

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 69.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13¹.2.9 дэх заалтын “, цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг зүй зохистой ашиглах хэрэглээний соёлыг эзэмшүүлэх” гэснийг болон 13¹.2.3, 13¹.2.4, 13¹.2.5, 13¹.2.6 дахь заалтыг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

Санал хураалтыг хүчингүй болголоо. Ажлын хэсгийн ахлагч Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ санал дээр гүйцээн боловсруулах.

С.Бямбацогт: Энэ санал хураалтыг хүчингүй болголоо. Гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэгт, Байнгын хороонд өглөө.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 68.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.12.“мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр, эсхүл хэд хэдэн дугуйтай тээврийн хэрэгслийг;

3.1.13.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг нийтэд төлбөртэйгээр ашиглуулах үйл ажиллагааг;

3.1.14.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч” гэж

өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг гэрээний үндсэн дээр хэрэглэгчид төлбөртэйгээр, тодорхой хугацаагаар ашиглуулах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг хуулийн этгээдийг.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.
/алх цохив/

95 гишүүн санал хураалтад оролцсоноос 66 гишүүн буюу 69.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “мопедоос” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээс” гэж, 3.1.11 дэх заалтын “мопед” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчилсүгэй.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.
/алх цохив/

95 гишүүн санал хураалтад оролцсоноос 60 гишүүн буюу 63.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.
/алх цохив/

95 гишүүн санал хураалтад оролцсоноос 63 гишүүн буюу 66.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 12¹.4 дэх хэсэг болон 3 дахь заалтын 13¹.2.11 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.
/алх цохив/

95 гишүүн санал хураалтад оролцсоноос 95 гишүүн буюу 98.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18 нас хүрээгүй хүүхэд 6 дугаар сарын 30-аас хойш мопед унахыг хориглож байна. Тийм үү? Скүүтер.

12.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

95 гишүүн санал хураалтад оролцсоноос 64 гишүүн буюу 67.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

ХОЁР.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “58, 59, 60, 61, 62, 63, 64 дахь” гэснийг “59, 60, 61 дэх” гэж өөрчилж, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 59 дэх хэсэг болгох:

“59.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодож явган хүний гарцаар зам хөндлөн гарсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

95 гишүүн санал хураалтад оролцож, 62 гишүүн буюу 65.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 62 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“62.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцсон арван найман нас хүрээгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Энд чинь нэмээд тэр түрээсэлж байгаа байгууллагаас 18 нас хүрээгүй хүүхдэд түрээсэлсэн бол хариуцлага хүлээхгүй юу? Хамтдаа орно биз дээ. Санал гаргасан ажлын хэсэг. Орох юм байна шүү. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

95 гишүүн санал хураалтад оролцсоноос 60 гишүүн буюу 63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 63.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.4.арван найман нас хүрээгүй хүүхэд болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2-т заасан сургалтад хамрагдаагүй хүнийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 60.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 59, 60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4, 63.5 дахь заалтыг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн ахлагч Г.Уянгахишиг гишүүнд микрофон өгье.

Г.Уянгахишиг: Энэ заалтыг гүйцээн боловсруулахаар.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулъя. Сайжруулах санал гаргаж байна. Хойшлууллаа. Санал хураалтыг. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

ГУРАВ.ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 58.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.
/алх цохив/

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.
/алх цохив/

**Долоо. “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

/Хог хаягдлын менежментийн санхүүжилтийн тогтолцоо, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах талаар/

Дараагийн асуудалдаа оръё. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 64.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг эцэслэн баталлаа.

Энэ хог хаягдлын менежмент, хог хаягдалтай холбоотой, аюултай хог хаягдал гээд энэ олон асуудлыг бас шийдсэн тогтоолыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос санал гаргаж, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхсоёл нарын гишүүд ажлын хэсэг ахалж ажилласан. Их чухал. Байгаль орчинд хог хаягдал маш том сөрөг нөлөөтэй байгаа. Үүнийг шийдэх чухал тогтоол батлагдсан. Засгийн газар хэрэгжилтийг хангах тал дээр онцгой анхаарч ажиллаарай.

Тогтоолын төслийг баталсан Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархлаа илэрхийлье. Г.Лувсанжамц гишүүн дэмжсэнээр, Б.Бат-Эрдэнэ гишүүн дэмжсэнээр тооцогдож байна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Найм. “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**
/Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл,
үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг
хангах талаар/

Дараагийн асуудалдаа оръё. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтдаа бэлтгэе, гишүүд ээ. Санал хураалтыг явуулъя. /алх цохив/

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя” гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Сурагчийн хүүхдийн үдийн хоолтой холбоотой чухал асуудал байгаа.

Санал хураалтад 95 гишүүн оролцоноос 61 гишүүн буюу 68.4 хувийн саналаар тогтоолын төслийг баталлаа.

Сургуулийн сурагчдын үдийн хоолны хүртээмжийг, чанарыг нэмэгдүүлэх ач холбогдолтой тогтоолыг манай Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хүсэлтүүд ирээд, Өргөдлийн байнгын хорооноос ажлын хэсэг байгуулагдаж, Б.Баасанжаргал гишүүн ахлуулж гараад ажилласан.

Одоо зөвхөн бага ангийн хүүхдүүд үдийн хоол идэж байгаа бол цаашдаа дунд анги, ахлах ангийн хүүхдүүд үдийн хоол иддэг болох, мөн үдийн хоолны агууламж, нөгөө калори, илчлэг нэмэгдэх ийм чухал ач холбогдолтой тогтоолыг Улсын Их Хурал баталлаа.

Тэгээд Б.Баасанжаргал нарын ажлын хэсэгтээ, Өргөдлийн байнгын хороо, баталсан Их Хурлын гишүүддээ талархлаа илэрхийлье ээ. /алга ташив/

Ес.Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл
/“Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон
батлах тухай хуулийн төслийг Засгийн газар
2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Дараагийн асуудалдаа оръё. Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Ж.Алдаржавхлан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас усан доорх соёлын өвийг хамгаалах, тогтвортой хадгалах зорилгоор 2001 онд Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенц батлан гаргасан.

Энэхүү конвенц нь 35 зүйл, дүрмээс бүрддэг бөгөөд конвенцын 1 дүгээр зүйл доод тал нь 100 жилийн турш хэсэгчлэн, эсвэл бүхэлдээ, тодорхой хугацааны туршид эсвэл байнгын усан доор байсан соёл, түүх эсвэл археологийн шинж чанартай хүний оролцоотой бүхий л ул мөрийг усан доорх соёлын өв гэж тодорхойлон түүнд археологи болон байгалийн орчинтой хамт байгаа дурсгалт газар, байгууламж, барилга, олдвор, хүний биеийн үлдэгдэл, археологи болон байгалийн орчинтой байгаа хөлөг онгоц, агаарын хөлөг, бусад төрлийн тээврийн хэрэгсэл, эсвэл тэдгээрийн аливаа хэсэг, ачаа, эсвэл бусад эд зүйлс, эртний түүхэнд хамаарах эд зүйлсийг хамруулахаар заасан байдаг.

Монгол Улсын хувьд далай тэнгист гарцгүй боловч нутаг дэвсгэрт орших том, жижиг нуур, гол усыг эртнээс шүтэж ирсэн уламжлалтай бөгөөд түүнд холбогдох зан үйл, ембүү, алт, мөнгөн сав, эд зүйлс өргөх явдал цөөнгүй байсан нь конвенцын 1 дүгээр зүйлд заасан усан доорх эд зүйлст хамаардаг.

Мөн Хөвсгөл зэрэг нуурт хуучны усан онгоц, завь зэрэг зүйлс хадгалагдан үлдсэн байдаг бөгөөд эдгээр нь цаг хугацаа өнгөрөх тусам соёлын өвийн шинжийг олж, үнэ цэнтэй болдог тул конвенцын тодорхойлолтод зааснаар дотоодын усан доорх соёлын өвд хамаарна.

Манай улсад усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас эд зүйлсийг хулгайлах, эвдэн сүйтгэх явдал гарсаар байна. Тухайлбал, 2018 онд Завхан аймгийн Отгон сумын нутагт Отгонтэнгэр хайрхны бэлд орших Балдархундага нуурын ёроолоос иргэд 366 ширхэг мөнгөн аяга хулгайлсныг хууль сахиулах байгууллага илрүүлж шалгасан.

Харамсалтай нь усан доорх соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчин байхгүйн улмаас шүүх эдгээр зүйлсийг орон нутгийн засаг захиргааны байгууллагад шилжүүлэн, мөнгийг нь ялган зах зээлийн үнээр худалдаж зарцуулсан байдаг.

Ийм тохиолдол бүр үндэсний соёлын өв, сан хөмрөгийн үнэ цэнт байдлыг дордуулж, өвийг оршин тогтнох чадваргүй болгон устаж үгүй болох үр дагавартай юм.

Цаашид энэ мэт тохиолдлоос урьдчилан сэргийлэх, дурсгалт зүйлсийг конвенцын зорилгын үүднээс илрүүлж бүртгэх, хадгалж хамгаалах, өмчилж эзэмших, зохистойгоор ашиглах үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгон, түүнтэй холбогдох харилцааг эрх зүйн хүрээнд зохицуулах асуудал тулгамдаж байна.

Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд хэлэлцүүлж өгөхийг хүсье.

С.Бямбацогт: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир танилцуулна.

Д.Бум-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий Бага хурлын 2001 оны 31 дүгээр чуулганаар баталсан Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон баталснаар усан доорх соёлын өвийг хамгаалах тогтолцоо бүрдэх, соёлын өвийн зүйлсийг дээрэмдэх, хууль бусаар зөөвөрлөх, арилжааны зорилгоор ашиглахаас хамгаалах, усан доорх археологийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн техникийн туслалцаа авах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг чухал ач холбогдолтой.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир дээрх конвенцод далайд гарцгүй улс орны хувьд чухал ач холбогдолтой талаар дурдаж, Монгол Улсад усан доорх археологийн дурсгалт газар, олдворууд байгаа эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар конвенцод нэгдэн орсноор дотоодын усан доорх соёлын өвийг хамгаалах төдийгүй соёлын өв хаана

байгаагаас үл хамааран өөрийн хил хязгаараас гадуурх ашиг сонирхлыг хамгаалахад оролцох эрхтэй болох талаар үг хэлсэн болно.

Хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувийн саналаар дэмжиж, эцэслэн батлуулахаар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөн хэлэлцүүлэхийг шийдвэрлэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, уг хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Д.Бум-Очир гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ж.Алдаржавхлан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Даваацэрэн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өв хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д зааснаар нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан Улсын Их Хуралд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулахыг хориглоно.

Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байдгийг бас Та бүхэнд сануулъя.

Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг Та бүхнээсээ хүсье.

Хууль санаачлагчийн илтгэл болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг 16.00 цагаас нэгтгээд явуулъя. 16.00 цагаас.

**Арав. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
гурав дахь хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудалдаа оръё. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Г.Лувсанжамц: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулах үед хуралдаан даргалагчаас зарчмын зөрүүтэй саналуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасныг үндэслэн хуралдаанд оролцсон гишүүд дараах асуултыг асууж хариулт авлаа.

- Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зарим санал давхардсан, төсвийн үр дагаврын хувьд зөрүүтэй саналуудыг нэгтгэх талаар тухайн санал гаргасан Улсын Их Хурлын гишүүдээс тодруулсан эсэх. Орон нутгийн шинж чанартай, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусаагүй Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зарчим, шаардлагад нийцээгүй хэдэн санал байгаа болон нийт саналуудын мөнгөн дүнгийн талаар.
-

- Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгахаар ажлын хэсгээс танилцуулж буй нийт 88 зарчмын зөрүүтэй саналаар хөгжлийн төлөвлөгөөний төсөвт өртөг 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр байгаатай холбогдуулан тус төслүүдийг бодитоор хэрэгжүүлэх төсвийн боломж, эх үүсвэр бий эсэх, хэрэгжилтийг бодитой хэмжих нөхцөл бүрдэх эсэх талаар.
- Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд хуульд заасан шаардлага хангахгүй байгаа саналуудын талаар ажлын хэсгийн зүгээс тухайн саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулсантай холбогдуулан энэ дүгнэлт нь үндэслэлтэй эсэх, Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр ирүүлсэн саналуудын үр дүнд хөгжлийн төлөвлөгөөний төсөвт өртөг 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр байгаатай холбогдуулан 2027 онд шинээр хэрэгжүүлэхээр тусгаж буй төсөл, арга хэмжээнүүдийн нийт төсөв санхүүжилтийн хэрэгцээг бодитоор тооцсон эсэх, Төсвийн тухай хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн уялдаа сул байгаагаас хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгах боломж хязгаарлагдаж байгаа болон эдгээр хуулийн зохицуулалтыг шинэчлэх, уялдуулах талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийн талаар.
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа талаар дурдаад, Засгийн газраас тэргүүлэх чиглэлээ тодорхойж энэ дагуу Улсын Их Хурлын гишүүдээс санал авдаг байх талаар.
- Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгуулахаар гаргаж буй саналууд нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох шаардлагад нийцсэн эсэх. Тухайлбал, Засгийн газрын бодлоготой уялдсан, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхой, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, магадлал нь батлагдсан төслүүдийн талаар дурдаад, жил бүрийн улсын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдэхээр төсөв тавигдаж, энэ хүрээнд зураг төсөв, магадлал нь хийгдэж, бэлтгэл ажил нь хангагдсан хэдэн төсөл арга хэмжээ байгаа, эдгээрээс улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд хэдэн төсөл, арга хэмжээ туссан, магадлал нь хийгдсэн, гурав дахь жил нь дууссан хэдэн төсөл, арга хэмжээ хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үлдэж байгаа талаар асуулт асууж, хэрэгжүүлэхгүй үлдэж буй төслүүдэд төсвийн хөрөнгөөр зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан гүйцээн боловсруулж, холбогдох хуультай уялдуулахаар чиглэл өгч, Байнгын хорооны гурав дахь хэлэлцүүлэгт шилжүүлсэн 203 зарчмын зөрүүтэй саналыг Улсын Их Хурлын даргын 2026 оны 194 дүгээр захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн зүгээс тухайн саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүдэд нь танилцуулахад нийт 115 саналыг хураалгах, хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзсэн.

Ажлын хэсэг 2026 оны 5 сарын 25-ны өдөр хуралдаж, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдэж, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулагдсан 43 саналыг холбогдох хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар дахин санал хураах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдээгүй саналуудыг дахин хэлэлцэх, санал хураах шаардлагагүй гэж тогтсон.

Энэ хүрээнд чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулагдсан 43 саналыг нэг бүрчлэн хэлэлцэж, ажлын хэсгийн зүгээс 12 зарчмын зөрүүтэй Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж санал хураалгах, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан 76 зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж, нийт 88 саналаас хуульд заасан шаардлага хангаагүй 11 саналыг хураахаас татгалзаж, 50 саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Г.Лувсанжамц гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Н.Учрал Монгол Улсын Ерөнхий сайд, Ж.Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Т.Доржханд Монгол Улсын Шадар сайд, Б.Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, З.Мэндсайхан Сангийн сайд, С.Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Ц.Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,

Л.Энх-Амгалан Боловсролын сайд, Ж.Алдаржавхлан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Э.Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Ч.Номин Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Б.Найдалаа Эрчим хүчний сайд, Э.Батшугар Эрүүл мэндийн сайд, С.Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Б.Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Батбямба Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Л.Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ш.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Т.Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, А.Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Б.Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Б.Мягмарнаран хаана байна? Өчигдөр бас байхгүй байсан. Ирвэл ир, ирэхгүй бол ажлаа өг.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцох үүрэгтэй.

Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Н.Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Энэ ажлын хэсэгт ирэх хүмүүс нь ирсэн юм уу?

Б.Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Б.Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Л.Наранчимэг “Эрдэнэс Монгол” компанийн Эрсдэлийн удирдлага, хяналтын газрын дарга, А.Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Д.Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Т.Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, М.Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга, Б.Бадамжав Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ц.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Ю.Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр,

нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Ж.Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Л.Баянзул Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Урьболд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Туяа Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, З.Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, П.Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогыг хэлтсийн дарга, Д.Энхтөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль эрх зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга, Н.Отгонбаяр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Ажлын хэсгийн гишүүддээ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол, тайлбар өгөхөөс татгалзсан бол, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол Улсын Их Хурлыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг болохыг сануулъя.

Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандахыг Та бүхнээсээ хүсье.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Р.Сэддорж, Д.Рэгдэл гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа. А.Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Асуулт ч юу байх вэ дээ. Ер нь юу болсныг л ярья.

Өнгөрсөн Баасан гарагт бүгдээрээ чиглэл аваад, ажлын хэсэг даалгавар аваад ажиллалаа.

Тэгээд ажлын хэсгийн дарга маань өөрөө ажлын хэсгээ ахалж байж нэг долоо хоног гадагшаагаа явчхаад ирчихээд, чуулганы уур амьсгалаа ч мэдрээгүй,

эхний ажлын өдөр баахан гишүүдтэй уулзаж, “за тэрийгээ татчих, тэрийг чинь оруулчихъя” гэж баахан тохироо наймаа хийлээ.

Багаасаа миний дүү ийм юм сурч болохгүй шүү гэж хэллээ. Тэгээд ажлын хэсэг дээрээ базсаар байгаад зарим гишүүд нь ажлаа хийхгүй, хурлаа тохирсондоо байсангүй гэж хаяж явцгаагаад.

Тэгээд 12 санал болгож базсан байдаг юм. Тэр 12 санал нь хүний эрхийн асуудлаар, хүүхдүүдийн эрхийн асуудлаар, хүүхдийн хоол, эрчим хүч гээд 400 тэрбум төгрөгийн нийтлэг асуудлуудыг базаж 12 санал болгов.

Эдийн засгийн байнгын хороон дээр орлоо. Эдийн засгийн байнгын хороон дээр ажлын хэсгийн саналаар санал хураасангүй. Нийт нөгөө саналуудаараа хураалаа.

Ингэхдээ яг л нөгөө зарчмаараа хүчтэй нь, тэгээд нөгөө бүлэглэлээрээ өөрсдийнхөө асуудлуудыг оруулав.

Ажлын хэсэг 400 тэрбум барьсан бол Эдийн засгийн байнгын хороо 1.4 их наяд төгрөг болголоо. Мэдээж санал нь ороогүй гишүүд бол мэдээж гомдолтой байгаа шүү дээ. Ойлгомжтой.

Орсон саналууд нь юу юм бэ, би тоймлоод хэлье.

- Чингэлтэй дүүрэг 3 санал,
- Сүхбаатар дүүрэг 4 санал,
- Дорнод аймаг 4 санал,
- Сүхбаатар аймаг 3 санал,
- Сэлэнгэ 2 санал,
- Дархан 3 санал,
- Хөвсгөл 3 санал,
- Төв 1 санал,
- Өмнөговь 1 санал,
- Увс аймгийн Малчин сум, Ховд, Завхан ийм асуудлуудыг оруулж ирсэн байна.

Оруулж ирсэн асуудлууд нь. 2 минут байна даа. Ярьчихъя. Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг Чингэлтэй, Сүхбаатар нэг тойрог шүү дээ. Ингээд 7 төсөл оруулж ирэв.

2 цэцэрлэг, залуу техникчдийн ордон, эмнэлгийн тоног төхөөрөмж, жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн эх үүсвэр, эрчим хүчний зарим асуудал, эмнэлэг.

Дорнод 4 төсөл. Ус хангамж, ариутгал татуурга, цахилгаан, зам. Сүхбаатар аймаг одоо бас зам. 3 төсөл оруулж ирж байгаа шүү.

Сэлэнгэ, Дархан, Төв, Хөвсгөл эд юу оруулсан бэ гэхээр 20 ортой эрүүл мэндийн төв, зам, гүүрийн байгууламж, ахмадын хөгжлийн төв, Гал түймэр унтраах, аврах 55 дугаар ангийн өргөтгөлийн асуудал.

Өмнөговь дээр зам, Баянхонгор дээр зам, Увс аймгийн Малчин сум 320 хүүхдийн сургууль оруулжээ. Ховд, Завханы дунд бас ийм замын асуудал оруулжээ.

Үүнээс юу харагдаж байна вэ гэхээр цөөхөн хэдхэн гишүүд өөр өөрсдийнхөө тойргийн асуудлыг ингээд оруулав.

Манай Эдийн засгийн байнгын хорооны дарга тойргоос сонгогдсон залуу гишүүн бас тойргийнхоо сэтгэлгээнээсээ гарч чадаагүй байгаа нь аргагүй байгаад байгаа байхгүй юу даа.

Ер нь л ингээд тойргоос сонгогдсон хүмүүс сайд нар хийж байна, тойргоос сонгогдсон хүмүүс Байнгын хорооны дарга хийнэ гэх юм бол бүхий л асуудлуудыг тойрог руугаа чирэх нь ойлгомжтой.

Бид тойргийг хөгжүүлэх гээд байна уу, аль нэг сумыг хөгжүүлэх гээд байна уу, нийтлэг Монгол Улсаа хөгжүүлэх гээд байна уу гэдгийгээ ч ялгаж чадахгүй байгаад байна шүү дээ.

Ийм улсын хөгжлийн төлөвлөгөө байдаг юм уу. Би үүнийг л асуугаад байгаа байхгүй юу. Ер нь байна шүү дээ. Одоо энэ төсөв орж ирэхэд зарим талаараа Сангийн яамны ч гэсэн буруу шүү дээ. Хөгжлийн төлөвлөгөөнд оруулаагүй асуудлыг төсөвт оруулж ирэхгүй гээд зарим сул гишүүдэд хаалт болгодог юм байна. Хүчтэй нь ч яах вэ, тэгээд өөрсдийнхөө асуудлуудыг оруулдаг. Бүр болохоо байхаар чуулган дээрээ улаан, ногоон лаазаараа тэгээд огт сураггүй 105 төслийг ч гэсэн оруулж л байсан. Ингээд хүчтэй нь явдаг ийм байх юм бол энэ улс орон өнөөг хүртэл яах вэ. /минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Г.Лувсанжамц гишүүн. Эдийн засгийн байнгын хороо бас хариултаа бэлтгэж байгаарай.

Г.Лувсанжамц: Б.Ариунзаяа гишүүнтэй санал нэг байна. Нэг ажлын хэсэгтэй хамтран ажилласанд баярлалаа.

Таны хувьд ч гэсэн зарчмаа сайн бариад.

Нийт 203 санал Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан. Ажлын хэсэг дээр 12-ыг нь л дэмжсэн. Мэдээж Б.Ариунзаяа гишүүн болон Н.Наранбаатар ажлын хэсгийн дэд ахлагчтай хамтраад энэ зүйлүүдийгээ цэгцлээд явсан.

203 саналаар 4.3 их наяд төгрөгийн санал орж ирсэн. Хэрэгжүүлэх боломж байхгүй ээ гэдэг зүйлүүд бас харсан. Хэлэлцсэн.

12 саналаар 400 тэрбум болгож багасгасан. Өнгөрсөн жил 138 санал гараад, эндээс 40 санал нь ажлын хэсэг дээр дэмжигдээд 1.4 их наядар улсын төсвөөр хэрэгжүүлнэ гэж тусаж байсан.

Тэгэхээр өнгөрсөн жилийн ажлын хэсэгт би бас ажиллаж байсан. Тэгээд тэр туршлага дээрээ үндсэлээд энэ жилд нэлээн сайн зарчмаа барьж ажиллаж чадсан болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт, гадаад томилолттой байж байгаад долоо хоног байж чадаагүй ээ. Эндээ хүлцэл өчье. Гэхдээ юун төлөө 126 гишүүнтэй, ажлын хэсэгт 15 гишүүнтэй билээ. Нэг гишүүн ажлаараа явж болно. Орны хүмүүс нь ажлаа гүйцээгээд хийх ёстой болов уу гэж бодож байна.

Гуравдугаарт, бүх гишүүдтэй уулзаад наймаа хийсэн гэсэн зүйлийг Та хөндлөө. Тийм зүйл байхгүй. Ажил хэрэгч байдлаар санал гаргасан гишүүдтэй уулзаад зураг төсөл нь байна уу, ТЭЗҮ нь байна уу, хэрэгжүүлэх боломж нь байгаа юм уу гэдэг зүйлүүдийг Эдийн засгийн яам болон Сангийн яамнаас тайлбарыг нь авсны үндсэн дээр нэг бүрчлэн уулзаж ярилцсан.

Ажил хэрэгч байдлаар ажилласан гэж би бодож байна. Тэгээд 12 саналаар оруулж байгаа ажлын хэсгийн ажлыг би сайн ажилласан болов уу гэж дүгнэж байгаа.

Нийтдээ 94 хувийг нь хассан гэсэн үг. 6 хувь нь л орсон.

Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжигдсэн 37 санал байгаа. Тэгээд энэ дээр Эдийн засгийн байнгын хорооны дарга хариулна байх аа.

С.Бямбацогт: Б.Заяабал дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга нэмж хариулъя.

Б.Заяабал: Баярлалаа. Б.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсэг Улсын Их Хурлын даргын захирамжаар Байнгын хороодын дундын асуудал учраас 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг захирамжаараа байгуулж ажилласан. Ажлын хэсэг маш сайн ажилласан гэж ингэж үзэж байгаа. Байнгын хорооны даргын хувьд.

203 санал орж ирсэн. Эндээс Байнгын хороон дээр санал хураалгахаар нийт 88 санал орж ирсэн байгаа. Ажлын хэсгээс дэмжигдсэн 12 санал, бусад санал нь ажлын хэсэг дээр дэмжигдээгүй санал гэсэн томъёоллоор оруулж ирсэн.

Сая ажлын хэсгийн дарга Г.Лувсанжамц гишүүн хэлж байна. 203 санал ирсэн. Ингээд ажлын хэсэг тэнд гишүүдтэй уулзаж хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар танилцуулга, бас мэдээлэл өмнөх хуралдаан дээр хэлсэн асуудлаар... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. Б.Заяабал дарга.

Б.Заяабал: Ингээд гишүүд гаргасан саналаараа санал хураалгахгүй гэсэн саналыг гаргасан байдаг.

Ингээд Байнгын хорооны хурал дээр 88 санал орж ирсэн. Саныг хураалгах явцад бас энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай нийцэж байна уу, ялангуяа энэ 6.10 дээр байгаад байгаа юм.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, нийслэлийн хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр.

6.10.2 дээр нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлсон эсэх, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь байгаа эсэх гэсэн шаардлагуудыг хангасан байх ёстой гээд заасан.

Хуралдааны дэгийн тухай хуулийн 13.2 дээр эдгээр тухайн хуулиар тогтоосон журам зөрчигдсөн бол санал хураалт явуулахыг хориглоно гэсэн.

Ингээд Байнгын хорооны хурал дээр ажлын хэсэг буюу Засгийн газраас, дээрээс нь ажлын хэсэгт орсон гишүүдээс, санал гаргасан гишүүдээс хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар саналыг нь асуугаад, санал нь нийцсэн гэсэн саналыг... /минут дуусав/

С.Бямбацогт: А.Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Ингээд шинэ, хуучин, анх удаа сонгогдсон, тойргоос сонгогдсон, жагсаалтаар сонгогдсон гэдэг гишүүдээс үл хамаардаг юм байна гэдгийг ер нь иргэд харж байгаа байх.

Ер нь аливаа асуудлыг хөгжлийн том цогцоор нь харах ёстой гэж би боддог.

Ийм ч учраас зарчмаа ярьж байгаа. Улсын хөгжлийн төлөвлөгөөнд аль нэг тойргийн асуудлыг жижиглэж оруулж болохгүй. Улс орноо хөгжүүлэх гэж байгаа бол томоор нь, цогцоор нь нийт ард түмнийхээ амьдралыг харах ёстой. Ийм учраас энэ жилийн төлөвлөгөөг угаасаа ийм байдлаар баталж явах нь угаасаа буруу байгаа учраас Засгийн газар эсвэл үүнийгээ татаж авах, эсвэл энэ төслийг батлахгүй байхыг гишүүддээ уриалж байна.

Энэ төсөлд одоо орж ирж байгаа асуудлууд төсөвт ороод, эдгээр аймаг, эдгээр сумд хөгжих юм байна. Бусад аймаг, бусад сумд хөгжихгүй байна гэдэг ойлголтыг бид өгч болохгүй.

С.Бямбацогт: Эдийн засгийн байнгын хорооны дарга хариулья.

Батлахгүй бол юу болохыг бас хариулаарай.

Б.Заяаболд: Гишүүдийн бүрэн эрхийн дагуу санал гаргах эрх нь гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Энэ ч агуулгаар 203 санал гарсан.

Энэ дээр мэдээж тойрогтоо гишүүд тойрогтойгоо холбоотой саналууд, дээрээс нь нийтийн эрх ашгийг хангасан холбоотой саналууд, нэлээдгүй саналууд гарсан.

Манай Р.Сэддорж гишүүн гэхэд жишээлбэл яг нийт хүүхдүүдийн үдийн хоолтой холбоотой санал гэх мэтчилэн тухайлсан тойргийн биш, нийт улс эх орны шинж чанартай. Д.Ганмаа гишүүн гэхэд нийт улс эх орны эрх ашигтай холбоотой, эрүүл мэндтэй холбоотой саналуудыг жишээлбэл гаргаж байсан байгаа гэдгийг хэлье.

Ер нь манай Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль дээр байгаа 6.10.2 дахь заалт. Эндээс болж гишүүд нэлээдгүй маргаан үүсгээд байгаа юм. Энэ санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлсон байх, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн байх гэдгээсээ болоод энэ асуудал үүсээд байгаа.

Өнгөрсөн жилийн төсөв дээр бас энэ жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй бол улсын төсөв дээр тавих шаардлагыг хангахгүй гэж үзнэ гэсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүд энэ жилийн төлөвлөгөө дээр суулгах талаар нэлээдгүй санал ирсэн.

Энэ дээр Улсын Их Хурлын даргын 2025 оны 523 дугаар захирамжаар ажлын хэсэг гарсан байгаа юм билээ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль дээр. Энэ дээр ажлын хэсгийн зүгээс үнэлгээ хийлгэж байгаа.

Ерөнхийдөө цаашда бид жилийн хөгжлийн төлөвлөгөө дээрээ яг үр дүнгүүдээ тавьж байя. Тухайлсан салбарын үр дүнгүүдийг энэ хууль дээрээ тодорхой маш товчхон баталдаг ийм жилийн төлөвлөгөө болгоё. Яг энэ үр дүнд хүргэхийн төлөө ямар ажлуудыг яаж хийх вэ, ямар төсвийн эх үүсвэрээр хийх вэ, хувийн хөрөнгө оруулалтаар уу, гадаадын хөрөнгө оруулалтаар уу гэдэг асуудлыг Төсвийн тухай хуулийгаа ярих үедээ шийдээд явдаг ийм зарчим руу шилжих нь зөв юм байна гэдэг ийм байр суурийг бас энэ хуралдааныг ахалж байхад ойлгосон гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Төлөвлөгөө батлахгүй байх нь болох юм уу? Ажлын хэсгийн ахлагчид хариульъя.

Г.Лувсанжамц: Төлөвлөж байж төсөвлөнө. Зарцуулсан төсвөө хянаж, үнэлгээгээ хийгээд татвар төлөгчдийн мөнгийг бид үр дүндээ зарцуулж чадаж байна уу, үгүй юу гэдгээ л харах ёстой. Ингэж байж бид үр дүнд суурилсан удирдлага, үр дүнд суурилсан засаглалыг бий болгох боломжтой.

Тэгэхээр төлөвлөгөө хэрэгтэй. Агуулгын хувьд засах шаардлагатай гэдэг дээр Б.Ариунзаяа гишүүнтэй санал нэг байгаа.

Ажлын хэсгийг ахлаад миний бие Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн өөрчлөх нэг төсөл дээр ажиллаж байгаа. Энэ агуулга дээр нь улсын төсвийн хөрөнгийг зарцуулах зүйлийг хөгжлийн төлөвлөгөө дээр тусгахгүй.

Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад зээл тусламж, хамгийн гол нь гаднын хөрөнгө оруулалт гэсэн энэ гурван зүйлийг тусгаад явъя.

Улсын төсвөөр зарцуулах гэж байгаа төслүүд нь байх юм бол төсөв дээрээ тусгаад явдаг байя гэсэн ийм үзэл баримтлалыг боловсруулаад явж байгаа. Ойрын хугацаанд өргөн бариад энэ асуудлыг засахаар ажиллаж байгаа.

С.Бямбацогт: Тэгэхээр хуулийг хэрэгжүүлэх ёстой. Засгийн газар.

Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн хууль дээдэлнэ гэж тангараг өргөдөг. Нэгэнт баталсан хуулиа хэрэгжүүлэх нь бидний үүрэг. Одоо төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө хоёрыг 6 сарын 01-ний дотор батлах үүрэгтэй. Бид хэд. Улсын Их Хурал.

6 сарын 01-ний дотор төсвийн хүрээний мэдэгдлээ баталж чадахгүй бол, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө баталж чадахгүй бол дараа нь бид төсвөө баталж чадахгүй. Дагаад бусад олон хуулиудыг баталж чадахгүй болно.

Тийм болохоор бид улсын төсвөө баталж чадахгүй бол аймаг, орон нутгийн төсвөө баталж чадахгүй болно. Ингээд төсвөө батлахгүй байгаад байвал энэ чинь ерөөсөө эцэстээ Улсын Их Хурал чинь өөрөө тарах асуудал болно шүү дээ. Нөхөд өө.

Тийм болохоор бид 2027 оны төсвийн суурь нь болж байгаа Хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдлээ хугацаанд нь баталж байж энэ Улсын Их Хурлын чинь өөрийнх нь чадамжтай байх, чадамжгүй байх асуудал яригдах болно шүү.

Тийм болохоор гишүүд үүнийг энэ талаас нь бодож ойлгох хэрэгтэй. Тэгэхгүй хуулиа хэрэгжүүлэхгүй ээ, төлөвлөгөө батлахгүй ээ, төсвийн хүрээний мэдэгдлээ батлахгүй ээ гэж ярих нь цаашдаа маш их үр дагавартай гэдгийг ойлгоцгоогоорой.

Б.Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь 126 гишүүнтэй боллоо гэдэг илүү давуу тал нь болно гэж бодсон. Гэвч харамсалтай нь сүүлийн үеийн гишүүдийн гаргаж байгаа саналууд, хуулиуд ер нь бол тийм нэг жалгын, дээрээс нь нэг хэсэг бүлэг хүмүүст зориулсан хуулиуд их баталж байна л даа. Өргөн барьж байна. Тэгээд тэрнийгээ зүтгүүлж байна.

Тэгээд сая хүүхдийг дэмжих тухай хууль гээд тэгж байна. Тэгтэл Ирээдүйн өв сангаас 120 тэрбум, 180 тэрбумыг гаргана гээд л ороод ирж байх жишээтэй. Ийм байдлаар олон гишүүд ийм хууль санаачлаад явах юм бол хэцүү л дээ.

Тэгэхээр одоо ингээд Их Хурлын гишүүд тойрог дээрээ санал авахын тулд 203 хүн 2.9 их наяд төгрөгийн санал гаргаад явж байгаа шүү дээ. Үүнийг чинь татвар төлөгч нар дийлэхгүй шүү дээ.

Тэгээд сая буцаагаад буулгаад 49 санал болгосон чинь тэр нь дахиад л 2.9 их наяд төгрөгийн зардалтай байх жишээтэй.

Энэ чинь хүмүүс хөлс хүчээ бүгдийг нь баран зүтгэн зүтгэн, хамаг тэр хүмүүсийнхээ цалинг хасан барин, өөрсдийнхөө үр хүүхдүүдийнхээ иддэг хоолноос хасан барин л тэр бүх татварыг чинь төлж байгаа шүү дээ.

Гэтэл дураараа ийм саналууд гаргаад л, тэгээд тэр нь дахин дэвших, дахин сонгогдох ийм хэрэгсэл болоод явж байна гэдэг чинь болохгүй л дээ.

Ер нь энэ хөгжлийн төлөвлөгөө гээд л жил болгон явдаг юм. Би нэг ч санал өгч байгаагүй. Урьд нь ч өгч байгаагүй. Энэ жил ч өгөөгүй. Нэг хүслийн жагсаалт тавьдаг. Тэгээд эрх баригч нар өөрсдийнхөө намын гишүүдийн юмнуудыг л бүгдийг нь тавьдаг. Сөрөг хүчнийхээ болохоор хасаад хаядаг. Тэрийгээ намар төсөв дээр ороод ирдэг юм уу гэхээр бас орж ирдэггүй.

Тэгээд түрүүн санал нь унаад байх шиг байна. Одоо төсвийн хүрээний мэдэгдэл гээд. Жилд 4 өөрчлөлт байна шүү дээ. 4 өөрчлөлт хийгээд. Ийм л баримт байгаа. Тэрийг унагаасан ч яалаа, унагаагаад ч яалаа. Ийм л юмнууд байгаа юм.

Цаана чинь татварын дарамттай. Та нар 9 төрлийн татвар нэмсэн. 3 төрлийн татвар шинээр бий болгосон. Өчнөөн олон арван хураамж, төлбөр, бүх

зүйлийг нэмсэн. Энэ бүх зүйл чинь аж ахуйн нэгжүүд, тэр хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн нуруун дээр асар их дарамт болж байгаа шүү дээ.

Тэрийг үл ойшоон тэгээд энд хэдэн нөхдүүд суучхаад л дур дураараа төсвийн зардлыг нэмэх санал гаргаад л, тэгээд ямар ч үнээр хамаагүй 2028 онд ялна гэдэг ийм л юмыг хийгээд сууж байна гэдэг чинь үнэхээр эмгэнэл юм.

Барааны үнэ яаж өсөж байна. Энэ хүмүүс яаж амьдарч байна, цалин тэтгэвэр ямар бага байна. Үүнийг та нар ер нь ойлгодог юм уу. Ард иргэдтэй уулзалт хийж байгаа юм уу.

Сая би тэр Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Рашаант гурван сумаар явж би уулзалт хийсэн. Ямар их уур уцаартай байна тэр хүмүүс. Үүнийгээ та нар мэдэрдэг юм уу. Ингэчхээд тэгээд ард түмний өмнө сайхан, сайн сайхан амьдруулна гэж хэлчхээд л, тэгээд л та нар цаагуураа хүмүүсийн, татвар төлөгчдийн мөнгийг ингээд л үр дүнгүй ашиглаад байх юм уу. Ингэж улс орныг удирддаг юм уу. Уралдаж идэх ийм бүх зүйлээ төсвөөр дамжуулж хийдгийг чинь бид мэднэ шүү дээ.

Тэгээд цаана нь очоод тендер дээр нь хувааж иддэг. Ийм л бүх зүйлийг хийж байгаа шүү дээ. Энэ идэж уудаг юмныхаа эхийг нь өнөөдөр тавьж байгаа шүү дээ.

С.Бямбацогт: Үг хэллээ. С.Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Хэдэн жилийн өмнө Япон хүний хийсэн “Пүүжээ” гээд киног та бүхэн санаж байгаа байх.

Төв аймгийн Баянчандмань сум дээр нэг охиныг эргэдэг байсан. Тэгээд нэг удаа ирсэн чинь тэр охин яг Баянчандмань сумын дундуур зам гарч яваад автомашинд дайруулсан.

Өнөөдөр яг Монгол Улсад яаж байна гэхээр жилдээ 500-аас дээш хүмүүс зам тээврийн ослоор амь насаа алдаж байна. Статистик. Нийслэл рүү хоёр жилийн өмнө явуулсан. Хүний эрхийн дэд хорооны даргаар ажиллаж байхдаа энэ чиглэлээрх маш олон судалгаа хийсэн.

Өнөөдөр Монгол Улсын 330 сумаас 20 гаруй сум нь яг дундуур нь төв зам дамжин өнгөрч байгаа. Асар өндөр эрсдэлтэй байгаа.

Энэ бол үндэсний аюулгүй байдал гэдэг чинь хүний аюулгүй байдал, хүний аюулгүй байдал гэдэг чинь хүүхдийн аюулгүй байдлаас ч гэсэн эхэлж байгаа.

Тийм учраас хөгжлийн хөтөлбөрт Баянчандмань сум зэрэг нийтдээ 16 сум дээр гүүрэн гарц тавих шаардлагатай байгаагийн эхнийхийг нь оруулж байгаа юм.

Энэ нэг тийм орон нутгийн шинж чанартай, тойргоо усалж байгаа зүйл гэж гуйвуулаад байж болохгүй. Яагаад гэхээр. Та хэд жоохон чимээгүй байж байгаач. Би нэг үг хэлээдэхье.

Тийм учраас яах вэ гэхээр Монгол хүний аюулгүй байдлын эрэмбэ, нөгөө өчигдөр Ж.Энхбаяр сайдад хэлээд байсан үндэсний аюулгүй байдалд төсөв маань нийцэж байгаа, үзэл баримтлалд төсөв маань нийцэж байгаа хөгжлийн хөтөлбөрүүд маань нийцэж байгаа эсэх дээр бид шалгуур тогтоох тухай асуудал байгаа юм.

Тийм учраас яаж байна гэхээр монгол хүний сая энэ сурон, скүүтэртэй холбоотой замын хууль ч гэсэн яг л ийм. Ер нь бид энэ зүй бусын стандарт байхгүйгээс, төр өөрөө энэ стандартаа хангаагүйгээс үүдэж иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирч байгаа зүйлийг бууруулах, энэ зүйлийг л бид анхан шатанд хийж хөрөнгө оруулалт руу оруулах ёстой болоод байгаа юм.

Өнөөдөр Улаанбаатар хотын хувьд ч гэсэн бас энэ асуудлыг бид Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал руу явуулсан. Зам тээврийн хамгийн их осол гараад байгаа 10 цэг. Гүүрэн гарц юм уу, нүхэн гарц хийхээр осол гэмтэл 6 хүн амь насаа алдаж байсан гарцын мөргөлт нэг болтлоо буурч байх жишээтэй.

Тийм учраас үүнийг Баянчандмань сум гэж ад үзээд байхгүй, Монголын жилдээ бүх хүмүүс л хойшоо босоо тэнхлэгээр энэ замаар дайрч өнгөрч байгаа.

Тийм учраас гэх мэтчилэн яг ийм эрүүл, аюулгүй байдалд иргэдээ амьдруулахад нь стандарт болсон зүйлүүд орж байгаа. Жишээлбэл, энэ 49 санал хураалттай сэдвийн 35 дээр нь ийм зүйл орж байгаа.

Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яам ч гэсэн уг нь боломж байвал яг иймэрхүү ямар стандартаар үүнийгээ оруулж байгаа гэдгээ тайлбарлаад явмаар байгаа юм. Энэ дотор алт ч бий байх, зомгол ч бий байх. Аль аль нь л бий байх.

Гэхдээ яг ямар шалгуураар энэ бүх зүйл даваад байгаа вэ гэдгээ иргэд, олон нийтдээ тайлбарлахгүй болохоор татвар төлөгчид төсвийн мөнгөөр дараагийн сонгуульдаа эрхтэй, чадалтай хүмүүс нь өөрийн тойрог, салбар луугаа татаж байна гэсэн ойлголт бас хэтэрхий давамгайлаад явчих вий.

Тийм зүйл ч байгаа, бас. Тийм утгаараа Монгол Улсад парламентын гаргаж байгаа шийдвэр гаргалт нь өөрөө 2024 оны 11 сарын 28-ны шийдвэрээр хүн төвтэй байх 5 шалгуурыг гаргасан.

Тэгэхээр одоо яг энэ 5 шалгуураараа л бид энэ төсөв дээр, хөгжлийн хөтөлбөр дээрээ хэмжүүр тавиад шийдвэрүүд гаргадаг болмоор байна.

Ингээд жишээлбэл Баянчандмань сумын Засаг дарга н.Ууганбилиг, хурлын дарга н.Энхболд, орлогч н.Анхбаяр, н.Оргил гээд. Эд нар яг тодорхой хүмүүс. Нийтдээ сумын төвийн 3 мянган хүний гарын үсэг цуглуулаад үүнийг ирүүлсэн.

Манай Баруунхараа дээр, Хонгор дээр, Баруунбүрэн дээр, Баян дээр, Эрдэнэ дээр, цаашлаад Баян сум дээр гээд. Улсын хэмжээнд байгаа бүх сумуудын энэ жагсаалтыг гаргаж байгаад бид үүнийг нэг форматаар зайлшгүй хийх ёстой байна.

Тийм учраас энэ жилийн хөгжлийн хөтөлбөр дээр зөвхөн нэг сум буюу Монгол Улсын хүн амын зорчих хөдөлгөөний зонхилох хувь явж байгаа дээр ийм юм хийж байгаа. Цаашлаад Эрдэнэсант ч гэдэг юм уу замуудад хиймээр байна.

Ер нь авто замыг сум тойруулж нэг километрийн зайтай тавьдаг байх стандартыг бас хэрэгжүүлмээр байна. Ийм үгийг хэлье.

С.Бямбацогт: Санал хэллээ. Д.Рэгдэл гишүүн асуултаа асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Өнөөдөр их чухал хууль батлагдах гээд орж ирж байна.

Тэгээд хоёр, гурван асуулт байгаа юм.

Нэгдүгээрт, ахмадын тэтгэврийн талаар хөгжлийн бодлого, төлөвлөгөөндөө ямар арга хэмжээ оруулж ирсэн юм бол оо? Нэг их тодорхой юм харагдахгүй байгаа. Ер нь.

Яагаад гэвэл өнөөдөр манай нийт тэтгэвэр авдаг ахмадуудын 70 шахам хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг. 800 мянган төгрөг хүрэхгүй. Энэ нь сүүлийн хоёр жилийн үнийн өсөлтөөс болоод хаана хаанаа хүрэхгүй болоод байгаа юм. Энэ дээр нэг тодорхой хариу хэлж өгнө үү.

Бас нэг хувийн нэмэлт тэтгэврийн асуудал сүүлийн үед нэлээн яригдаад байгаа.

Тэгэхээр зэрэг энэ хувийн нэмэлт тэтгэврийг 2025 оны түвшин “тэг” хувь юм уу? Ерөөсөө байхгүй гэсэн юм ороод ирэх юм.

Бид нарт тааралдаж байгаа мэдээ, материалаар болохоор хувийн нэмэгдэл тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тоо 2025, 2026 онд нэлээн нэмэгдэж байгаа ийм мэдээлэл байдаг. Энэ 2025 оны “тэг” хувь гэдэг чинь аль хэр үнэн юм бол? Энэ дээр нэг хариулт авмаар байна.

Төлөвлөгөөнд их аятайхан нэг тоо байгаа юм. Энэ тоо нь болохоор шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 0.72 гаруй хувьд хүргэнэ гэж байгаа юм. Их сайхан тоо. Үүнийг 2027 онд ямар ямар мөнгөөр, ямар ямар хөрөнгө оруулалтаар 0.72 хувь буюу 720, 730 тэрбум төгрөгт яаж хүргэх гэж байна вэ? Үүнийгээ хэлээд өгвөл манай шинжлэх ухааны салбарт их үнэтэй сайхан мэдээлэл болох байгаа юм.

Гурав дахь асуулт бол дэлхийн инновацын индекс гээд. Энэ манай Монгол Улсын хөгжлийн 2026-2030 оны үндсэн чиглэл дээр их олон индексээр төлөвлөгөөнийхөө хэрэгжилт, биелэлтийг үнэлдэг болгож орж ирснийг би зүй ёсоор үнэлж байгаа юм.

Тэгэхээр дэлхийн инновацын индексээр Монгол Улс маань 2020 онд 58 байснаа 2023 онд 68 болж, 10-аар нэмэгдээд, 2024 онд 78 болоод дахиад 10-аар хойшоо ухраад байгаа юм.

Тэгээд 2027 онд буцаагаад 62 болно гэж байгаа буюу 16 нэгж хувиар үүнийгээ сайжруулна гээд байгаа юм. Энэ нь одоо ер нь ямар үндэслэлтэй гаргасан тооцоо юм бол? Үүнийгээ тайлбарлаж өгөөч ээ.

Дөрөв дэх асуулт. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол 49 томъёолол орж ирж байгаа юм байна. Энэ дотор яг тоо хэлж өгөөч. Хуулийн зөрчилтэй орж ирсэн хэдэн санал байна вэ? Хуулийн зөрчилтэй. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтаар зураг байхгүй, төсөв байхгүй эсвэл хэрэгжүүлэх байршил байхгүй ийм саналуудын тоог хэлээд. Энд нь хэчнээн төгрөг шаардаад байгаа юм бэ гэдэгт нэг хариулж өгөөч. Ийм дөрвөн асуулт байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах вэ? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулъя.

Ж.Энхтөр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр байна.

Тэтгэврийн талаар гишүүний асуултад хариулъя.

Хувийн тэтгэврийн, нэмэлт тэтгэврийн тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа. Нийгмийн даатгалын ерөнхий болон бусад нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн талаарх хуулиуд дээр цогц өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулж, удахгүй Засгийн газар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр боловсруулж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Дараагийн асуултад.

Б.Мөнгөнсүх: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх. Гишүүний асуултад хариулъя.

Дэлхийн инновацын индекс болон Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нийтдээ 516 шалгуур үзүүлэлттэй, 4 түвшний үр дүнг тодорхойлж, хэмжих 516 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байдаг.

Үүний нэг үндэсний үр дүн нь Дэлхийн инновацын индексийн үзүүлэлт байгаа. Энэ 10 үр дүнгийн нэг Дэлхийн инновацын индексийг 62 дугаар байрт оруулахаар 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгаад байгаа. Үүний хүрээнд бодлогын үндсэн 8 гол хүрээг тодорхойлж байгаагийн нэг нь шинжлэх ухаан, технологи, инновацтай холбоотой бодлогын цөм хүрээг тодорхойлж энэхүү... /минут дуусав/

С.Бямбацогт: Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал хариулъя.

Б.Заяабал: Д.Рэгдэл гишүүний дөрөвдүгээр асуудал дээр хариулъя.

Зарчмын зөрүүтэй 49 санал орж иржээ. Ингээд хуулийн зөрчилтэй хэдэн санал байна вэ, хэчнээн төсөвт өртөг нь хэд байна вэ гэж.

Тэгэхээр Байнгын хороо хуралдаж байх хугацаанд чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хууль тогтоомжид нийцсэн санал дээр санал хураалтыг зохион байгуулна гэсэн дэгийн хуулийн заалттай. Энэ дагуу санал гаргасан гишүүн болон ажлын хэсэг буюу Засгийн газар, яамдаас хууль тогтоомжтой нийцсэн эсэх талаар тухай бүрд нь асууж, нийцсэн гэсэн санал дээр нийт 88 санал дээр санал хураалт явуулж, 49 санал нь дэмжигдсэн байгаа.

Тэгэхээр 49 саналын төсөвт өртөг нь 1.7 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 49 төсөл арга хэмжээ дэмжигдсэн гэсэн мэдээллийг өгье.

С.Бямбацогт: Д.Рэгдэл гишүүн тодруулж асууя.

Д.Рэгдэл: Б.Заяабал даргын хариултаас энэ саналууд хуулийн зөрчилгүй юм байна гэж ойлголоо. Зөв үү? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт:, миний гуравдахь асуултад хариулсангүй. Хоёр дахь асуудал, Эдийн засаг, хөгжлийн яамнаас дэлхийн инновацын индексээр нэлээн ажил хийх гэж байгаа юм байна.

Тэгэхээр дэлхийн инновацын индексийг бид үнэхээр ингэж 15, 16 нэгж пунктээр сайжруулж чадвал Монгол Улсын өрсөлдөх чадварын индекс төрөөс үнэхээр бодитой нөлөө үзүүлнэ. Энд нэлээн ажил шаардана.

Гурав дахь асуулт юу байсан гэхээр зэрэг шинжлэх ухаан, технологийн салбарын зардал маань дотоодын нийт бүтээгдэхүүний 0.72 хувь буюу 720, 730 тэрбум төгрөг болох нь. Үүнийг ямар ямар арга хэмжээнд хуваарилж байгаа юм бол? Энэ төлөвлөгөөг харахад хөрөнгө оруулалтаар ерөөсөө 19 тэрбум төгрөг л байна. Ердөө.

Урсгал зардал нь өнөөгийн түвшнээр бодох юм бол 70 орчим тэрбум болно. Тэгээд энэ хоёрыг чинь нийлээд үзэхээр чинь 90 тэрбум болоод байгаа юм.

С.Бямбацогт: Гүйцээгээд асууя. Д.Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Тэгээд дотоодын нийт бүтээгдэхүүнийг 720 тэрбум гэж бодвол энэ дээр 80 тэрбумыг төлөвлөгөөндөө тусгаад, тэгээд цаана нь байгаа 640 тэрбум төгрөг ямар ямар юм руу яаж хуваарилагдаж явах гээд байгаа юм бол? Эдийн засаг, хөгжлийн яам л хариулбал зүгээр байна.

С.Бямбацогт: Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ер нь цаашдаа шинжлэх ухааны салбарт хувийн салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх тэр боломж, эрх зүйг бүрдүүлэх шаардлага байгаа. Дан улсын төсвийн санхүүжилтээр хангалттай хэмжээний эх үүсвэр хуваарилагдахгүй байгаа.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад шинжлэх ухааны салбарын 19.4 тэрбум төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ нь юу вэ гэвэл шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбороо ашиглалтад оруулаад дуусгая.

- Хэрэглээний биотехнологийн төвийг ашиглалтад оруулах.
- Уламжлалт анагаах ухааны судалгаа, сургалт, үйлчилгээний зориулалттай цогцолборыг ашиглалтад оруулах.
- Технологи дамжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэсэн зорилго, хөтөлбөрүүд төлөвлөгөөнд орсон байгаа.

С.Бямбацогт: С.Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Их Хурлын дарга, эрхэм гишүүдийнхээ, ажлын хэсгийнхний өдрийн амгаланг айлтгая.

Ингээд бид мэдээж хэрэг хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэж байна.

Хөгжлийн төлөвлөгөөг Эдийн засгийн асуудал хариуцсан байнгын хороон дээр хөгжлийн эдийн засаг их сайн ойлгодог улсууд л мэдээж хэлэлцэж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Хөгжлийн эдийн засгийн хүрээнд л асуудлууд, шийдвэрүүд гарч байгаа байх. Надад хоёр асуулт байна.

Бид ингээд төсвөөр бүтээн байгуулалт хийе, хөрөнгө оруулалт хийе гэхээр зэрэг төсөв хүрэхгүй. Цаашдаа ч хүрэхгүй. Энд эргэлзэх зүйл байхгүй. Гаднаас зээл авдаг. Зээлээ ч ашиглаж чаддаггүй. Угаасаа хуулийн гацаануудтай.

Тэр битгий хэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийе гээд маш тодорхой төлөвлөгөөнд оруулсан байдаг. Тэрийгээ ч дэмждэггүй. Тэгэхээр бид яаж хөгжих вэ.

Тэр битгий хэл төр, хувийн хэвшлийн түншлэлийг яаж ажилладгийг ер нь гишүүд ойлгож байгаа юм байна уу. Би зориуд асуумаар байна. Би Эдийн засаг, хөгжлийн яамнаас нь асууя, сайдаас нь асууя. Энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр ямар загварууд дээр нь ямар төслүүд, ямар зорилтуудыг хангах вэ гэдэг дээр Та бүхэн биднийг мэдээжүүлэх ёстой юу гэсэн нэг асуулт байна.

- ▷ **Хоёр дахь асуулт.** Уг нь мал, малын эмийн дэвшилтэт технологийн үйлдвэр гэсэн санал орж ирсэн юм. Би үүнийг шинжлэх ухааны байгууллагуудтай ажиллаж байж тэндээс ирсэн санал л даа.

Өнгөрсөн жилийн манай дотоодын нийт бүтээгдэхүүний 2.4 хувийн өсөлт нь мал аж ахуйн салбараас. Энэ салбар өөрөө манай эдийн засгийг солонгоруулах гол салбаруудын нэг гэсэн ийм зорилтыг тавьсан. Салбар нь өөрөө 30 гаруй хувийн өсөлттэй. Тэгэхээр энэ эмнэлэг өөрөө их чухал. Энэ эмнэлэг байж байж энэ эмнэлгийн цаана бид жилдээ 10-аас 15 тэрбум долларыг гадагшаа дан ганц вакцин авахаар, эм авахаар гаргадаг юм билээ. Үүнийгээ дотооддоо хийнэ гэсэн зорилготой, оношлуурынхаа 30 хувийг дотооддоо хийнэ гэсэн зорилготой, вакцинаа бараг 100 хувь дотооддоо хийх бүрэн боломжтой. Патентууд нь бүгд манайханд байж байгаа.

Тэгээд үүнийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн загвараар хийнэ гээд оруулсан байсан чинь дэмжээгүй. Яагаад гэдгийг ерөөсөө ойлгоогүй. Хариулт байхгүй. Ерөөсөө ойлгож ядаад байна л даа. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж байгаа юм.

- ▷ **Гурав дахь асуулт.** Монгол Улсын эдийн засаг бүсийн эдийн засагтай болон дэлхийн эдийн засагтай интеграцлагдах ёстой. Нэгдэх ёстой. Тэрний гол зорилт нь бид “Боомтын сэргэлт” гээд тодорхой зорилт тавьсан. Боомтууд дээр ажлууд хийж байна.

Энэ дээр Цэнгэл болон Даянгийн чиглэлийн бас нэг авто замын асуудал байгаа юм. Энэ боомтын сэргэлтийн маш чухал нь. Цаана байж байгаа Хятадын 19 их наяд долларын эдийн засагтай бид олон сувгаар холбогдоно гээд зорилт тавьсан шүү дээ.

Төв Ази чинь 600 тэрбум ам.доллар боллоо. Үүнтэй холбогдоно гэсэн. Сая Ормузын хоолой дээр зөрчил бий болоход дайн бүхий байдал бий болсон. Үргэлжилж байна. Эндээс хамгийн эрсдэлгүй гарсан нь Хятад.

Яагаад гэвэл нөхдүүд тэр дундын коридорыг бий болгосон. Бүс ба замаар дамжуулаад бүх асуудлаа шийдсэн байж байгаа. Үүнтэй бид холбогдох ёстой шүү дээ. Дэлхийн эдийн засагтай. Тэгээд энэ чиглэлээр оруулж ирсэн саналыг бас мөн адил төр, хувийн хэвшлийн түншлэлээр гэсэн байгаа юм.

Энэ чинь –

- ▷ барь,
- ▷ ашигла,
- ▷ шилжүүл гэдэг загвартай шүү дээ.

Төсвөөс нэг ч төгрөг гарахгүй. Үүнийг яах гэж байгаа юм бэ? Та бүхэн хөгжлийн эдийн засгаа мэдэж байна уу, ойлгож байна уу? Энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн загваруудыг яаж хэрэгждэгийг нь ойлгож байна уу, мэдэж байна уу, уншиж байна уу? Ингэж бид улс орноо хөгжүүлнэ гэж бодож байгаа бол бид алдаж байна шүү гэж хэлэх гээд байгаа юм.

Тэр тусмаа хөгжлийн асуудал хариуцсан энэ яамыг чинь зориуд байгуулах ёстой гэж үзээд, үүнийг чинь Үндсэн хуулийн өөрчлөлттэй уялдсан байдлаар, Алсын хараатай уялдсан байдлаар бүр 2020 оны сонгуулийн дараа л үүнийг чинь бид яаравчилж байгуулсан шүү дээ.

Тэгээд байгуулсан шалтгаан нь юу гэхээр хөгжлийн бодлогын төлөвлөлтийг нэгдмэл болгоё гэсэн. Хуучирсан мөртлөө сайн туршлага шүү дээ. Тэгэхээр энэ дээр эхлээд би хариулт авмаар байна.

С.Бямбацогт: Эдийн засгийн хөгжлийн яам. Ж.Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: 2027 онд бид 1.15 их наяд гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийнэ. Үүнээс төсвийн боломж 2 их наяд гарвал байгаа. Бусад нь –

- ▷ гадаадын хөрөнгө оруулалт,
- ▷ хувийн хэвшил,
- ▷ төр, хувийн хэвшлийн түншлэл гэсэн хүрээнд гадаад зээл гэдгээр хэрэгжинэ.

Тэгэхээр гишүүд олон санал, их наядын санал гаргаж байгаа нь өөрөө 2027 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орох боломж үнэхээр бага байгаа.

Тэгэхээр санал гаргасан улсууд тэрийгээ бодолцоно биз.

Хоёрдугаарт, төр, хувийн хэвшлийн түншлэлээр бид нэгэнт төсвийн хөрөнгө оруулалтаар хөгжлийн хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх чадавх хязгаартай үед бид нөгөө талаасаа эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах бодлогын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бүхий л салбарт, хөрөнгө оруулалтад урамшуулж дэмжиж байгаа.

Нэн ялангуяа эрчим хүчний салбар, дэд бүтцийн салбаруудад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх санал, санаачилгыг дэмжиж, эрхийг нь олгож байгаа.

Үүгээр нэлээн томоохон асуудлуудыг шийдэхээр байгаа. Түрүүчээсээ эрчим хүчний хэд хэдэн төсөл, дэд бүтцийн хэд хэдэн төслүүд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлээд амжилттай явж байгаа.

Таны дурдсан биотехнологийн асуудал, биокомбинат. Манайх шиг ийм зэрлэг амьтан болон тэжээмэл олон сая малтай ийм улс орны хувьд биотехнологийг онцгой хөгжүүлэх ёстой. Энэ дотроо биокомбинатын чадавхыг нэмэгдүүлэх нь тэргүүлэх зорилтын нэг байгаа. Энэ бодлого Монгол Улсын нийгмийг хөгжүүлэх 2026-2030 оны төлөвлөгөөндөө нэлээн салбарын тэргүүлэх чиглэл гээд бодоод тусгаад явсан.

Та энэ дээр энэ жилийн юм туссангүй гэж асуудал ярьж байна. Энэ ерөнхий гол төлөвлөгөөндөө тусаад явсан. Үүнийг бид гадаад зээлээр шийдвэрлэхээр олон улсын байгууллагуудтай санал солилцоод ажиллаж байгаа. Үүнийг бид онцгой анхаарч хөгжүүлэх манай тэргүүлэх ийм үйлдвэр, салбар юм гэдгийг хэлэхийг хүсэж байна. Тэгэхээр энэ ажил орхигдохгүй.

Таны хэлсэнтэй санал нийлж байгаа онцгой чухал зүйл бол төлөвлөлт. Ер нь бид чинь эхлээд Их Хурлаар төсвийн хүрээ гарч ирж байна. Төсвийн хүрээгээр эдийн засгийнхаа, нийгмийнхээ чадавхыг бид тодорхойлно. Орлого, зарлагын боломж, хөрөнгө оруулалтын чадавхыг гаргана. Энэ дээрээ суурилад хөгжлийн хөтөлбөрөө оруулж ирнэ. Хөгжлийн хөтөлбөр батлагдсаны дараа төсөв Сангийн яам төсөв зохиож эхэлнэ. Төсвөө бид намар Их Хурал батлаад, тэгээд дараа нь аудит гүйцэтгэл хийгээд Их Хуралдаа тайлагнадаг ийм л 4 цикл шүү дээ.

Тэгэхээр зарим гишүүд үүнийг хийхгүй, батлахгүй байхыг ярьж байгаа нь бас жоохон учир дутагдалтай шүү. Ингэж болохгүй. Энэ Улсын Их Хурлын үндсэн үүрэг гэдэг талыг хэлэхийг хүсэж байна.

С.Бямбацогт: Б.Заяабал дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга хариульъя.

Б.Заяабал: Ер нь гишүүдээс гаргаж байгаа саналуудаас аваад үзэхэд ерөнхийдөө урьд өмнө нь төрийн, Засгийн газрын чинь бодлогын баримт бичигт нь туссан, Эдийн засаг, хөгжлийн яаман дээрээ техник, эдийн засгийн зураг төсвийнх нь мөнгө нь шийдэгдсэн. Тэгээд тэр зураг, төсөв нь хийгдээд, дээрээс нь бүр магадлал нь хийгдсэн тийм ажлууд нэлээдгүй байна лээ шүү дээ.

Гишүүд, яамдад энэ талын мэдээлэл байхгүй байна лээ. Тэгэнэд хуралдааны явцад гишүүдээс асуухад зарим гишүүд магадлал, зураг төслөө өөрөө шууд харуулж байгаа юм.

Тэгэхээр Засгийн газар дээрээ бодлогын уялдаануудыгаа зөв авч явахгүй бол үүнтэй чинь холбоотой асуудлууд үүсээд байна шүү гэсэн зүйлийг нэмж хэлье.

С.Бямбацогт: С.Зулпхар гишүүн тодруулж асууя.

С.Зулпхар: Баярлалаа. Энэ бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр цаашдаа бид явна. Бид төсвөөр юу ч хийж чадахгүй. Тэрийгээ ил тод хэлэлцээд эхэллээ шүү дээ.

Яах вэ, гэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр, гаднын хөрөнгө оруулалтаар, мэдээж хэрэг гаднын хөрөнгө оруулагчдын дэмжлэгээр бид эдийн засгаа томруулно. Тэгээд ирэхээр зэрэг төсөвт боломж гарна. Тэр үеийг хүлээхгүйгээр бид хийх ёстой ажлын нэг бол саяын мал аж ахуйн салбартай холбоотой Малын эмийн дэвшилтэт технологийн үйлдвэр байхгүй.

Гэхдээ үүнийг мөн адил төр, хувийн хэвшлийн түншлэлээр гэж оруулсан шүү дээ. Угаасаа уулзалт хийгээд явахад хүрээлэнгүүд патентаа гарга. Патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх нь угаасаа хувийн хэвшлийн оролцоо байна. Үүнийг тэгж хийдэг олон улсын жишгээр нь явъя гэсэн нэг ийм зүйл дээр тохирсон учраас үүнийг таван жилийн төлөвлөгөөнд орсон байхад нь нэг жилийнхээ төлөвлөгөөнөөс нь хасаад хаядаг нь өөрөө буруу байна гэсэн санал хэлж байгаа юм.

Дарга аа, 1 минутаа нэмээд авъя.

С.Бямбацогт: Гүйцээгээд асууя. С.Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Хоёр дахь асуудал бол тэр Даянгийн замын асуудал би сая үндэслэлүүдийг нь хэлсэн. Энэ дээр чинь тодорхой модель хийгээд тооцооллууд хийгээд үзсэн шүү дээ.

Одоо ингээд тээвэрлэлт чинь 60-аас 90 хоногт, заримдаа саатахаараа бүр 90 хоног болоод байгаа шүү дээ. Энэ тээвэрлэлтийн чинь дундын коридорт аваачиж холбоод, тэгээд энэ тээвэрлэлт Азиас Европ руу 14 хоногт явж байгаа

нь манай улсын хувьд 18-аас 21 хоногт болох энэ боломжийг л олгож байгаа шүү дээ. Үүний цаана чинь бүхэл бүтэн гадаад худалдааны том боломжууд нээгдэж байгаа. Түүнээс гадна дэлхийн эдийн засгаас хүртэх боломжийг нээж байгаа учраас энэ бас төр, хувийн хэвшлээр хийгдэх боломжтой төсөл учраас үүнийг та бүхэн оруулсан байсан бол араас нь хөөцөлдөөд холбогдох яам нь явах ёстой. Саналууд нь ч гарч байгаа шүү дээ. Үүнийг Та бүхэн дахиж хараач ээ гэж байгаа юм.

Би эдийн засгийн асуудал хариуцсан Байнгын хорооныхон үүнийг нарийн судалж байж, нэг бол саналыг нь асууж байж санал хураасан бол зөв байж дээ гэж байгаа юм. Төлөвлөгөөнд бас орсон байгаа шүү дээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Ж.Энхбаяр тодруулж хариулъя.

Ж.Энхбаяр: Ингээд хоёр талаасаа хамтраад төр, хэвшлийн түншлэлээр биокомбинатын шинэчлэл, био технологийн хөгжүүлэлтийн асуудлыг шийдэх бололцоотой.

Нэгэнт Улсын Их Хурлаар хуульчлан батлагдсан, таван жилийн төлөвлөгөөнд орсон тул үүнийгээ хийгээд явъя. Энэ дээр бид анхааралтай санаачлагатай ажиллая.

Тэр бүгд хуульд нийцсэн үү гэдэг дээр л учир дутагдлууд их байгаа шүү. Одоо ялангуяа жижиг зардлууд. Жижиг, дунд үйлдвэрлэл дэмжих тоног төхөөрөмж Чингэлтэй дүүрэгт 1 тэрбум гэх мэтийн саналууд их олноор орсон.

Одоо ингээд ахмадын хөгжлийн төвийн барилгын өргөтгөл. Нэг зүйл анхаарахгүй бол орон нутагт байгаа соёлын төвүүд маань салбарлаад гэр бүлийн төв, ахмадынх, эмэгтэйчүүдийнх, хүүхдийнх гээд ижил төстэй үйлчилгээ явуулдаг төвүүдийг олноор барьж эхэллээ.

Ингээд урсгал зардал чинь төсөв, төрийн үйлчилгээ, зардал нэмэгддэг, төр данхайлаа гэдэг. /минут дуусав/

С.Бямбацогт: Р.Сэддорж гишүүн асуултаа асууя.

Р.Сэддорж: Өдрийн мэнд хүргэе.

Бид хэд бүгдээрээ хэлэлцээд л байгаа. Энэ тийм ч буруу зүйл биш. Засгийн газар ч төлөвлөхдөө 100 хувь үнэмлэхүй сайн төлөвлөж үнэндээ чадахгүй.

Тойргийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүд ч буруу юм сэтгээд зүтгүүлээд байгаа юм биш. Бид тангараг өргөхдөө “Монголын ард түмний нийтлэг эрх ашгийн төлөө ажиллана” гэж тангараг өргөсөн байгаа.

Тэгээд Монгол Улсын эдийн засгийг бүрдүүлж байгаа хэдэн уурхай, үйлдвэр л байгаа. Тэр нь –

- “Оюу Толгой”,
- “Эрдэнэс Тавантолгой”,
- Нарийнсухайтын бүлэг ордууд,
- Таван толгойн бүлэг ордууд гээд.

Эд нар маань зогсвол юу болох вэ. Эд нар юун дээр тогтож явж байгаа вэ. Баяжуулах үйлдвэр, гүний ус дээр тогтож явж байгаа.

Тэгэхээр гүний усыг “Онги, Цагаанбургастай” гээд төслийг Монголын эрдэмтэд, усны эрдэмтэд бүгдээрээ олон 10 жил яриад тэгээд 2024 оны говиос сонгогдсон 7 гишүүн болон энэ 7 гишүүний манлайлал доор Улсын Их Хурлын гишүүд маань усны лобби бүлэгт нэгдээд энэ төслүүдийг оруулаад ир ээ, дэмжье гээд. Тэгээд усны эрдэмтэд маань, усны газар, Байгаль орчны яамныхан маань маш баяртай урам зоригтой энэ төслүүдээ хийж байгаа. Шалгарсан компаниуд нь сайн ажлаа хийж байгаа.

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороон дээр яагаад унасныг мэдэхгүй байна. Сая өнгөрсөн долоо хоногийн хурал дээр унасан гэж ойлголоо. Санал нь.

Тийм учраас эрхэм гишүүд минь энэ “Онги, Цагаанбургастай” хэмээх баяжуулж, нүүрс, зэс, алт угааж байгаа энэ гүний усыг хойч үедээ үлдээж гадагшаа урсаж байгаа гадаргын усаараа нуур хийгээд, гуравхан хувиар нь л нуур хийгээд тэгээд энэ говь руу татах энэ төслийг дэмжиж босгож өгөөч гэдгийг Та бүгдээсээ хичээнгүйлэн хүсье.

Энэ Монголын ард түмний нийтлэг эрх ашгийн үүднээс энэ санал явж байгаа шүү.

Өвөрхангай аймгийнхан усныхаа мөнгийг Өвөрхангай аймгийн төсөв 10, 10 тэрбумаар нэмэгдэх юм. Усны орлого гэж байна шүү дээ.

Хэнтий аймгийн төсөв хэдэн арван тэрбумаар нэмэгдэх юм. Энэ аймгууд чинь усаа эдийн засгийн эргэлтэд оруулах юм. Энэ саналыг эрхэм гишүүд маань Байнгын хороон дээр унасан саналыг босгож дэмжиж өгөөч ээ. Их Хурлын даргадаа хэлье. Үүнийг та нар анхааралтай. Энэ ингээд нэг жил л алдах юм бол улам цаашаа яваад байх юм.

Манай улс ядуу улс биш. Манай улс мөнгө төгрөгөө зарцуулж зарж чадахгүй байгаа, эрэмбэ дарааллаа олохгүй байгаа, юмаа эрэмбэлж чадахгүй байгаа ийм л улс. Аль ажлаа түрүүлж хийх вэ гэдгээ шийдэж чадахгүй байгаа ийм улс.

Тийм учраас цаашдаа яамд, энд байгаа ажлын хэсгийн хүмүүс бүгдээрээ яавал дараа жилийн энэ төлөвлөгөө дээр энэ ойлголцлууд улам ойлголцоод явах вэ, яавал Их Хурлын гишүүдийнхээ санаа бодолтой бүгд дотроо Монгол Улсынхаа талын юм бодоод байгаа шүү дээ.

Нэгдсэн байдлаар энэ төслөө оруулж ирэх үү гэдэг дээр Эдийн засгийн хөгжлийн яам, Засгийн газар улам сайн бодож ажиллах хэрэгтэй байна. Бид сургуулийн хүүхдүүдээ алагчлалгүйгээр үдийн цайг нь өгчхөөд, тэгээд санаа амар, ажлаа хийе гээд энэ жилээс яриад байгаа шүү дээ.

Энэ мөнгө чинь тийм их мөнгө биш. Бусад тэр зам юутай харьцуулахад. Нэг номерт... /минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Чинбаатарын Анар гишүүн асуултаа асууя.

Ч.Анар: “Хөгжлийн төлөвлөгөө” гээд нэртэй сүртэй сүртэй олон төлөвлөгөөнүүд энэ яамдыг махалж гаргаж байна.

“Хөгжлийн төлөвлөгөө” гэсэн мөртлөө төсөв дагасан хүслийн жагсаалт. Тэгээд

- ◆ “таван жил”,
- ◆ “Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”,
- ◆ “Алсын хараа-2050” гээд маш их төлөвлөлтүүдтэй.

Тэгээд хөгжлийн юм бол яг хөгжлийн байхгүй, дандаа нэг ийм аж ахуйн асуудлуудыг тойргийн гишүүд нь оруулж ирээд Монгол Улсын хөгжлийн биш, орон нутгийн ч юм уу, тойргийн асуудлууд нь ороод ирсэн.

Тэгээд энэ нь гишүүдийн буруу биш. Яагаад гэвэл тойргийн иргэдийн төлөөлөл учраас тухайн тойрогт байгаа асуудал. Гэхдээ Монгол Улсын хөгжлийг шийдэхгүй шүү дээ.

Тэгээд ийм нэг завхарсан юм яваад байдаг. Тэгээд нөгөө хүслийн жагсаалтад нь орохгүй бол төсөвт нь суутгадаггүй учраас гишүүд нь ажлын хэсгийн дарга, Байнгын хороодын дарга, Засгийн газраа, Эдийн засгийн яамаа лоббиддог.

Буцаагаад барьцаанд ордог. Хэн нь хэнийгээ лоббидоод хэн нь хэнийгээ барьцаанд ороод байгаа нь мэдэгдэхгүй.

Ийм баахан төлөлтүүд ямар хэрэг байгаа юм бэ?

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооны шинэ дарга, Г.Лувсанжамц гэсэн хоёроос, ажлын хэсгийн ахлагчаас асууя.

Яагаад вэ гэхээр хамгийн их үр дүнгүй байна, хоосон төлөвлөж байна гэж шүүмжилдэг байсан хоёр хүн хөгжлийн төлөвлөгөөг ахалж байгаа.

→ Тэгээд үнэхээр хэмжигдэхүйц байж чадаж байгаа юм уу? 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний үр дүнгийн дүгнэлтийг асуугаад ерөөсөө хариулт авч чаддаггүй.

Тэгэхээр та хоёр ажилласан учраас.

→ 2026 оны төлөвлөлтөд үр дүн байсан юм уу?
→ 2024, 2025 он?
→ Тэгээд энэ нь хэрэгждэггүй төлөвлөгөөн дээрээ хариуцлага нэхдэг тогтолцоо яаж үүсэх юм бэ?

Хоёрдугаарт, төсөв дагасан хүслийн жагсаалт оруулж ирж гишүүд нь ард иргэдийнхээ төлөөлөл болж байна гээд–

→ барьцаанд ордог асуудлыг яаж шийдэх юм бэ?
→ Сууриар нь яаж өөрчлөх юм бэ?
→ Энэ дээр ямар ч дорвитой шинэчлэлт хийх юм бэ?

Хэрвээ үнэхээр хөгжлийн төлөвлөгөө байх ёстой юм бол яамныхаа оруулж ирсэн юмаар л явъя л даа. Тэгэхгүй нэг замын засвар, дээврийн засвар гэж юм оруулж ирээд яваад байх юм. Тэр эрх мэдэл чинь Засгийн газар, орон нутагтаа байх ёстой биш юм уу? Хариуцлагыг хэнээс авдаг тогтолцоо байна уу?

Хоёрдугаарт, хуучин хэрэгжилт нь байна уу? Энэ олон төлөвлөгөө хэрэгтэй юм уу гэсэн гурван асуултыг ажлын хэсгийн дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга хоёроос асууя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Б.Заяабал дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга хариулъя.

Б.Заяабал: Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр жилийн төлөвлөгөө гээд үр дүнгүй төлөвлөгөөнүүд явж байна гэж ингэж шүүмжилдэг байсан гээд. Энэ дээр би санал нэг байна. Би өмнө нь ийм зүйл хэлдэг байсан.

Угаасаа төлөвлөж байгаа төрийн бодлогууд хэрэгжүүлэхийн тулд явах ёстой. Хэрэгжихүйц байх ёстой гэдэг нь үнэн.

Энэ удаагийн хөгжлийн бодлоготой холбоотой асуудлууд Монгол Улс энэ хөгжлийн бодлого, төлөвлөлт удирдлагын тухай хуулиар гурван янзын хугацааны бодлогууд байгаа.

- Урт хугацааны бодлого гээд “Алсын хараа-2050” байна.
- Дунд хугацааны бодлого гээд манайд маш олон баримт байна.

- 10 жилийн хөгжлийн хөтөлбөр байна.
- 5 жилийн хөгжлийн хөтөлбөр байна.
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр байна.
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гээд байна.

Дараа нь богино хугацааны хөтөлбөр гээд –

- жилийн төлөвлөгөө,
- тэгээд төсөв гээд байгаа.

Аудит энэ дээр хийгдсэн юм билээ. Өнгөрсөн онуудын аудитын дүгнэлтүүдийг нь би авч товч гүйлгэж харсан.

Энэ дээр юу гэж байна гэхээр –

- төлөвлөлт нь “хэрэгжихүйц бус төлөвлөсөн байна”.
- бодлогын баримт бичгүүд нь “хэтэрхий их давхацсан байна” –

-гэсэн дүн мэдээллүүдийг өгч байгаа юм.

Тэгээд энэ дээрээсээ үүдээд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийгаа эргэж харъя гээд энэ дээр нэлээдгүй ажлууд хийгдээд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар судалгаа хийгдээд явж байгаа юм билээ.

Судалгааны урьдал тайланг би хүлээж авч харсан.

- Хөгжлийн бодлого баримт бичиг нь –
- хүрэх үр дүн рүүгээ чиглэсэн заалтуудыгаа илүү төлөвлөж явъя.
- Тэрийгээ дүгнэдэг шалгуур үзүүлэлтүүдийгээ оноож явъя.
- Тухайлсан төсөл, арга хэмжээг нэр, огноо зааж явах нь буруу юм байна.

Ер нь үр дүн рүүгээ чиглэсэн бодлогын баримт бичгүүд байх ёстой гэсэн хөндлөнгийн ажлын хэсгийн урьдчилсан саналууд гараад явж байгаа гэсэн мэдээллийг авсан гэдгийг хэлье.

Б.Пүрэвдорж: Шадар сайд Жадамбын Энхбаяр нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга ингэж хамаагүй ярьж болохгүй шүү. Нэг.

Монгол Улс чинь Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад хөгжлийн бодлого, төлөвлөлттэй байна. Түүнд “тогтвортой хэрэгжинэ” гээд Үндсэн хуульдаа оруулаад, тэгээд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль гаргаад таван жилийнхээ хөтөлбөрийг Их Хурал хуульчлан баталсан.

- Юу юуг яаж хийх вэ.
- Ямар үр дүнд хүрэх вэ.

2026-2030 оны бүх хөгжлийн бодлого, төлөвлөлт чинь тодорхойлогдсон. Та бүгд өөрсдөө баталсан шүү. Нэг.

Энэ дээрээ гүйцэтгэлээ жил жилээр гаргаад, төсөв, санхүүгийн чадавхдаа тулгуурлаад жил жилээр хэрэгжилтийг хангаад л явж байгаа.

Түүнээс үгүйсгээд л нэг өөр юм барьж яриад л, ялангуяа аудит ингэсэн гэдэг бол та их ноцтой юм ярилаа. Энэ чинь батлагдсан хууль хэрэгжиж байгаа үйл ажиллагаа. Өөр зарчмын санал байвал тэрийгээ хуульдаа өөрчлөлт оруулаад явуулах ёстой болохоос биш... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн дарга Г.Лувсанжамц гишүүн нэмж хариулъя.

Г.Лувсанжамц: Ч.Анар гишүүний хоёрдугаар асуултад хариулъя.

- 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт 25 хувьтай.
- 2025 оных 57 хувьтай гарсан.

Энэ жилийн хувьд Эдийн засаг, хөгжлийн яамнаас өргөн барихад өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй зөв агуулгатайгаар хөгжлийн төлөвлөгөө өргөн баригдсан. Үүнийг сайшааж байгаа. Гэхдээ шүүмжлэх зүйлүүд мэдээж байгаа. Жишээлбэл, таван жилийн үндсэн чиглэл дээр туссан шалгуур үзүүлэлт 516 байгаагаас 393-ыг нь л өргөн барьсан.

Тэгэхээр жилийн хөгжлийн төлөвлөгөө маань юу руу чиглэх вэ гэдэг дээрээ туссан байгаа. Гол агуулга болох энэ 3 дугаар хавсралтаа жил болгон өөрчлөөд байх юм бол хөгжлийн бодлого тогтвортой байна гэдэг заалт маань өөрчлөгдөөд байгаа гэсэн үг.

Тэгэхээр хөгжлийн бодлого, төлөвлөлт дээрээ бид хөгжлийн төлөвлөгөөн дээр “төсөл, арга хэмжээ бичих биш” “арга замаа бичих ёстой”.

- Боловсролын чанарыг сайжруулна.
- Хүртээмжийг сайжруулна.

Тэгээд намар төсвөө барихдаа яаж түүндээ хүрэх гэж байгаа юм бэ гэдэг төсвөө тавих ёстой. Төсөл, арга хэмжээгээ тавих ёстой. Ингэж засах зүйлүүдийг нь хийх ёстой болов уу гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Ч.Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Тэгэхээр 25, 57 хувьтай.

Манайх чинь 80-аас дээш бол хэрэгжсэн гэж дүгнэдэг билүү. Тэгээд хэрэгжихгүй байгаа энэ төлөвлөгөөнүүд дээр хэн ямар хариуцлага яаж үүрдэг юм бол? Засгийн газрын үйл ажиллагааг би Засгийн газар болгон л сонслоо. Дандаа л хангалттай сайн ажилласан гээд байдаг. Тэгээд энэ тоо баримтаараа хэрэгжихгүй юм.

Хоёрдугаарт, үнэхээр асуудал байгааг нь бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ.

Энэ хөгжлийн төлөвлөгөө дээр. Яамаа ч ажил хийлгэдэггүй, төсөв дагаж хүслийн жагсаалт явуулаад байдаг. Их Хурлын гишүүд нь энэ суурь асуудлаа өөрчлөхийн талаар ярих ёстой юм биш үү. Тэгэхгүй энэ төсөл, хөтөлбөрийг манай орон нутагт хийж өгөөч, энэ салбарт хийж өгөөч гээд ийм хүслийн жагсаалтуудыг л оруулаад байх юм. Гол асуудлаа өөрчлөх ёстой юм биш үү.

Б.Пүрэвдорж: Тэргүүн Шадар сайд Ж.Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Ч.Анар гишүүн асуудлыг их зөв хараад байгаа цөөхөн гишүүдийн нэг. Үнэхээр хөгжлийн бодлого бол хуульчилж Үндсэн хуульдаа тусгаж, улс төрөөс ангид, улс төрийн намууд хатуу үүнийгээ барьж хэрэгжүүлнэ гэдэг л зөвшилцөл шүү дээ.

Энэ хэрэгжилт муу гараад байгаа шалтгаан ердөө л Их Хурал дахь энэ дур зоргын үйлдэл. Нөгөө –

- хуулийн шаардлагад нийцээгүй,
- зураг төсөлгүй,
- эх үүсвэргүй,
- хөндлөнгөөс оруулсан зуу зуун саналууд,
- их наяд, их наядын зардлууд.

Энэ оруулсан жагсаалт чинь хөгжлийн бодлогын хэрэгжилтийг, үзүүлэлтүүдийг унагааж байгаа зүйл байгаа юм. Энэ дээр бүр Засгийн газрын оруулсан хэрэгжилт өндөр гардаг. Гишүүдийн оруулсан нь бага гардаг. Яагаад гэвэл –

- зураггүй,
- төсөлгүй,
- эх үүсвэргүй.

Улс төр хийгээд оруулдаг. Тэгээд хэрэгжилтийг нь их доош нь хойш нь чангаагаад хэрэгжилтийн түвшин гарахгүй зүйл энэ байгаа юм.

Ахиад энэ юугаа хиймээр байгаа юм. Энэ таван жил баталсан зүйл дотроо л бид цаашаа явна. Үүнийгээ л хатуу барих ёстой. Шинэ зүйл гэж байхгүй.

Б.Пүрэвдорж: Ч.Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Хэн нь хариулах бол? Ж.Энхбаяр сайд хариулах юм уу? Хэрэгжилт дээр нь асуудал үүссэнэ. Бие бие рүүгээ жихээд байх юм. Хариуцлагын тогтолцоо ер нь яаж байдаг юм бол? Хэн нь ч хариулсангүй.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулиар энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол тэдгээрт Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ гэсэн ийм санкцтай.

Ер нь асуудал Үндсэн хуулийн зөрчил рүү явна шүү гэдгийг л гишүүд минь дахин анхаараарай.

Манай гишүүд Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд гээд байгаа юм.

Үндсэн хууль давж, хууль давж бүрэн эрх хэрэгждэггүй. Их Хурлын гишүүний бүрэн эрх хуульд нийцэх ёстой шүү. Ийм олон саналууд гарсан. Харж байна. Дараа нь энд эх үүсвэртэй нь, ТЭЗҮ-тэй, зураг төсөлгүй аливаа ямар нэгэн төсөл энэ хөгжлийн бодлогыг давах ёсгүй. Одоо хаана хаанаа жоохон сахилгатай, хариуцлагатай болцгооё бүгдээрээ. Зурагтай, төсөлтэй, мэргэжлийн багуудын боловсруулсан зүйлийг хийдэг болъё.

Хөгжлийн төлөвлөлт гэдэг чинь бие даасан институт хийдэг, ур чадвар шаарддаг мэргэжлийн ажил шүү дээ.

Б.Пүрэвдорж: Одоо Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна.

Б.Түвшин: 2027 оны хөгжлийн төлөвлөгөө ярилцаж байна.

Сая Эдийн засаг, хөгжлийн сайд маань хаана хаанаа зарчимтай баймаар байна л гэж байна. Яг үнэн. Тэгэхдээ эхлээд энэ төслөө оруулж ирж байгаа

байгууллага буюу Засгийн газар өөрөө жоохон зарчимтай байх шаардлагатай байна.

Одоо энэ орж ирж байгаа төсөл, арга хэмжээнүүдийг харахаар 124 төсөл, 186 арга хэмжээ. Харьцаа нь 40. 60.

Юу гэсэн үг вэ гэхээрээ хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалт хийхгүй байна. Дандаа тийм –

- зөөлөн үйл ажиллагаа,
- судалгаа,
- зөвлөлдөх үйлчилгээний зардлуудыг энд ихэнх нь гаргасан байна.

Хөрөнгө оруулалтаа урсгал зардлын харилцааны олон улсын харьцуулалт гэж байдаг. Яг энэ хөгжлийн төлөвлөгөөнд. Энэ 124 төслийн –

- хөрөнгө оруулалтаар санхүүжих нь -71 хувь,
- урсгал зардлаар санхүүжих нь -38 хувь.

Тэгээд энэ чинь дэлхийн олон улсад байдаг жишгээс хамаагүй доогуур байна шүү дээ.

Хөрөнгө оруулалтын төслүүдийн 57.3 хувь гэж байгаа нь олон улсад байж байгаа байдлаасаа энэ томоохон бодит хөрөнгө оруулалт руугаа 70-аас 80 хувь байдаг. Манайх дөнгөж 57 хувь л байгаа шүү дээ.

Ингэхээр чинь яаж хөгжих юм.

Эрэмбэ дарааллын аргачлалгүй. Олон улсын жишигтэй нийцэхгүй.

- Нөлөөллийн хүрээ,
- эдийн засгийн дотоод өгөөж,
- санхүүжилтийн бэлэн байдал,
- яаралтай болон яаралтай биш байдал,
- бүс нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр –

-гэсэн таван шалгуур тусгагдаагүй. Дандаа хүслийн жагсаалт оруулж ирсэн.

- Зардал, үр ашгийн шинжилгээ хийгдээгүй.
- Эдийн засгийн дотоод өгөөжийн хувь хэмжээ тодорхойгүй.
- Яаж хөгжих нь тодорхойгүй.

Cost-Benefit Analysis-ыг Засгийн газрын аргачлалаар хийгээгүй.

Эцсийн дүндээ бага дүнтэй, үр ашигтай төслүүд, өндөр дүнтэй үр ашиг багатай төслүүд ижил эрэмбэлэгдээд ороод ирсэн.

Одоогоор энэ дотроос харж байгаа 37 төсөл, хөтөлбөр нь зөвхөн нэг аймаг, сумыг хамарсан. Төсвийн хэмжээ багатай. Орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх боломжтой. Яаралтай бус. Энэ хойшлуулж болох юмнууд зөндөө л байна шүү дээ.

Үүнийг нь тодорхой шалгуураар шүүгээгүй шүү дээ. Бүгдийг нь нээлттэй хийгээд л болгоё л доо.

Бүс нутгийн том төслүүдийн эзлэх хувь байхгүй байна шүү дээ.

Одоо эндээс харж байхад 6 ба түүнээс дээш аймгийг хамарсан төслүүд дөнгөж 11 хувьтай. Үгүй энэ улс чинь гайгүй дундаж хөгжиж байгаа улсуудад 50-иас 60 хувьтай байна шүү дээ.

Вьетнамын 58 хувь байна. Би бүр өндөр хөгжилтэй улсыг яриагүй. Индонезийн 52 хувь байна.

Тэгээд манай улс чинь бүс нутгийн хөгжил болон аймаг дамнасан, сум дамнасан энэ юмнуудаа хийхгүй зүгээр аймаг доторх, сум доторх юмнуудыг хийсээр байгаад дуусах гэж байгаа юм уу? Тэгээд үүнийг оруулж ирснээр нь дэмжээрэй гэж яриад байгаа юм уу?

Хойшлуулж болох төслүүдийн шинжилгээ, эдийн засгийн үр нөлөөг хийгээгүй байна шүү дээ.

Одоо энэ 124 төслөөс 37 төсөл нь зөвхөн нэг аймаг юм уу, нэг сумыг хамарсан. Төсвийн хэмжээ багатай буюу 5 тэрбумаас доош. Орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх боломжтой. Яаралтай бус.

Эдгээрээс 2028-2029 онд хойшлуулаад, 1.2 их наяд төгрөгийг чөлөөлөөд, бүс нутгийн том төслүүдэд чиглүүлэх боломжтой гэж үзэж байна.

Олон улсын туршлагаас харахад Өмнөд Солонгост жишээлбэл 90 онд энэ жижиг жижиг төслүүдээсээ 150 орчмыг хасаад, чөлөөлөгдсөн бүс нутгийн 7-хон том төсөл хэрэгжүүлээд л 10 жилийн дотор хөгжсөн шүү дээ.

Бид өнөөдөр ерөөсөө энэ хөгжлийн төлөвлөгөө биш. Зардлын хүсэлт, мөрөөдөл гаргаад байна шүү дээ.

Тэгээд Их Хурлын гишүүдийн буруу гээд зарим нь яриад сууж байна шүү дээ. Ийм зарчимгүй юман дээр саналаа өгөхгүй тэгээд яах юм.

Гадаад орнуудын туршлагыг хар. Аль ч зарчмыг бариагүй. Хөрөнгө оруулалтын төсөл давамгайлсан. Бүс нутгийн хэмжээ давамгайлсан төсөл 50 хувиас дээш байна гээд туршлагауд дээр бичсэн л байгаа шүү дээ.

Тэгээд энэ таван зарчим бариагүй учраас гишүүд өөр өөрсдийнхөө хүслийг оруулж ирээд та нар энэ олон хүмүүсийн хүслийг дийлэхгүй болоод байгаа байхгүй юу. Өөрөө өөрсдөө ажлынхаа эрэмбэ дараалал, зарчмыг гаргаж байж энэ хүмүүс чинь өөрөө зарчимд орно шүү дээ.

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж гүйцээж асууя.

Б.Түвшин: Тэгэхээр энэ төсөлд нь ер нь 6 ба түүнээс дээш аймгийг хамарсан томоохон хөгжлийн төлөвлөгөө, төслүүд ороогүй нь сул талтай.

Тийм учраас–

- ▷ **Нэгдүгээрт**, Дэлхийн банкны гаргасан аргачлалыг үндэслээд эрэмбэ дарааллын таван шалгуурыг даруй нэвтрүүлэх хэрэгтэй байна.
- ▷ **Хоёрдугаарт**, төсөл бүр дээр зардал, үр ашгийн шинжилгээ хийгээд дотоод өгөөжийг нь ярих хэрэгтэй.
- ▷ **Гуравдугаарт**, тэр хойшлуулж болох 37 төслийг 2028, 2029 онд шилжүүлээд чөлөөлөгдсөн 1.2 их наядыг бүс нутгийн томоохон төслүүдэд шилжүүлэх хэрэгтэй.
- ▷ **Дөрөвдүгээрт**, урсгал зардлын төслүүдийг бууруулж, хөрөнгө оруулалтын төслүүдийг нэмэх.
- ▷ **Тавдугаарт**, төсөл, арга хэмжээний харьцааг 60, 40 болгож байж л манай улс энэ хөгжлийн төлөвлөгөө гэдэг сонгодог утгаараа болно.

Би энэ дээр бүс нутгийн юм ярина. Арцсуурийн боомт, Арцсуурийн тэр боомтын зам бол Завхан аймаг, Говь-Алтай аймаг, Ховд аймгийн зүүн хойд, Увс аймгийн зүүн хэсэг, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Өвөрхангайг дамнасан Ази болон Төв Азийн бүс нутагтай холбох гол боомт... /минут дуусав/ Шадар сайд Ж.Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Б.Түвшин гишүүн өөрөө хууль зөрчсөн гишүүний нэг.

375.0 тэрбум төгрөгийн санал гаргаж энд хураалгах гэж оруулж ирж байгаа хүн.

Ямар тооцоо судалгаа, ямар техник, эдийн засгийн үндэслэл.

Нөгөө талдаа эдийн засгийнхаа орлого, зарлагын асуудлаа та эргэж хараач. Нийт төсвийн чинь 90 хувь бараг урсгал зардал болоод, цалин, тэтгэвэр, халамж болоод байна шүү дээ.

Хөрөнгө оруулалт хийх орон зай 2027 онд байхгүй. Шилжих 3.6 тэрбумаас 2.2-ыг нь бид санхүүжүүлэх эх үүсвэртэй. Энэ чинь бодит л байдал шүү дээ.

Энэ 3, 4 тэрбум төгрөгийн шинэ жагсаалт орох бололцоогүй шүү дээ.

Та 60, 40 байх ёстой гэж их сайхан зүйл ярьж байна. Би дэмжиж байна. Ийм байгаасай билээ. Тэгвэл урсгал зардлыг л битгий нэм л дээ. Битгий янз янзын зардал нэмсэн хуулиуд оруулж ирээд бай л даа. Хөгжлийнхөө дэд бүтцийг, энэ суурь асуудлаа шийдэж чадахгүй эрчим хүч дэд бүтэц чинь хоцрогдоод эхэллээ шүү дээ.

Дандаа урсгал зардал, дандаа нийгэмд таалагдах зардлуудыг санхүүжүүллээ.

Тэгэхээр чинь бодит байдал маань ийм л байна. 2027 онд бид яг бодит байдалтайгаа нүүр тулж байна шүү дээ.

Шинэ хөрөнгө оруулалт байхгүй ээ. Шилжих хөрөнгө оруулалтаа дотроосоо 70, 80 хувийг нь санхүүжүүлж чадвал их томоохон амжилт болох гээд байна. Уг нь болдог бол энэ 126 гишүүний гаргаж байгаа саналыг бүгдийг нь зогсоож байгаад таны хэлдэг 7-хон төслийг санхүүжүүлэх юмсан. Энэ дэд бүтцийн, бүс нутагтай холбосон, интеграцид нэгтгэх, улс орноо бодсон хөгжлийн 7-хон төслийг санхүүжүүлбэл бидэнд хэрэгтэй байна.

Харамсалтай нь Их Хурлын гишүүн бүрэн эрх гэдэг доор энэ байгаа эх үүсвэрийг тал тал тийш нь тан чангааж байна шүү дээ.

Бүхий л тойргийн түвшинд, сумын түвшинд чангааж байна шүү дээ.

- Хөвдөг гүүр,
- гал команд,
- эмнэлгийн тоног төхөөрөмж,
- жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж,
- гэр бүлийн арга хэмжээг санхүүжүүлэх –

-гэх мэтийн мэтээр энэ чинь хэдэн их наядын зардлууд чинь орж ирж байна шүү дээ.

Энэ усны асуудал. Говийг хөгжүүлэхийн тулд, уул уурхайг хөгжүүлэхэд ус хэрэгтэй байна шүү дээ.

Эн тэргүүнд эрчим хүч, ус. Энэ тэргүүлэх чиглэлүүдийн дэд бүтцийн асуудлыг хиймээр байна шүү дээ.

Энд нэг сайхан юм ярина. Ачир дээрээ шал өөр санал хураалгана. Ийм хоёр нүүртэй байж болохгүй шүү дээ.

Б.Пүрэвдорж: Б.Түвшин гишүүн нэмж тодруулъя.

Б.Түвшин: Энэ Ж.Энхбаяр сайдын үгийг сонсохоор их зөв бөгөөд зарчимтай ярих юм. Үйлдэл нь яг эсрэгээрээ. Сая би тоон фактаар л ярилаа шүү дээ.

Миний оруулсан гурван саналыг сонсох уу. Та.

- ➔ Улиастай, Ховдын зам. 2, 3 аймаг, бүс нутгийн асуудал ярьж байна. Төсөв нь бэлэн.
- ➔ Арцсуурийн зам явж байгаа зам. Ердөө л 80 тэрбум төгрөгийн асуудал ярьж байна.
- ➔ Арцсуурийн боомт. Төсөв, техник, эдийн засгийн үндэслэл нь бүгдээрээ бэлэн болсон. 10-хан тэрбум төгрөг.

Одоо энэ 90-хэн тэрбум төгрөгийн асуудлыг л оруулаад өг өө. Энэ чинь өөрөө Завхан, Говь-Алтай, Ховд, Увс аймгийн зүүн хэсэг, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Өвөрхангай гэсэн аймгуудыг Евразитай холбох ганц гарьц шүү дээ.

Энэ өөрөө эдийн засгийн том төлөвлөлт шүү дээ.

Тэгж ярих юм бол энэ төсөл чинь усны дараа орох эрэмбээрээ хамгийн өндөр эрэмбэлэгдсэн ажлууд шүү дээ.

Энэ эрэмбүүдийг хэлж байхад юун урсгал зардал. Би харин ч урсгал зардал хасахын төлөө ажилладаг. Цаашдаа ер нь боломж гарвал урсгал зардлуудыг илүү хасах ёстой. Энэ дээр харин ч санал нийлж байна.

Б.Пүрэвдорж: Асуулт асуусангүй. Өөрөөр хэлбэл урсгал зардлаа хасъя. Яг чухал хэрэгцээтэй хөрөнгө оруулалт хийе гэсэн санал гаргасан байна. Тэгээд түүндээ хариулт хэрэггүй гэж гишүүн өөрөө үзэж байна.

Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн чинь суурь нь юу юм бэ? Гол юм нь. Гол дэд бүтэц нь.

Эдийн засаг, хөгжлийн сайд эдийн засгийн хөгжлөө ярина. Үүний чинь суурь дэд бүтэц нь юу юм. Ус шүү дээ.

Тэгээд Эдийн засгийн байнгын хороон дээр “Онги, Цагаан бургастай” төслийн зарчмын зөрүүтэй миний оруулсан саналыг унагаад өнөөдөр бид энд мянган зам, сургууль, станц барих гээд яах юм. Усгүй байж байж.

Говийн бүс 1.7 их наядыг төвлөрүүлдэг шүү дээ. 1.7 тэрбум биш шүү. 1.7 их наядыг төвлөрүүлдэг.

Говийн ард түмэн баялгаа хэзээ ч тэмцэж хэзээ ч харамлаж байгаагүй өгдөг.

- Тэгсэн хэрнээ бид яагаад гадаргын устай байж болдоггүй юм.
- Бид яагаад амьд явж болдоггүй юм.
- Говийн ард түмэн яагаад устай байж болдоггүй юм.

Та Хөдөө аж ахуйн сайд байсан. Нийт малын чинь 40 хувь нь ундны усны эх үүсвэргүй болсон байгаа шүү дээ. Манай улсын усны 80 хувь нь гүний ус.

Тийм учраас бид дэлхийд усны хомсдолтой 20-хон орны нэгэнд ордог байхгүй юу гишүүд ээ.

Тэгэхээр бид өнөөдөр хөгжлийн төлөвлөгөө батлах гэж байгаа бол уснаас татгалзаад ямар юмных нь хөгжлийн төлөвлөгөө байдаг юм.

Одоо 8 дугаар сард COP-ийг бид энд эх орондоо зохион байгуулна гээд хөл хөөрцөг болоод бэлдээд явж байгаа.

Энэ дээр чинь анх удаа Монгол Улсын санаачилгаар усны менежмент орж ирсэн. Ийм байхад бид хөгжлийн төлөвлөгөөнөөсөө усаа хасах ёстой юм уу? Би Үндсэн Үндсэн хуулийн цэцдээ өгөх юм уу?

Би зарчмын зөв асуудал тавьж байна гэж ойлгож байна. Ж.Энхбаяр сайд аа. Та тэгээд хариулт өгөөрэй. Энэ усгүйгээр ямар ч хөгжил явахгүй, юу ч явахгүй. Энэ зөвхөн говийн ус биш. Монгол Улсын хэмжээний ус байх ёстой юм.

Би танаас хоёр асуулт асууя. Яагаад энэ юугаа авч явдаггүй юм бэ? “Онги, Цагаанбургастай” төсөл өө. Би биш та аваад явж байх ёстой юм биш үү. Та Эдийн засгийн байнгын хороог лоббидоод энэ усны төслийг дэмжээд өгөөч гээд явж байх ёстой хүний нэг гэж би нэгдүгээрт бодож байна.

Хоёрдугаарт, би энэ саналыг хэлж байгаагаараа, ийм зарчмын зөрүүтэй санал гаргаснаараа Үндсэн хууль зөрчсөн үү?

Тэргүүн Шадар сайд Ж.Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Та наад асуултаа ажлын хэсэг, Эдийн засгийн байнгын хорооноос асуувал яасан юм. Би танд өмнө нь хэлсэн шүү дээ.

Эдийн засаг, хөгжлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд –

- усны асуудал, говийн бүсийн усжуулалт байгаа.
 - Техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж байна.
 - Хэрлэн, Тооно дээр Оюу Толгой компани санхүүжүүлээд техник, эдийн засгийн үндэслэл нь дууслаа.
- Нэлээн олон тэрбум зарцууллаа.
 - 4 маршрут гарлаа.
 - Маршрутаас нь сонголт хийнэ. Тэгээд энэ чинь өртөг орж ирнэ шүү дээ.
- Тэр ТЭЗҮ-ээр хэчнээн төгрөгийн хөрөнгө оруулалтаар яаж яаж явах юм.
 - Маршрут нь тодорхой болох хэрэгтэй.
 - Нийгэм, засгийн үнэлгээнүүд нь.
 - Процесс дуусаагүй байгаа юман дээр мөнгө тавьж болохгүй шүү дээ.

Хуульд нийцүүлээд санал хураасан байх гэж бодож байна.

Энэ чинь бодлогын асуудал дээр, тэргүүлэх чиглэл дээр “Онги, Цагаан бургастай”, “Хэрлэн, Тооно”, говийн бүсийн усжуулалт бол тэргүүлэх ээлжийн бодлого хэвээрээ л явж байгаа.

Нөгөө талаар бид COP-ийн хүрээнд Монгол Улс буулгах арга хэмжээний хүрээнд энэ чинь тэргүүлэх, Засгийн газрын танилцуулах төсөл болоод явж байгаа биз дээ.

Та бид хоёр чинь их сайхан ойлголцоод явж байгаа гэж ойлгох юм. Тэгээд өөр юм яриад байх юм. Энэ бодлогоос ухарсан зүйл байхгүй.

Гадаад, дотоод зээл, арга хэмжээ, буцалтгүй тусламж, нөгөө талдаа бололцоотой бол уул уурхайн салбарын зохион байгуулалтаар хөрөнгө оруулалтыг нь татаад хийх бололцоотой л байна шүү дээ.

Ингээд нэг нэгийгээ үгүйсгээд л, асуудлыг хурцатгаад л улс төр болгоод байх хэрэг юу байна. Нийлээд зүтгээд ард нь гарцгаая л даа. Тийм биз дээ. Тэгээд би дэмжиж байгаа гэдгээ хэлье. Дэмжиж байна. Асуудал байхгүй. Тийм ээ. Хамтраад ажиллая.

Өнөөдөр тоо, баримт нь эцэслээгүй юман дээр бид мөнгө тавьж болохгүй нь суурь шаардлага биз дээ. Энэ зураг нь хийгдэж байгаа юм аа. Мөнгө тавьчих гэж болохгүй биз дээ, энэ чинь.

Б.Пүрэвдорж: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Та бид хоёр хоорондоо ярихаараа жигтэйхэн нэг саналтай байгаад байдаг. Та тэгээд манлайллаа үзүүл л дээ.

Ганц говийн бүсийн 7-хон гишүүн явах ёстой юм уу? Та бас явах ёстой шүү дээ. Засгийн газар хөдлөх ёстой биз дээ. Тэгж байж үүнийгээ авч гарна шүү дээ.

Тэндээс асуу, эндээс асуу гээд байх юм. Үгүй, би таныг үйл хөдлөлөөрөө үзүүлээд хамтраад ажиллая гэж байгаа юм.

Түүнээс биш болохгүй юм гуйгаад би ямар өөртөө нүүрсний уурхай гуйж байна уу. Бид цөхөрч байна шүү дээ.

Өнгөрсөн жил хөгжлийн төлөвлөгөө дээр зарчмын зөрүүтэй саналаар оруулсан. Тэр 333 нуурыг чинь зарчмын зөрүүтэй саналаар оруулсан.

Тэр ТЭЗҮ-ийн 9 тэрбумыг чинь бас зарчмын зөрүүтэй саналаар оруулсан. Энэ төрд бодлого байх ёстой биз дээ.

Яагаад дандаа зарчмын зөрүүтэй саналаар явуулж байх ёстой юм. Яагаад дандаа уйлаан майлаан болж, хүн амьтан гуйж түүж явж байх ёстой юм бэ энэ чинь.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Сангийн яамнаас нэмэлт. Асуугаагүй юу. Асуулт асуусангүй. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Биш. Санал хураалтыг 16.00 цагаас.

Үг, асуулт хамтдаа шүү. Уучлаарай. Үгийг санал хураалт дээр явна.

Өөрөөр хэлбэл зарчмын зөрүүтэй санал дээр үг хэлж болно. Санал хураалтыг 16.00 цагаас явуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Арван нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн
2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

1992 онд Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа баталсан.

Энэ хуулиар иргэний үндсэн эрхийг хамгаалж, эрх мэдлийн хуваарилалтыг хангуулах үндсэн зарчмууд хуульчлагдсан.

Үндсэн хуулийн тухай олон нийтэд илт болсон нэг үнэн бий. Иргэний үндсэн эрхийг хамгаалаагүй, эрх мэдлийг хуваарилаагүй Үндсэн хууль бол Үндсэн хууль биш гэдэг суурь зарчим байдаг.

1992 оны Үндсэн хуулийн хамгийн суурь гол үнэт зүйл хувь хүний үзэл бодол, итгэл үнэмшил, түүний санаачилга дээр суурилсан хөгжлийн тухай үзэл баримтлал байсан.

Олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрч, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахыг Үндсэн хуулиараа бид тунхаглан зорьсон билээ.

Олон ургалч ургалч үзэл энэ нийгэмд байна гэдэг иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх дээр суурилсан олон намын тогтолцоо бүрдэнэ гэсэн үг.

Олон намын тогтолцоо өөрөө өрсөлдөөнт улс төрийг бий болгож чөлөөт сонгуулийн зарчмаар төлөөллийн ардчилал болох Улсын Их Хурал буюу парламентыг бүрдүүлдэг.

Олон намын төлөөлөл бүхий Улсын Их Хурал 126 гишүүнтэй өргөтгөсөн үйл ажиллагаа өнөөдөр явуулж байна.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон 2024 оны сонгуулийн үр дүнгээр 126 гишүүнтэй олон намын төлөөлөл бүхий Улсын Их Хурал бүрдсэн.

Олон намын төлөөлөл бүхий энэ Улсын Их Хурлын үндсэн үйл ажиллагаа нь бодлого, үйл ажиллагаагаараа мэтгэлцдэг, өрсөлддөг, олонх цөөнхийн зарчмаараа ажилладаг парламентын ардчиллыг бий болгосон.

Парламентын ардчиллыг бэхжүүлэх зорилготойгоор энэ хоёр жилийн хугацаанд Улсын Их Хурал дээр “асуулгын цаг” гэдэг үйл ажиллагаа, зарчмыг хуульчлан баталгаажуулсан. Өнөөдөр үдээс хойш асуулгын цаг хэрэгжинэ.

Энэ мэтгэлцээн дээр суурилсан олон намын төлөөлөл бүхий парламентыг зохион байгуулахын тулд Улсын Их Хурлын дарга буюу парламентын спикерийг төвийг сахидаг, намын улс төрөөс ангид байлгах зарчмыг хуульчлахаар Улсын Их Хуралд мөн хууль өргөн барьсан.

Энэ хуулиудын цаана дахиад нэг чухал зарчим байгаа нь Үндсэн хуулиар тодорхойлсон эрх мэдэл хуваарилах зарчим. Улсын Их Хурал засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Ард түмэн энэхүү эрхээ шууд болон өөрийн сонгон байгуулсан төлөөллийн байгууллагаараа уламжлан эдэлнэ гэсэн Үндсэн хуулиас үүсэлтэй.

Улсын Их Хуралд 126 гишүүн байхаас гадна гишүүн ард түмний элч байх тухай Үндсэн хуулийн маш тодорхой заалттай.

Улсын Их Хурлын чуулганы зохион байгуулалт бол энэ 126 гишүүн ард түмнийг төлөөлж үгээ хэлж, хууль тогтоож, Засгийн газрыг хянахад чиглэсэн.

Засгийн газар буюу Ерөнхий сайдыг Улсын Их Хурал томилж, чөлөөлдөг. Ерөнхий сайд Улсын Их Хурлын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг.

Гэтэл Үндсэн хуулиар тодорхойлсон суурь үнэт зүйл зарчмууд алдагдаж, эрх мэдлийн хуваарилалт эвдэгдэж байгааг Та бүхэн өдөр бүхэн чуулганы танхимд сууж байхдаа харж байгаа.

Улсын Их Хурлын тархин дээр Улсын Их Хурлын дарга буюу Улсын Их Хурал парламентын спикертэй зэрэгцэн суух Ерөнхий сайдын суудлыг буулгахгүйгээр олон намын төлөөлөл бүхий мэтгэлцээн бүхий парламентыг бид ажиллуулж чадахгүй.

Ерөнхий сайд Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнах ёстой. Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайдад загнуулж ажлаа тайлагнадаггүй.

Гэтэл суудлын зохион байгуулалт хуульчлагдаагүй. Суудлын зохион байгуулалт Үндсэн хуулийн үзэл санаанд нийцээгүйгээс болоод парламентын чуулганы танхимд бид гурван даргын адил бэлгэдэлтэй болж хувирсан байна.

Ерөнхий сайдын суудлыг буулгаж мэтгэлцээн бүхий парламент буюу олон намын төлөөлөл бүхий энэ парламентын хэвийн үйл ажиллагааг хангуулж, эрх мэдэл, хуваарилалтын зарчмыг Үндсэн хуулийн дагуу бий болгохын тулд энэхүү хуулийн төслийг өргөн барилаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуульд үнэнч байх, Үндсэн хуулийн дэг журмын дагуу парламентат ёсыг бэхжүүлэх, Үндсэн хуулийн дагуу парламентын засаглалыг хэрэгжүүлэхийн тулд Улсын Их Хурлын чуулганы танхим дахь хууль бус суудлын хуваарийг хуулийн дагуу зохицуулах энэ хуулийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Х.Тэмүүжин гишүүнд баярлалаа. Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна.

Индэрт урьж байна.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 31.5-д бүлэг нэгдсэн болон Байнгын дэд хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах эрхтэй гэж заасны дагуу Монгол Ардын намын бүлгээс ажлын таван өдрийн завсарлага авсан.

Тус завсарлагын хугацаа дуусаж, Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна, Монголын ард түмэн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ гэж Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны танхим дахь суудлын байршил нь олонхын эрх мэдэл, цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй 126 гишүүнээс бүрдсэн Улсын Их Хурлын харилцан тэнцвэртэй мэтгэлцэх боломжийг бүрдүүлэх тул уг нөхцөлийг хангахад чиглэсэн танхимын зохион байгуулалтыг хуульчлах шаардлагатай гэж үзэн уг төслийг боловсруулсан гэдгээ танилцуулсан.

Хуулийн төсөл иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар төслийн 15.7-д заасан цөөнхийн бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд дарга тухайн цөөнхийн бүлгийн дарга нарын суудлыг нүүрний эгнээнд тус тус хуваарилна гэсэн нь Улсын Их Хуралд суудалтай бүлэггүй нам, эвслийн дарга төлөөлж буй гишүүдийн суудлыг хэрхэн хуваарилах талаар зохицуулалт тусгагдаагүй тул холбогдох өөрчлөлт оруулах эсэх,
- Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Ерөнхий сайдын суудлын зохион байгуулалт парламентын ардчилалд хэрхэн нөлөөлөх, мөн гадаад туршлагыг үндэсний онцлогтой нийцүүлж авч үзэх шаардлагатай талаар. Нэгдсэн хуралдааны танхимын суудлын хуваарилалтыг хуульчлах бодит шаардлага байгаа эсэх. Танхим дахь суудлын хуваарийг Улсын Их Хурал өөрийн дотоод зохион байгуулалтын түвшинд шийдэх боломжтой эсэх. Суудал хуваарилалтыг хуулиар тогтоосноор парламентын ардчилал сайжрахад бодит ач холбогдолтой эсэх талаар асуулт асууж хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр хуулийн төслийг дэмжиж буйгаа илэрхийлээд, энэхүү нэгдсэн хуралдааны танхимын суудал хуваарилалтын асуудал нь улс төр биш парламентын засаглалын суурь асуудал тул хуульчлах нь зөв гэжээ.

Ерөнхий сайд парламентын танхимын дээд хэсэгт биш харин парламентын танхим дотор Улсын Их Хурлаас хуваарилсан суудалд сууж, Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд хариуцан тайлагнах шаардлагатай гэж үзэж байгаагаа түүнчлэн хэлсэн болно.

Байнгын хороо хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: А.Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Би энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

Яагаад гэхээр Ерөнхий сайд Улсын Их Хурлын дарга биш. Ерөнхий сайд, Засгийн газар Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг тийм байгууллага.

Ажлаа тайлагнадаг байгууллага нь удирддаг, томилдог байгууллагынхаа дээр гарч суугаад загнах хэлбэрээр, эсвэл нэг бол намын даргын хэлбэрээр сөрөг хүчнийхээ үйл ажиллагаа руу хандаад байдаг асуудал байж болохгүй л дээ.

Тийм учраас би энэ заалтыг угаасаа дэмжиж байгаа. Улсын Их Хуралд Ерөнхий сайд чинь өөрөө Улсын Их Хурлын гишүүн, энд өөрийнх нь суудал байгаа шүү дээ.

Тэгээд заавал тэр индэр дээр Улсын Их Хурлын даргатай зэрэг суугаад байгааг ойлгохгүй байгаа юм. Бид чинь хуульчлахдаа хүртэл 02,03 гэдэг биз дээ. Одоо энгийнээр ярих юм бол.

Тэгээд би хуралдаан даргалагч, Их Хурлын дэд даргачдад хандаж нэг юм хэлэх гэсэн юм.

Одоо ингээд бид хууль хэлэлцэх болохоор ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулсны дараа хуралдаан даргалагч Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-ийг 21.25-тай танилцуулдаг л даа.

Ажлын хэсэгт орж ирж байгаа гишүүд үнэн зөв, тодорхой тоо баримттай хариулах ёстой. Тийм үүрэгтэй. Нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөхийг хориглоно гээд.

Тэгээд сүүлийн хэдэн долоо хоног чуулганыг харахад орж ирж байгаа ажлын хэсгийн гишүүдэд асуултдаа хариулж чадахгүй тохиолдлууд зөндөө харагдлаа шүү дээ.

Өчигдөр жишээ нь Б.Түвшин гишүүний асуултад шал худлаа хариулж байна лээ. Өнгөрсөн долоо хоногт энд сууж байсан Барилгын хөгжлийн төвийнхөн хариулж чадахгүй танд бичгээр өгье гэж байна лээ.

Ингээд асуултдаа оногдсон цагаа, хариултад оногдсон цагаа бөөрөнхийлсөөр байгаад тойруулсаар байгаад дуусгадаг. Шал өөр “а” гэж

асуухаар “б” гэж хариулаад, тэмээ гэж суухаар ямаа гэж хариулсаар байгаад цагаа дуусгадаг. Тэгээд асуусан минут нь тодорхой үр дүнгүй, хариулт нь тодотголтойгоо ч үр дүнгүй ингээд нэг ийм хэлэлцсэн болоод өнгөрдөг байдлууд дээр нь хариуцлага тооцох хэрэгтэй.

Тэгэхээр би одоо энэ Улсын Их Хурлын Тамгын газраас асуулт байна.

- ▷ **Нэгдүгээрт**, Яг энэ чуулганы танхимд 2024 оны 7 дугаар сарын 02-ноос хойш ажлын хэсэг болж орж ирсэн хүмүүс хэчнээн Улсын Их Хурлын гишүүн асуултад үнэн зөв хариулж чадаагүй юм бэ?

Хичнээн албан тушаалтан бичгээр хариу өгье гэж хэлээд бичгээр өгөөгүй вэ? Өчигдөр миний санаж байгаагаар 4 удаа бичиг ирэх ёстой. Өнөөдөр эд нараас ирсэн үү? Энэ тухай тайлан бүртгэл байдаг уу?

- ▷ **Хоёрдугаарт**, асуултад хариулж чадаагүй, чуулганд ирээгүй, үнэн зөв мэдээллээ өгөөгүй, зарим мэдээллийг нуун дарагдуулсан энэ хүмүүст хариуцлага тооцсон тохиолдол байдаг уу? Байдаг бол хэд гэсэн ийм асуултуудад аягүй тодорхой хариулт авмаар байна.

Би дахиад хэлье. Бичгээр хариулт өгнө гээд 100 хүн бичгээр хариулт өгнө гэсэн бол хэд нь бичгээр өгсөн юм. Нэг.

Нийт асуусан асуултад тодорхой хариулж чадаагүй. Гишүүд та асуултад хариулаач гэж хэлснээс хэд нь тодорхой хариулаагүй юм?

- ▷ **Гуравдугаарт нь**, Улсын Их Хурлын чуулганд нэрээ өгөөд ирээгүй албан тушаалтнуудад ямар хариуцлага тооцсон юм?
- ▷ **Дөрөвдүгээрт нь**, эдгээр хүмүүс бичгээр өгөөгүй, асуултад хариулаагүй, худлаа хариулсан хүмүүст хариуцлага тооцно. Хуулийн дагуу хэдэн хүнд хариуцлага тооцсон бэ?

Энэ дөрвөн асуултад тодорхой хариулт авмаар байна.

Яагаад гэхээр ажлын хэсэг танилцуулах болгондоо 24.15, 24.25 гээд аягүй сүртэй уншдаг байхгүй юу. Танилцуулдаг. Та үүрэгтэй шүү гээд л. Энэ таны үүрэг, хуулийн хариуцлагатай шүү гээд байдаг. Яг үүн дээр ийм хариуцлага тооцсон тохиолдол хэд байдаг юм?

Би энэ яг судалгааг авмаар байна. Асуултдаа тодорхой хариулт аваад бичигтээ тодорхой хариулт авдаг бол Улсын Их Хурлын үйл ажиллагаа сайжирна шүү дээ.

Тэгэхгүй байгаа минутаа яаж дуусгах вэ гэж дэвэн дэлхийн юм тойрч хамж ярьсаар байгаад асуусан хүнийхээ бухимдлыг ч төрүүлээд, асуултдаа ч хариулдаггүй нөхцөл байдал бий болжээ. Үүнд ямар хариуцлага тооцсон юм бэ? Яаж цааш нь хариуцлагажуулах юм гэдэг асуулт Улсын Их Хурлын Тамгын газраас.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын Тамгын газар.

Тэгэхээр ер нь Их Хурлын гишүүд өөрсдийнх нь асуултад бүрэн дүүрэн хариулаагүй, худлаа хариулсан, аль эсвэл үл хүндэтгэсэн ийм байдал гаргасан тохиолдолд яг энэ Улсын Их Хурлын тухай хуулиар хариуцлага тооцох заалттай.

Тэгэхээр өнгөрсөн парламентаар Г.Занданшатар даргад яг энэ асуудлаар худал хариулсан, үл хүндэтгэсэн гэдэг шаардлага тавьсан. Түүний дагуу Г.Занданшатар нэг албан тушаалтанд хариуцлага тооцож байсан юм.

Тэгэхээр ийм боломжууд байдаг шүү гэдгийг хэлье.

Тэгэхээр индрийн 3 дугаар микрофон. Тамгын газраас хариулъя.

Ж.Бямбадулам: Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам. Хариулъя.

Улсын Их Хурлын тухай хууль болон дэгийн тухай хуулиар Улсын Их Хуралд худал мэдээлэл өгсөн талаар зохицуулалтыг тусгасан байгаа.

Энэ дагуу хаврын чуулганы нэгдсэн хуралдаан дээр мэдээлэл өгсөн болон мэдээлэл дутуу өгсөн, бичгээр сүүлд тайлбар өгье гэсэн албан тушаалтнуудын жагсаалт тухай бүр гарч байгаа.

Одоо яг чуулганы нэгдсэн хуралдаан дээр өөрөө шалгагдаж байгаа, нягталж байгаа энэ мэдээллийг танд дар бичгээр хүргүүлье. Тухай бүр гаргаж байгаа.

Хариуцлага тооцсон албан тушаалтны мэдээллийг гаргуулаад танд бичгээр хүргүүлье.

Б.Пүрэвдорж: Шууд хариулахад хэцүү л дээ. Ө.Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Яг бичгээр өгөөрэй. Гэхдээ энэ дээр бодвол Их Хурлын Тамгын газар мониторинг хийдэг байлгүй дээ гэж бодож байна. Тэгэхгүй бол бидний чуулганы танхимд байгаа хэлэлцүүлэг чинь зүгээр л нэг харилцан яриа болж үлдэнэ шүү дээ.

Зүгээр л нэг харилцан яриа болж үлдэнэ.

Тэгэхээр энэ чинь илүү үр дүнтэй болох хэрэгтэй. Жишээ нь, гурван долоо хоногийн өмнө Г.Хосбаяр гишүүний асуултад Барилгын хөгжлийн төвийнхөн асуултад хариулаагүй. Шал худлаа хариулсан. Ерөнхий инженер нь ирсэн, захирал нь ирсэн ч чадаагүй. Өчигдөр Б.Түвшин гишүүний асуултад шал худлаа хариулж байна лээ.

Өнгөрсөн жил Байгаль орчны байнгын хороон дээр Тавантолгойн түлшийг ярьж байхад манайд тохирлын гэрчилгээ байгаа гээд тэр Чанар, хяналтын албаны дарга нь ярьж байна лээ. Тэгэхэд мэргэжлийн стандартын газрынхан Тавантолгойн түлш дээр тохирлын гэрчилгээ аваагүй гээд бичиг нь хүртэл байгаа шүү дээ.

Энэ хүмүүст ямар хариуцлага тооцдог юм. Бид тэгэхгүй бол чуулганы танхим зүгээр л харилцан яриа болгоё.

- Хариуцлага тооцдоггүй,
- худлаа ярьдаг,
- хариултад хариулдаггүй,
- цагаасаа зугтаадаг,
- бөөрөнхийлж хариулаад дуусгадаг бол хэлэлцэж яадаг юм.
- Хариуцлага ярьж яадаг юм.

Тэгэхээр Их Хурлын Тамгын газар надад ажлын гурван хоногт багтааж өгөөч.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ.

П.Сайнзориг гишүүн. Алга байна.
О.Батнайрамдал гишүүн. Алга байна.
Х.Баасанжаргал гишүүн. Алга байна.
Одсүрэнгийн Номинчимэг гишүүн. Алга байна.
Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн. Алга байна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Хуулийн үзэл баримтлал дээр “Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй хэрэгжих парламент ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд” гэж бичсэн байгаа.

Тэгэхээр одоо бид нүдэнд харагдахгүй боловч яг энэ төрийн индэр дээр улс төрийн нам гэдэг үл үзэгдэгч ширээ сандал зассан байгаа.

Энэ дээр зассан Ерөнхий сайд гэхээс илүү улс төрийн намууд Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын гишүүд ард түмнийг төлөөлөх эрхийг хязгаарлаж байгаа энэ хандлагууд өнгөрсөн 90-ээд оноос өмнө байсан хандлага яг энэ чигээрээ ингээд үргэлжлээд яваад байгаа юм. Тухайлбал, яг үнэндээ Үндсэн хууль дээр “намын бүлэг” гэж ганцхан л үг байдаг. Тэр нь Улсын Их Хурлын дэд даргыг томилохтой холбоотой л асуудал байдаг.

Гэтэл намын бүлгүүд дээр Улсын Их Хурлын гишүүдийг ямар санал өгөх, өгөхгүй, ямар кноп дарах, дарахгүйг шийддэг. Тэгээд жишээлбэл Ардчилсан намын хувьд 2, 3 одтой гээд сонголтууд. Тэрийг дагах заавал ч үгүй шаардлагууд тавьдаг. Ардын нам дээр ч гэсэн яг энэ санаачилга өнгөрсөн онд яваад. Тэгээд бүтэлгүйтсэн.

Энэ нь өөрөө Улсын Их Хурлын гишүүдийг ард түмнийг төлөөлөх идэвхтэй санаачилгатай байх урам зоригийг нь хаадаг.

Тэгэхээр энэ чиглэлээр харагдахгүй байгаа ширээ сандлын талаар хууль санаачлагчид гишүүний хувьд ямаршуу бодолтойг сонсмоор байна

Хоёрдугаарт, Үндсэн хуулийн өөрчлөлтөөр бүгдээрээ давхар дээлтэй болсон. Анх эхэлж 1992 онд Үндсэн хууль батлагдахад Улсын Их Хурлын гишүүн яг Улсын Их Хурлын гишүүнийхээ үүргийг гүйцэтгэхийн тулд өөр ажил завсарч хийхийг нь хориглосон байсныг нь Үндсэн хуулийн өөрчлөлтөөр дөрөвний нэг болгоод, сүүлдээ бүгдээрээ хийдэг болсон.

Өөрөөр хэлбэл танхимын зарчмаар гээд Засгийн газрын гишүүд яг энэ Улсын Их Хурлын гишүүн буюу ард түмний төлөөлөх бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй, энэ саналаа илэрхийлж чадахгүй иймэрхүү нөхцөл байдалд байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбоотой болдог Улсын Их Хурлын тухай хуулиар гишүүн нь хэлэлцэж байгаа асуудлаар үг хэлсэн саналд нь бүрэн эрхийнхээ хугацаанд болон дараа нь ч хариуцлага хүлээхгүй гээд. Тэгээд Засгийн газрын гишүүд хариуцлага хүлээж байна.

Тэгэхээр энэ субъектүүдийг тусад нь суулгаж ялгаж харагдуулмаар. Хэрвээ сандал ширээний асуудал яригдахаар бол гэж харагдаж байгаа. Энэ талаар хууль санаачлагчийн байр суурийг сонсьё.

Дараагийн асуудал нь, хуулийн төсөл дээр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимын асуудлаас гадна Байнгын хороо, дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдааныг яг энэ жишгээр баруун, зүүн талаар нь гэхээр бүлэг, фракцаараа хамгийн олон гишүүнтэй бүлэг, фракц нь зүүн талаасаа эхлэх юм уу гэдэг ч юм уу. Ийм асуудлууд 15.10 дээр орж ирсэн байгаа.

Энэ надад зүгээр илүү заалт юм шиг санагдсан. Хэрвээ энэ зохицуулалтуудыг хуулиар зохицуулахаас гадна түүх авч үзвэл Монголын Юань Ши гээд энэ юун дээр Хятадад зүүнийг дээдэлдэг ёстой. Өөрөөр хэлбэл олонх нь зүүн талаасаа эхэлж байрлалаа эзэлж байгаа бол Монгол ёсонд баруун талаасаа эзэлдэг гээд Юань гүрний үед яг энэ ордны дэг жаягийг өөрчилж байсан байгаа юм.

Гэх мэтчилнээр гээд сандал суудал яривал өөрчлөх уламжлал соёлтой нийцүүлээд өөрчлөх хэрэгцээнүүд гарч магадгүй харагдаж байгаа. Тэгээд саяын хэлсэн саналуудтай хууль санаачлагчийн байр суурийг сонсьё. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Хишигдэмбэрэлийн Тэмүүжин хариулна.

Х.Тэмүүжин: Д.Энхтүвшин гишүүний саналуудтай нэг байна.

Бид чуулганы танхимын суудлын хуваарь болон олонх болсон нам зүүн талдаа суугаад, цөөнх болсон хэсэг нь баруун талдаа суудаг энэ харилцааг ерөөсөө хуулиар зохицуулаагүй. Зүгээр уламжлалаараа явсан.

Бодит байдал дээр хууль тогтоогчид Улсын Их Хурлын гишүүд үүнийг ер нь шийдээгүй.

Ёслолын албаныхны санал болгосноор нэг албан тушаалтан ер нь шийдвэрлэдэг тийм уламжлалаар явсан юм билээ.

Ийм байдлаар бид өөрсдөө эрх мэдлээ бусдад шилжүүлж өгсөнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын чуулганы зохион байгуулалт өөрөө –

- “ардчилсан парламентат ёс”,
- “парламентын ардчилал –

-гэдэг хоёр суурь зарчим руугаа ерөөсөө дөхөж очоогүй.

Эндээс болоод бид ер нь жоохон –

- хязгаарлалттай хууль тогтоох үйл ажиллагаа,
- хязгаарлалттай ард түмнийг төлөөлөх үйл ажиллагаа,
- хязгаарлалттай Засгийн газраа хянах үйл ажиллагаагаа –

-өөрсдөө явуулж байгаа юм билээ.

Тэгээд би Ерөнхий сайд Н.Учралын Улсын Их Хурлын дарга байхдаа хэлээд байсан “Чөлөөлье” гэдэг үгтэй санал нэг байгаа.

Би таны үгтэй санал нэг байна. Парламент буюу Улсын Их Хурал Засгийн газрын дарамт, Засгийн газрын хэт нөлөөллөөс чөлөөлөгдөх цаг нь болсон.

Таны сая хэлсэн шиг бусад улс оронд парламентад ажлаа хариуцан тайлагнадаг Засгийн газрыг ямар байр суурьтай байх вэ гэдгийг Улсын Их Хурал нь өөрсдөө шийддэг юм билээ. Чуулганыхаа энэ зааланд.

Тэгээд Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийг эд бол “ард түмнийг төлөөлөх” гэдэг тэр чиг үүргээ хэрэгжүүлэхгүй. Эд бол гүйцэтгэх эрх мэдлийн буюу кабинетаар ажиллах зарчимдаа үнэнч байх гэдэг тэр зарчим руугаа явна.

Тийм учраас ард түмнийг төлөөлж байгаа бусад Улсын Их Хурлын буюу парламентын гишүүдтэй адилхан хэлсэн, ярьсан, бодлого дэвшүүлснийхээ төлөө хариуцлага хүлээхгүй гэдэг зарчимд хамаарагдах биш, эсрэгээрээ парламентад ажлаа хариуцан тайлагнадаг учраас парламентад худал хэлэхгүй гэдэг, хариуцлагатай үг хэлнэ гэдэг, мэдээллээ үнэн зөв өгнө гэдэг тэр хариуцлагын хүрээнд байгаа шүү гэж тусад нь Ерөнхий сайдын суудал энэ, Засгийн газрын гишүүдийн суудал энэ. Энэ суудал дээрээс Та Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд биш, Засгийн газрынхаа гишүүний хувьд үг хэлж байгаа учраас хариуцлагатай шүү гэдгийг бүр тодорхой зааж өгдөг юм билээ.

Тэгэхээр бид энэ агуулгыг Засгийн газар буюу Ерөнхий сайдад хэлэхээс өөр аргагүй.

Одоо Ерөнхий сайдын суудлыг энэ индрийн дээр буюу спикерийн хажууд тавихаар тэр хүн 126 гишүүний дээр гарч ирээд би тусдаа хүн гээд дээрээс харсан өнгө аястайгаар ажлаа хариуцан тайлагнаж байгаагаа биш. Би намын даргын хувьд би гишүүдийн ихэнхийнх нь хэн байхыг шийдэх тэр хүний хувьд гээд загнасан, зандарсан өнгө аястай болоод хувирдаг юм билээ. Зүгээр сандал суудлын дээр доор байгаа байдлаасаа холбоод ийм ааш, аяг гаргаад эхэлдэг.

Тийм учраас... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут хариулъя.

Х.Тэмүүжин: Тийм учраас парламентын ардчилал гэдэг зарчмыг хангахын тулд, мэтгэлцэх зарчим дээр суурилахын тулд сөрөг хүчинтэйгээ, цөөнхтэйгөө ижил түвшинд мэтгэлцээнийг явуулна.

Мэдээж олонх шийдвэрээ гаргана. Цөөнх хяналт тавина.

Гэхдээ мэтгэлцээн тэнцвэртэй байх гэдэг зарчмынхаа үндсэн дээр энэ мэтгэлцэж байгаа хоёр индрийн харалдаа Ерөнхий сайд нь суугаад, сөрөг хүчний лидер нь суугаад мэтгэлцэнэ.

Засгийн газрын гишүүд нь мөн Ерөнхий сайдынхаа доор суугаад Улсын Их Хурлын гишүүдийн нүдэн дээр энэ хүмүүс Улсын Их Хурлыг хуурахгүй байх ёстой шүү гэдэг, хариуцлагатай шүү гэдэг харагдахуйц тодорхой болох ёстой гэдэг нь зөв юм билээ.

Б.Пүрэвдорж: Д.Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Тэгээд хэрвээ энэ хуулийн төсөл дэмжигдвэл монгол ёс руу нийцүүлж зүүнийг дээдлэх хятад ёс биш, барууныг дээдлэх монгол ёсыг дээдэлж олонх нь баруунаасаа эхэлдэг байх гэх мэтчилэнгийн өөрчлөлтүүд оруулах хэрэгтэй санагдаж байсан.

Түрүүн хэлсэн. Засгийн газрын гишүүд тусдаа нэг тийм боксонд суугаад ч юм уу, хорин хэдэн гишүүн нь тэгж ялгарч харагдахгүй бол гишүүнийхээ хувьд хариуцлага хүлээхгүй чиг үүрэгтэй, Засгийн газрынхаа гишүүний хувьд хариуцлага хүлээх чиг үүрэгтэй хоёр давхар дээлтэй субьекттэй гишүүдийг тусад нь ялгаж суулгах нь зөв байх гэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг нийтдээ 40 гишүүн хамтран өргөн барьсан байгаа.

Ардчилсан намын бүлгийн дийлэнх олонх гишүүд энэ хуулийг хамтран өргөн барьсан.

Яагаад тэгсэн бэ гэхээр өнгөрсөн хугацаанд Монгол Улс ардчиллаас ухарч байна, эрх мэдэл хэтэрхий их төвлөрч байна. Дарга төвтэй нийгэм боллоо гэдэг талаар маш их шүүмж нийгэмд ч байна. Тийм ээ. Тэгээд Ардчилсан намын хувьд ч гэсэн ардчилсан үн Үндсэн хуулийнхаа суурь зарчмыг хамгаалах ардчилсан тогтолцооныхоо дархлааг хамгаалах, парламентын дархлаагаа хамгаалах тал дээр хатуу байр суурьтай зогсож байгаа.

Ер нь яагаад эрх мэдэл төвлөрөөд байна вэ гэдэг дээр олон зүйлийг хэлж болно.

Эрх мэдлийн төвлөрлийг маш олон арга хэрэгслээр бий болгодог юм байна л даа. Хууль тогтоомжоор, институт хоорондын харилцаагаар. Түүнээс гадна орон зайн төлөвлөлтөөр.

Энэ чиглэлээр маш олон философичид, улс төрийн онолчид, тодорхой онолуудыг дэвшүүлсэн байдаг. Тухайлах юм бол Францын философич Мишель Фуко (Michel Foucault 1926–1984) “эрх мэдэл зөвхөн хууль, дүрэм журмаас хамаардаг бус, байгууллагын дотоод зохион байгуулалт, орон зайн төлөвлөлтөөр

илэрдэг” гээд яг энэ хуульд тусгагдсан санаануудыг философийн үндсэн дээр судалсан байдаг.

Тэгэхээр юу яригдаад байна вэ гэхээр парламент бол төрийн эрх барих дээд байгууллага. Энэ парламент –

- Засгийн газраа томилж байгаа,
- Ерөнхий сайдаа томилж байгаа.

Гэтэл парламентын танхимынх нь өөрийнх нь зохион байгуулалт нь Ерөнхий сайд нь дээрээ гараад суусан. Их Хурлын даргын суудлын хажууд Ерөнхийлөгчийн суудал байж байдаг.

Тэгэхээр энд дарга төвтэй буюу төрийн гурван өндөрлөг гэж ярьдаг энэ зүйл чинь энэ танхимаас эхлээд байна. Яг үнэндээ төрийн гурван өндөрлөг гэдэг нэр томъёо хаана ч байхгүй. Зөвхөн энд ингээд гурван сандалыг зэрэгцүүлээд парламентынхаа танхим дотор тавьсанаас болоод байна гэдэг асуудал.

Тэгэхээр Ерөнхий сайд парламентаасаа томилогдоод парламентдаа тайлагнадаг юм бол яагаад парламентынхаа дотор харилцан эрх тэгш байдлын хүрээнд ярихгүй байгаа юм бэ гэдэг зүйлийг бид ноднингоос хойш ярьж эхэлсэн.

Түүний хүрээнд өнөөдөр үдээс хойш болох Улсын Их Хурлын асуулгын цагийг санаачилсан байгаа. Асуулгын цагийн хүрээнд Ерөнхий сайд индрээсээ бууж ирээд энд сөрөг хүчний гишүүдтэй, Улсын Их Хурлын гишүүдтэй яг нэг түвшинд мэтгэлцэхлээр ямар байдлаар хэлэлцүүлэг өөрчлөгдөж байна вэ гэдгийг хүмүүс харж байгаа байх.

Тэгэхээр хойморт байгаа гурван суудлыг буулгаад зөвхөн Их Хурлын даргын буюу хурал даргалагчийн суудлыг үлдээгээд, нөгөө хоёр суудлыг нь авч хаях нь эрх мэдлийн төвлөрлөөс хэлбэрийн хувьд, орон зайн төлөвлөлт, зохион байгуулалтын хувьд гарах маш чухал ач холбогдолтой.

Тэгээд өчигдөр Х.Баасанжаргал гишүүн хэлэлцүүлгийн үед ярьж байсан. Тэнд аливаа асуудал зөвхөн тэр нэг дээгүүр байгаа хэдэн дарга нарын хүрээнд шийдэгдээд байна гэдэг.

Тэгэхээр тэр төвлөрлийг сааруулахын тулд бас энэ хуулийг дэмжээч ээ гэж хүсэж байгаа юм. Тэр яригдаад байгаа нөхдүүд чинь суудал нь хүртэл өөр байна. Өнөөдөр дарга төвтэй нийгэм яаж илэрч байна вэ гэхээр хамгийн том дарга нь хамгийн олон хаалганы цаана очоод суудаг. Тэр хаалганы цаадах руу иргэд нэвтэрдэггүй. Тийм ээ. Их Хурлын гишүүд нь ч хүртэл нэвтэрч чадахгүй байгаад байна шүү дээ.

Тэгэхээр ийм орон зайн хувьд хүртэл ийм алдаа дутагдалтай. Энэ зохион байгуулалтаасаа татгалзъя. Тэгж байж парламентын танхимыг яг нээлттэй мэтгэлцээний талбар болгоё. Тэгж байж Засгийн газар нь парламентдаа тайлагнадаг тогтолцоог бий болгоё гэж ярьж байгаа.

Ерөнхийлөгчийн суудлын хувьд ч тэр. Ерөнхийлөгч бол улсын эв нэгдлийг илэрхийлэгч хүн. Ерөнхийлөгчийн суудал наадмын талбай дээрээ гоё, хамгийн гоё. Хойморт нь байх ёстой. Энэ танхимд тааллаараа оролцож байгаагийн хувьд заавал энд ингээд тусгай суудал зассан байх шаардлагагүй л гэж... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Х.Тэмүүжин хариулна.

Х.Тэмүүжин: Би Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг уншиж өгье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1 Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх бөгөөд ард түмэн энэхүү эрхээ шууд болон өөрсдийн сонгон байгуулсан төлөөллийн байгууллагаар уламжлан хэрэгжүүлнэ.

Хорьдугаар зүйл. Төрийн эрх барих дээд байгууллага бол Улсын Их Хурал мөн.

Хорин нэгдүгээр зүйл. Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй.

Энд Ерөнхий сайдтай гэж ерөөсөө хэлээгүй. Харин Гучин наймдугаар зүйл. Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага.

Дөчин нэгдүгээр зүйл. Засгийн газрыг Ерөнхий сайд удирдаж, Улсын Их Хурлын өмнө ажлаа хариуцан тайлагнах.

Ийм зохицуулалттай. Улсын Их Хурлын дарга Засгийн газрын хуралдаан дээр Засгийн газрын кабинетын тэргүүлж байгаа Ерөнхий сайдын хажууд сандал тавиад суувал маш зохимжгүй бөгөөд бүдүүлэг зүйл болно.

Гэтэл Улсын Их Хурлын чуулган дээр Улсын Их Хурлын даргын хажууд Ерөнхий сайд яг феодал ноёд шиг тусдаа ширээ сандал засуулаад сууж байгаа нь өөрөө бид Үндсэн хуулийн суурь зарчмуудыг зөрчсөн Үндсэн хуульд үл нийцсэн чуулганы зохион байгуулалтын хэлбэртэй байж байгаа.

Үүнийг л бид Үндсэн хуульд нийцүүлж засах хэрэгцээ шаардлага байгаа. Энэ бол Үндсэн хуульд заасан эрх мэдэл хуваарилалтын зарчмыг хангуулахад зорино. Мөн хяналт тэнцээнийг бэхжүүлэхэд зорино.

Хамгийн гол нь Үндсэн хуульд баталгаажиж хамгаалсан парламентын ардчиллыг мэтгэлцээнтэй, эн тэнцүү олонх, цөөнх үгээ хэлдэг. Мэдээж олонх

шийдвэрээ гаргана. Гэхдээ цөөнх хяналт тавих чадвартай болох зарчмыг хангуулж байгаа.

Хамгийн гол нь дахиад “парламентат ёс”. Олон улсад “парламентат ёс” гэдэг зүйлийг юу гэж хэлдэг вэ гэхээр энэ бол парламентын засаглал. Улсын Их Хурал буюу парламент нь Засгийн газраа хянах чадвартай байх тухай яриа. Засгийн газар нь парламентад хянагдаж ажлаа үнэн зөв тайлагнах тухай яриа.

Тэгэхээр энэ зарчмыг хангуулахад сандал суудал, орон зайн буруу зохион байгуулалт, төлөвлөлт маань садаа болоод Үндсэн хуулийн бус дэг журмыг парламентын чуулган дотор бий болгоод байна гэдэг өнцгөөс энэ хуулийг санаачилсан юм.

Тийм учраас гишүүд энэ хуулийг дэмжиж, “парламентын ардчилал”-ыг “парламентат ёс”-ыг Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн суурь үзэл санаа, зарчмуудын төлөө саналаа өгнө гэдэгт итгэж байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хариулж дууслаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

С.Эрдэнэболд гишүүн индрийн 2 дугаар микрофон.

С.Эрдэнэболд: Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын Улсын Их Хурлын гишүүдийн хамтран санаачилж байгаа Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дэмжиж үг хэлье.

1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа баталсан.

Тус оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 12 цаг 00 минутаас энэ хууль маань хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Монгол Улс ингэснээрээ эргэлт буцалтгүй “парламентын засаглалтай орон” болсон.

Парламентын засаглалтай орон гэдэг бол хувь хүнээр бус хуулиар зохицуулагддаг нийгэм, эдийн засаг, оюун санааны эргэлт буцалтгүй шилжилтийг бид хийж чадсан.

Энэ ардчилсан Үндсэн хууль 1990 оны цагаан морин жилийн ардчилсан хувьсгалын шууд үр дүн байсан бөгөөд олон жил монголчуудын хүсэн хүлээсэн эрх чөлөөний тэмцлийн үр дүн байсан.

Ингээд Монгол Улс өөрийн гэсэн бүрэн эрхт байдалтай, тусгаар тогтнолтой, Үндсэн хуультай, ардчилсан тогтолцоо руу ард түмнийхээ хүсэл эрмэлзлийн дагуу орж чадсан үйл хэрэг байсан юм.

Сүүлийн жилүүдэд ардчиллын үзэл санааг гутаан доромжлох, чөлөөт нийгмийн үзэл санааг гутаан доромжлох, ардчиллын үнэ цэнийг гуйвуулах хандлагууд гарч байгаа.

Үүний нэг том шалтгаант нөхцөл нь парламентын засаглалыг буруутгах, парламентын засаглалыг муухай харагдуулах, парламентад ёсыг үнэгүйдүүлж хүчгүйдүүлэх зүйл хэрээс хэтэрсэн юм.

Энэ ч үүднээс бид парламентын дархлааг бэхжүүлж, парламентын соёлыг эргэлт буцалтгүйгээр нэвтрүүлэхэд олон улсын жишиг болсон зохицуулалтыг зайлшгүй ханган хэрэгжүүлэх ёстой улс.

Энэ үүднээс бид энэ хуулийг дэмжиж байгаа юм. Учир нь Монгол Улс парламентын засаглалтай орны хувьд парламентад ёсыг хэлбэрэлтгүй сахиулах нь хэлбэрийн төдий биш агуулгынх байх ёстой. Агуулгаасаа гадна үзэгдэх, харагдах орчны хувьд ч гэсэн хүмүүсийн сэтгэл зүйд хуулийн агуулга нийцэж байх ёстой гэж үзэж байгаа.

Энэ үүднээс Монгол Улсын Засгийн газарт хяналт тавих ёстой. Парламент нь өөрөө Монгол Улсын гүйцэтгэх засаглалын байгууллагын үг яриаг дуулгавартайгаар сонсож байдаг байдлыг халах үе шаттай зүйлс нь өөрөө Үндсэн хуулийн зарчимтай нийцэж байна гэж үзэж байгаа.

Энэ ч үүднээс Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл хийдэг байсан цагийг асуулгын цаг болгосон. Ингэснээрээ бүрэн биш ч гэсэн мэтгэлцээний хувилбар луу бид чиглэж орж байгаа.

Ингэснээрээ индэр дээр Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсын Их Хурлын гишүүдийн, дээрээс нь сөрөг хүчний зарчмын аргумент асуултуудад хариулдаг. Дээрээс нь бэлдсэн зүйлээ уншдаг, өөрөө ирдэггүй, оролцдоггүй байсан зүйлийг бид халж чадсан.

Х.Тэмүүжин нарын гишүүдийн санаачилсан өнгөрсөн 10 дугаар сараас соёл болоод хэрэгжээд явж байгаа зүйл.

Нөгөө талаасаа парламентын засаглалтай олон орны хувьд гүйцэтгэх засаглал нь өөрөө парламентад ажлаа тайлагнахын хувьд индэр дээр гараад

ярьж байгаатай адилхан дарга болж тэр дээр суудаг биш, жирийн парламентын гишүүн гэхээсээ гадна гүйцэтгэх засаглалын кабинетын хувьд хариуцлага хүлээж үгээ хэлж тайлагнадаг байх ёстой.

Тийм ч үүднээс зүгээр нэг сандал суудлын дээр доорын яриа биш. Энэ цаад утгаараа агуулгын хувьд түүхэн шинэчлэлт, шилжилтийн чанартай хуулийн зохицуулалт гэж ойлгож болно.

Тийм учраас бид парламентат ёсоо дархлааг нь сайжруулахын тул Монгол Улсын Ерөнхий сайдыг Их Хурлын индрийн цаана метр 50 сантиметрийн өндөртэй тэр товцог ширээн дээр Их Хурлын даргын зэрэгцээ, Ерөнхийлөгчийн зэрэгцээ суудаг биш яг парламентынхаа дунд кабинетаараа суудаг байх шаардлага зарчмын шинж чанартай зүйл.

Ингэснээрээ парламентын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдад загнуулдаг биш, чиглэлийг нь хангадаг биш, Монгол Улсын Их Хурал нь өөрөө парламентын хуулийн хэлтэс шиг ажилладаг биш жинхэнэ дархлаатай ажиллах боломж бүрдэнэ гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут үг хэлнэ.

С.Эрдэнэболд: 1726 онд Шарль де Монтескьё (Charles de Montesquieu 1689–1755)-ийн гаргасан “Хуулиудын амин сүнс” ном дээр эрх мэдэл хуваарилах онолыг тодорхойлсон байдаг.

Ингэхдээ –

- хууль тогтоох,
- гүйцэтгэх,
- шүүх эрх мэдэл –

-гэж 3 хуваасан байдаг.

Өнөөдөр Монгол Улс та нар википедия дээр ороод харах юм бол semi-presidential буюу хагас Ерөнхийлөгчийн засаглалтай.

- ▶ Ерөнхийлөгч нь хүний нөөц шийддэг.
- ▶ Ерөнхийлөгч нь төсөвт оролцдог.

Ингээд парламентын бүрэн эрхийг бүдгэрүүлдэг зүйл болсон.

Дээрээс нь гүйцэтгэх засаглал бөгөөд Ерөнхий сайдын кабинет нь болох юм бол илүү эрх мэдэлтэй дарга юм шиг. Уг нь илүү үүрэг хүлээдэг гүйцэтгэгч, хуулийг хэрэгжүүлэх ёстой байтал энэ зүйл урвуу хамааралтай болсон.

Тийм учраас энэ хуулийг дэмжих нь өөрөө засаглал хуваарилах онолын буюу checks and balances-ийг амьд байлгах зайлшгүй нөхцөл бөгөөд, гарцаагүй аргумент гэж үзэж байгаа учраас энэ хуулийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Улсын Их Хурлын гишүүд дэмжиж өгөхийг хүсье.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Равжихын Эрдэнэбүрэн үг хэлнэ. Индрийн 2 дугаар микрофон.

Р.Эрдэнэбүрэн: Эрхэм гишүүд ээ, парламентын засаглалтай улсад маш чухал шаардлагатай хэлбэрийн хувьд нэг сандал суудлын байрлал ярьж байгаа юм шиг мөртлөө маш чухал шаардлагатай хуулийн төсөл байгаа юм.

Сая ч яригдаж эхлээгүй. Олон жил манай Х.Тэмүүжин гишүүн ярьж байсан. Ийм сэдэв. Тэгээд Их Хурлын дэд дарга аа, Ерөнхий сайд бол олонхоо төлөөлж ярьж байх ёстой. Олонхынхоо бодол санаа, төсөв, төлөвлөгөө бүх юмыг ярьж байх ёстой ийм хүн байгаа.

Тэгээд олонхынхоо өмнө суугаад цөөнх рүүгээ харж суугаад ярьж байх ёстой. Парламентын мэтгэлцээн гэдэг юм чинь тэндээс гарч ирэх гээд байгаа юм.

Тэгэхгүй тэр дээр суухаар яаж байна вэ гэхээр олонхтойгоо мэтгэлцээд байгаа байхгүй юу. Ерөнхий сайд чинь. Цөөнхтэй ч мэтгэлцэнэ, олонхтойгоо ч мэтгэлцэнэ.

Гэтэл олонх бүлэг дээрээ, цөөнх ч бай бүлэг дээрээ бүх юмаа яриад, тэр олонх бүлэг дээр ярьсан юмаа Ерөнхий сайд цөөнхтэй мэтгэлцэж байх ийм л позицтой, байр суурьтай, сандалтай байх ёстой гэж бодож байгаа юм.

Ингэж байж парламент суудалтай намуудын үзэл санааны ялгаа, бодлогын ялгааг гаргаж ирэхгүй бол одоо бид нарт ямар хүндрэл учраад байна гэхээр аль нь ч ялгаагүй болсон, ялагдахаа больсон. Одоо жишээлбэл манай олонх 12 жил засаг барьчхаад байж байгаа мөртлөө гэнэт сая гарч ирсэн юм шиг л ярьж байгаа шүү дээ.

Хөөе, энэ чинь юу болов оо. Эдийн засаг чинь ямар хэцүү болов оо. Авлигал чинь ямар хэцүү болов оо гээд нөгөө олонх чинь арван хэдэн жил засаг барьчхаад гарч ирснээ Ерөнхий сайд руугаа баахан юм ярьцаагаад суугаад байгаа юм.

Тийм учраас энэ ялгаагаа гаргаж аль нам нь ямар үзэл санаатай байгаа юм, ямар бодлоготой байгаа юм гэдгийг гаргахын тулд Ерөнхий сайд олонхоо төлөөлөөд олонхынхоо дунд суугаад цөөнх руугаа харж суугаад тэгээд олонхоо төлөөлж ярьдаг байх ёстой. Олонх бүлэг дээрээ бүх юмаа зангидаад гараад ирсэн байх ёстой.

Тэгэхгүй олонх чинь энд орж ирээд бүлэг дээр зангидаж чадаагүй юмаа Ерөнхий сайдтайгаа энд орж ирээд маргаад суугаад байгаа шүү дээ.

Тийм учраас хэлбэрийн хувьд Ерөнхий сайдын сандалыг өөрчлөх гээд байгаа биш ээ. Энэ цаанаа гүн агуулгатай юм. Цаашлаад намуудын үзэл санаа, улс төрийн бодлого, бүх юмыг ялгаж харуулах чухал зүйл юм.

Ингэснээрээ парламент өөрөө цаашдынх нь парламентын хөгжилд тодорхой чухал үр дүн үзүүлнэ гэж бодож байгаа.

Тийм учраас дэмжиж байгаа гэдгээ хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Р.Эрдэнэбүрэн гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг 16.00 цагт нэгтгэн явуулна. Үдээс өмнөх чуулганы хуралдаан завсарлалаа. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

С.Бямбацогт: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Арван хоёр. Улсын Их Хурлын асуулгын цаг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.1-д ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан гишүүдээс Ерөнхий сайд хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн байдал болон бусад асуудлаар асуулт тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна гэж заасан.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан процессын дагуу өнөөдрийн асуулгын цаг хэлэлцэгдэнэ. 2 цагийн дотор дуусах ёстой.

Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа цөөнхийн бүлэгт 75 минутаас, олонхын бүлэгт 15 минутаас, цөөнхийн гишүүдэд 30 минутаас хэтрэхгүй байна гэж тус тус заасан.

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн О.Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал нарыг тусгайлан бэлдсэн индэрт урьж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавьж мэтгэлцэнэ.

Бүлгийн цуварсан асуултын тоог 09-өөс хэтрүүлэхгүй, асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэлд микрофон өгье.

О.Цогтгэрэл: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Энэ удаагийн асуулгын цагийн сэдэв цаг үеийн халуун сэдэв болж байгаа татварын асуудлаар, тэр тусмаа Монгол Улсад татварын нөхцөл байдал өнөөдөр ямар байна.

Татвараас улбаалсан төр, төрийн томролт, төрийн дарамт ямар байгаа билээ. Үүнийг цаг хугацаатайгаар тодорхой асуултууд тавья.

Тэр тусмаа сүүлийн 10 жилийн эдийн засаг, улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, Засгийн газраас, эрх баригчдаас явуулсан бодлогын талаар бид төвлөрч асууна.

Яагаад 10 жил гэж байна гэвэл 10 жил өөрөө бас бодлого дэвшүүлээд, бодлогын үр дүнгүүд гарсан байх ёстой. Аль хэдийн гарсан. Буруу зөвийн дэнс дээр шүүгдсэн байх ийм цаг хугацаа.

2016 оноос харьцуулаад яривал 2016 онд Монгол Улс татвараар 5 их наяд төгрөг цуглуулдаг байжээ. Одоо 29 их наяд төгрөг цуглуулж байна. Татвараар.

Тэгэхээр 10 жилийн хугацаанд аж ахуйн нэгж, бизнес иргэдээс авч байгаа татварын хэмжээ бараг 6 дахин нэмэгдсэн. Бараг 6 дахин.

Тэгэхээр Засгийн газрын татвар 6 дахин нэмэгдсэн бол өнгөрсөн 10 жилийн хугацаанд иргэдийн орлого 6 дахин нэмэгдээгүйг асуусан, асуугаагүй тодорхой.

Энэ 6 дахин нэмэгдээгүй. Энэ хугацаанд ядуурал 10 жилийн хугацаанд бараг 1 процентоор ч буурсангүй.

Төр 6 дахин томорсон. Татвар 6 дахин ихэссэн. Ядуурал 1 процентоор буураагүй. Дундаж давхарга агшсан. Түгжрэл, юу юу байдаг юм, энэ бүгдийг яривал одоо энэ 10 жилд бодлогын өөрчлөлт гарсангүй.

Тэгэхээр энэ бодлогын алдаа байсан гэдэгтэй Та санал нийлж байна уу? Бодлогын ямар алдаа байсан? Эхний ээлжид “тийм”, “үгүй” гэж хариулаад өгмөөр байна. 10 жилд бодлогын зөв байсан уу, буруу байсан уу?

С.Бямбацогт: Ерөнхий сайдын микрофон.

Н.Учрал: О.Цогтгэрэл даргад баярлалаа.

- 2016 онд хүн амын тоо 3 сая 63 мянга 568 байсан.
- 2026 онд хүн амын тоо 3 сая 425 мянгад хүрсэн.

Манай нэрлэсэн дотоодын нийт дотоодын нийт бүтээгдэхүүн 29.9 их наяд байсан. Өнөөдөр манай дотоодын нийт бүтээгдэхүүн 89.9 их наяд хүрсэн.

Тэгэхээр 10 жилийн хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүн тэлсэн, хүн ам өссөн.

Төрийн албан хаагчдын тоон дээр эргээд харахад төрийн захиргааны албан хаагчид гэхээсээ илүүтэйгээр төрийн үйлчилгээний албан хаагч нарын тоо өссөн.

6-аас 18 нас буюу сургуулийн насны хүүхдүүд 260 мянгатай л байсан. 2016 онд. Өнөөдөр 455 мянга буюу бараг хоёр дахин өссөн.

Тэгэхээр төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо түүнийгээ дагаад өссөн гэсэн үг.

Төрийн захиргааны албан хаагчдын тоог эргээд харахад яамд 2 мянга хүрэхгүй л хүнтэй.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо яагаад өсөж байна вэ гэвэл хүүхдүүдийн тоо, хүн амын тоо өсөөд эхлэхээр сургууль, цэцэрлэгт ажиллах багш, эмч болоод бусад үйлчилгээний албан хаагчдын тоо түүнийгээ дагаад өсдөг.

Тийм учраас хүн амын тоотой холбоотой асуудал гэж хэлж болно. Харин алдаа байсан уу гэвэл алдаа байсан.

▪ Төсвийн бодлого, мөнгөний бодлого хоёроо уялдуулж чадаагүй.

Мөн бид өнгөрсөн хугацаанд хуримтлал үүсэж байгаа эдийн засгийн өсөлтийн үеийг зөв, бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй. Олсныхоо хэрээр үрсэн. Алдагдалгүй төсөв батална гэж улс төржилтийн их хор гайгаар олсныхоо хэрээр үрдэг болсон. Урсгал зардал нэмэгдсэн.

Тийм учраас бид илүүтэйгээр төсөв, мөнгөний бодлогыг уялдуулах бодлогыг барих зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүн бүрийг дэмжих... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: О.Цогтгэрэл гишүүн тийм.

О.Цогтгэрэл: Тэгэхээр таны хариултыг сонсохоор зайлшгүй нийгмийн үйлчилгээ болон төрийн албаны олон олон зүйлүүдтэй холбож байна.

Гэтэл яг үнэндээ би танд тавьсан асуулт бол гол нь иргэдийн орлогын тухай л ярьсан л даа. Төрийн татварлалт 6 дахин нэмэгдээд байхад иргэдийн бодит орлого яагаад нэмэгддэггүй юм бэ? Тэр байтугай тэр ядуурлын 28, 29 гэдэг тоо, хувь процент яагаад буурдаггүй юм бэ?

Тэгэхээр үүнтэй холбоотой зөвхөн татвараасаа гадна татвар гэдэг хууль дээр байгаа тоо хэмжээ. Энэ татвар дээр чинь нэмэх нь албан бус далд татвар байна. Инфляц. Энэ чинь тэр эмзэг дунд давхарга руу чинь асар их хүчтэй нөлөөлж байгаа. Инфляц одоо хоёр оронтой тоо даваад гараад яваад өглөө.

Дахиад дээрээс нь албан бус айхтар татвар чинь энэ авлигажсан төр. Тэр ар өврийн хаалгаар гар хүндрүүлж асуудал шийддэг. Энэ бүгдийг нийлээд үзэх юм бол Монголын төр дэх татварлалт чинь. Хуульд заасан болоод хуульд заагаагүй татварлалт гэдэг зүйл хэрээс хэтэрсэн.

Яг энэ татвартай холбоотой би 2016 оны, 2020 оны, 2024 оны танай намын сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдийг дарга нарын зураг бүхий мөрийн хөтөлбөрүүд байна л даа. Татвар нэмэхгүй гээд тов тодорхой 3 мөрийн хөтөлбөр, 3 сонгуулийн амлалт дээр тов тодорхой бичсэн.

Гэтэл энэ хугацаанд тоогоороо 17 татвар нэмж авчээ. Заримыг нь шинээр бий болгож зарим татваруудыг.

Тэгэхээр энэ нь танай нам мөрийн хөтөлбөрөөсөө буцсан, ухарсан, мөн сонгогч ард иргэдийг хууран мэхэлсэн гэсэн үг мөн үү? Энэ дээр Та нэг “тийм”, “үгүй” гээд хариулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя. Н.Учрал Ерөнхий сайдын микрофон.

Н.Учрал: Татварын ерөнхий хуульд заасны дагуу нийт 30 төрлийн татвар байгаа юм. 27 төрлийн татвар байна.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд яг нэмэгдсэн татваруудыгаа би харж үзлээ.

— Онцгой албан татвар нэмэгдсэн.

— Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ нэмэгдсэн.

Үүнд юу ордог вэ гэхээр согтууруулах ундаа, тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар нэмсэн байна лээ.

Хувь хүний орлогын албан татварыг анх удаа прогрессив болгосон. Шаталсан татварын тогтолцоо руу шилжүүлсэн. Нийслэл хотын албан татварын хувь хэмжээ 1 байсныг 2 хувь болгосон юм.

Мөн нөгөө онцгой албан татвар дээр согтууруулах ундааг 2 жил тутам үе шаттайгаар нэмэгдүүлэх хуулийг баталсан учраас нэмэгдээд явж байгаа. Агаарын бохирдлын төлбөр гээд эдгээр татвар төлбөрүүд нэмэгдсэн.

Бид татварыг нэг зүйлээр тайлбарлах ёстой. Юу вэ гэхээр татвар өөрөө төсөв бүрдүүлдэг гол хэрэгсэл биш. Татвар нийгмийн баялгийг тэгш хуваарилдаг механизм.

Тийм учраас манайх шиг оронд шаталсан татварын тогтолцоо руу шилжих ёстой гээд хамгийн эхний том дэвшил бол хувь хүний орлогын албан татвар байсан. Хувь хүний орлогын албан татвар 10 саяас орлого нь давсан тохиолдолд 10-аас 15 сая дээр давсан орлого дээр нь 15 хувийг нэмдэг. 15-аас нэмэгдээд эхлэхээрээ 20 хувийг нэмдэг буюу өндөр төлж байгаа, өндөр орлого олж байгаа компани, аж ахуйн нэгжүүдүүдээс татвар хурааж эргээд дундаж давхаргаа, бага орлоготой иргэдийгээ дэмждэг энэ механизм.

Ингэснээр эрүүл мэнд, боловсролын салбар, төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгддэг.

Тийм учраас татвараар дамжуулж бид чинээлэг дундаж давхаргыг бий болгох зорилгоор энэ шаталсан татвар луу 2022 онд шилжсэн байхгүй юу.

Тэгэхээр өнөөдрийн яригдаад байгаа сэдвүүд болохоор энэ хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгоё ч гэдэг юм уу, ийм сэдвүүд өөрөө бид чинээлэг дундаж давхаргынхаа эсрэг... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: О.Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Тэр татвар хураамж нэмэгдсэн эсэх гэдэг дээр “тийм”, “үгүй” гэдгийн шаардлага ч байхгүй л дээ. Тэр бол тодорхой.

Энэ дотор чинь яривал олон олон зүйл.

- Үл хөдлөхийн татвар,
- Хотын татвар,
- Автомашин бүхий иргэдийн –

-асар олон том дүн бүхий 17 татвар хураамжийн тухай бид ярьдаг.

Үүнтэй холбоотой татварууд нэмэгдсэн. Бүгдийг үгүйсгэж бас болохгүй. Нэг татварыг уг нь бууруулах оролдлого хийсэн. Бууруулсан.

Хагас жилийн өмнө төсөв дээр Г.Занданшатар Ерөнхий сайдын үед Та Эдийн засгийн хөгжлийн сайд байхад санагдаж байна. Тодорхой шатлал бүхий НӨАТ-ын чөлөөлөлт, буцаан олголтыг нэмэгдүүлэе гэдэг ганц гайгүй иргэдэд ээлтэй нэг хуулийг өнгөрсөн хагас жилийн өмнө батлагдсан.

Одоо үүнээсээ Та Эдийн засаг, хөгжлийн сайд байх үеийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөсөө одоо Ерөнхий сайд болоод буцаж байна л даа.

Яг энэ татвар чинь өөрөө Та нарын яриад байдаг тэр бага, дунд орлоготой иргэд рүүгээ чиглэсэн олон олон өөрчлөлт чинь уг нь энэ татварт байсан.

Одоо бидний ярьж байгаа Та бүгдийн өргөн барьж байгаа татвар чинь далд эдийн засгийг дэмжсэн, татварын суурийг нэмэгдүүлэхэд чиглээгүй, татварын тэгш, шударга өрсөлдөөнтэй байх зарчмыг энэ системийнхээ эсрэг, тэр тусмаа хөдөлмөрлөдөг, бүтээдэг, орлого олдог, илүү их хөдөлмөрлөснөөс нь илүү их татварлана гэдэг. Харин бидний тогтож ирсэн зах зээлийн эдийн засгийн үнэт зүйл рүүгээ халдсан татварын өөрчлөлтийг Та бүхэн өргөн барьж байгаа.

Ганц гайгүй байж болох татварын өөрчлөлтөөсөө буцаад одоо яг тэрнийх нь эсрэг бүр суурь системүүдийн эсрэг далд эдийн засгийг яаж дэмжих тэр тэгш, шударга өрсөлдөөнийг, татварын суурь өргөтгөхөд чиглэсэн биш яг энэ бүгдийн эсрэг ийм үндсэндээ бодлогын асар том... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд хариулья.

Н.Учрал: Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт хөдөлмөрлөж байгаа хэн бүрийг дэмжих бодлого.

Хувь хүний орлогын албан татварын 1 хувийг 1 хувь болгоё гэдэг яг хэнийг дэмжсэн бодлого юм бэ. Яг хэнийг дэмжсэн.

10 сая төгрөгийн орлоготой компани, аж ахуйн нэгж, иргэнээс 1 хувь. Иргэнээс. 1 сая төгрөгийн цалинтай иргэнээс дахиад 1 хувь. Одоогийн хэрэгжиж байгаа 2022 оны хууль бол 10 саяас дээш давсан орлогоос 15 хувь. Давсан орлогоос шүү дээ. 15 саяас дээш гарвал давсан орлогоос 20 хувь. Илүү орлого олж байвал илүү төл гэдэг зарчим. Илүү орлого олж байвал илүү төл. Тэгж байж чинээлэг дундаж давхарга бий болгодог. НӨАТ-ын буцаатыг нэмэгдүүлэх нь хэнд ашигтай юм. Өнөөдөр энгийн иргэн хүнсний бараа, бүтээгдэхүүн авна. 20 мянган төгрөг авдаг байсан бол 40 мянган төгрөг, 10 мянган төгрөг байсан 20 мянган төгрөг авдаг болно.

Гэтэл 300 сая төгрөгийн машин авч байгаа хүн хэдэн төгрөг авах вэ. НӨАТ-ыг 2 хувь нэмэгдүүлвэл. Хэн хожоод байгаа юм энд.

Тэгэхээр энэ хэрэглээг дэмжсэн бодлого байхгүй юу. Хөдөлмөрлөж байгаа хүнийг дэмжинэ гэдэг бол хувь хүний орлогын албан татварын татварыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэглэнэ буюу 792 мянган төгрөг дээрээс нь тэглэвэл тэр хүн 79200 төгрөгийг өөртөө үлдээнэ гэсэн үг. 3 саяын цалинтай хүн 2 сая 200-саа хувь хүний орлогын албан татвар төлнө. Гэтэл бүгдийг нь нэг болгоно гэхээр наана чинь 10 саяын орлоготой хүнээс хүртэл 1 л хувь авна гэдэг чинь юу гэсэн үг юм. 100 мянган төгрөг авах юм уу. 10 саяын цалинтай хүнээс. Тэгээд яаж энэ нийгмийнхээ үйлчилгээг авч явах юм. Дундаж давхарга яаж авч явах юм.

Жишээ нь, одоо Та бод. Бараг 20-оос 80 хувийг бүрдүүлж байгаа шүү дээ. Аймгууд. Зүгээр Архангай аймаг л гэхэд бараг 61 хувь юм байна лээ шүү дээ.

Тэгээд тэр аймаг, орон нутаг яаж бие дааж үйл ажиллагаагаа явуулах вэ?

С.Бямбацогт: О.Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Харин тийм. Таны ярьж байгаа чинь яаж энэ хөдөлмөрлөж байгаа, яаж илүү одоо ухаан бодлоо уралдуулж, хөдөлмөрөө зарцуулж, орлого олсныг нь хэрхэн яаж тайрч тэгшитгэх вэ гэдэг яг сонгодог зүүний социалист бодлого, зүүний гэж хэлэхэд багадаа. Өсөн нэмэгдэх ч гэж янз бүрээр хэлдэг. Яг л одоо ийм л бодлого.

Яг үнэндээ хүн амын орлогын албан татварын тухай ярихад монголчуудын тэр хүн амын орлогын албан татварын бүтцийг харахад тэрний чинь бараг 60, 70 хувь нь зөвхөн цалингийн орлого байна гэсэн. Цалингийн орлого. Тэгвэл тэр цалин авч байгаа иргэд гэдэг чинь, цалин авч байгаа хүн гэдэг чинь хөдөлмөр хийж байгаа хүн. Халамж биш. Хөдөлмөр хийгээд хөдөлмөрийнхөө хөлсийг авч байгаа хүн. Тэр хөдөлмөрийнхөө хөлсийг авч байгаа хүнийг бид дарамтална. Их л ажиллавал ихийг авна. Та нараас.

10 байсан 15 болгоно. 15 биш одоо бүр дахиад даблдаж авна. Угаасаа тэр чинь 10 хувь гэдэг чинь абсолют дүнгээсээ хувь процентоороо их л гардаг юм байгаа биз дээ.

Тэгэхээр энэ чинь одоо үнэхээр бас энэ улс орныг одоо хойш нь чангаая. Энэ улс орныг тэр чөлөөт эдийн засаг. Та өөрөө бас тэр талд хааяа дуугараад байдаг юм. Үүнээсээ яг одоо үндсэндээ ухарсан буцсан ийм л бодлогыг л Та ярьж байна.

Жинхэнээсээ наад хүн амын орлогын татвар, энэ цалин гэдэг чинь хөдөлмөрийн орлого. Хөдөлмөр гэдэг чинь, хөдөлмөрлөж байгаа хүн гэдэг чинь жинхэнэ Та бидний яриад байдаг тэр дундаж давхарга чинь үүний цаана л байгаа. Дундаж давхаргыг, дундаж давхаргынхаа эсрэг бодлого л Та бүхэн ингэж сурталчилж байна.

Тэгээд түүх ярихад Ардчилсан намын хувьд 4-н 10-ын татвар гэж ямарваа нэг нь өсөн нэмэгдэх олон зүйлгүйгээр яг тов тодорхой бүгдээрээ 10 хувь төлдөг.

- ▶ Хүн амын орлогын албан татвар,
- ▶ НӨАТ-ын татвар,
- ▶ нийгмийн даатгалын шимтгэл.

Энэ бүгдийг чинь тов тодорхой, ойлгомжтой. Энэ чинь өөрөө эдийн засгийн өсөлтийг чинь дэмждэг гэдгийг хүн төрөлхтний эдийн засгийн энэ онол номынх чинь түүх нь батлаад өгсөн зүйл шүү дээ.

Илүү хөдөлмөрлөснийг нь илүү тайрна. Үүнийг... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд хариулья.

Н.Учрал: Цогоо даргын ярьж байгаа бол Та яг ярьж байгаагаа эсрэг яриад байна л даа.

НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлье гэдэг хэрэглээг дэмжиж байгаа байхгүй юу. Би хөдөлмөр эрхлэлтийг дэмжье гээд байгаа юм.

700 мянган төгрөгийн худалдан авалтаас 37 мянган төгрөгийг буцааж олгоод хэнд ашигтай байгаа юм. Харин авч байгаа цалинг нь 792 мянгыг чинь тэглэвэл хөдөлмөрлөж байгаа хүнийг дэмжих бодлого байхгүй юу.

НӨАТ-ын суутган төлөгчийн босго 50 сая байгаа. Тэрийг 400 сая болгоё гэдэг чинь юу юм бэ гэхээр тэнд 23 мянган суутган төлөгчийг босгож ирэх гээд байгаа байхгүй юу.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар жилд 1.5 тэрбумаас доош байвал 1 хувь төлдөг байсан. Үүнийг 2.5 тэрбум болговол 180 мянган танай компани шиг том үндэсний компаниуд олон төрөөсэй гэж би энэ татварыг оруулж ирсэн байхгүй юу. Хөдөлмөрлөж байгаа, баялаг бүтээж байгаа.

Дээрээс нь –

- 0-ээс 6 тэрбум төгрөг,
- 6-аас 10,
- 10-аас 15 гээд шатсан босгуудыг нэмэгдүүлж байгаа.

Юу вэ гэхээр өмнө нь 10 хувь, 25 хувь гэж байдаг байсан. Одоо 6-аас 10 тэрбум төгрөгийн орлоготой компани дээр 15 хувийн татвар олгож 25-ынх нь дунд шатлал бий болгосноороо дахиад 300 компани шүү дээ. Уул уурхайн биш. 6-аас 10 тэрбум.

Та бол том компани байгуулсан хүн. Та сайн мэдэж байгаа. Би танайх шиг олон компанид өрөөсэй гэж бодож байгаа. Та магадгүй захирлууддаа өндөр цалин өгдөг байсан байх. Тэр хүмүүс илүү олбол илүү төлөөсэй л гэж байгаа юм. 10 сая төгрөгийн цалин авч байгаа хүн, 12 сая төгрөгийн цалин авч байгаа хүн 10 саяас 10 хувь, 2 сая дээрээс 15 хувь төлөх чинь нийгмийн баялгийн тэгш хуваарилалт байхгүй юу.

Тэгэхээр хэрэглээг дэмжье гээд байгаа чинь чинээлэг дундаж давхаргыгаа устгая гэсэн бодлого байхгүй юу. Хөдөлмөрлөж байгаа хэн бүрийг дэмжих нь энэ татварын хуулийн зорилго.

Түүнээс биш НӨАТ-ын буцаалтаа нэмэгдүүлье гээд хэрэглээг дэмжээд явбал нөгөө 300 саяын машин авч байгаа хүмүүс чинь л НӨАТ-аараа өндөр төлбөр авах байх.

Түүнээс энгийн иргэн хүнсний бүтээгдэхүүн... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: О.Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Та харин яг жинхэнээсээ тархи угаасан шал худлаа гэдэг юм уу зүйл ярьж байна л даа.

Бидний ярьж байгаа тэр НӨАТ-ын буцаалт гэдэг чинь 10 хувийг нь НӨАТ-аас 2 хувийг буцаахаар ерөөсөө Монгол Улсын НӨАТ-ын татвар 8 хувь л гэсэн үг. 10 хувиас 5-ыг нь буцаахаар Монгол Улсын НӨАТ-ын татвар 5 хувь болж байгаа л хэрэг. Татвар тэр чигээрээ л 5 хувь болж буурч байна л гэсэн үг.

Гэтэл Та тэр 10 хувь аваад 2 хувийг нь 3 хувь болгохоор НӨАТ-ын буцаалтын хэрэглээг дэмжиж байна. Тэгвэл Монгол Улс ерөөсөө 5 хувийн НӨАТ-

ын татвартай л больё л доо. Тэгвэл энэ Монголын хэрэглээг дэмжээд байна гэсэн үг үү? Үгүй шүү дээ.

Энэ татварын ачаалал буурч байна. Төр жижигсэх боломж гарч байна. Бидний ярьдаг, хэлдэг зүйл чинь энэ л биз дээ. Татварын буцаалт гэдэг чинь буцаалтын тухай яриа биш. 10-аас 2-ыг хасаад 8 хувийн татвартай л НӨАТ-ын татвартай л орно шүү дээ. Гэтэл Та үүнийг 2 хувийг 3 болгохоор. 3 болговол манайх 7 хувийн НӨАТ-ын татвартай л орно шүү дээ.

Энэ чинь харин сайн үзүүлэлт биш үү. Та яахаараа үүнийг 3-ыг нь зөвхөн тэр 3-д нь ач холбогдол өгөөд байгаа юм. Бид чинь яг үнэндээ 10 биш 8 хувийн НӨАТ-ын татвартай орно шүү дээ.

5-ыг буцаавал 5 хувийн НӨАТ-ын татвартай олон орон больё л доо. Тэгвэл. Аль эсвэл 10-ыг аваад 5-ыг буцаахын ч хэрэггүй. Ер нь 5 хувийн НӨАТ-ын татвартай л больё л доо.

Гэтэл үүнийг одоо Та өөр талаас нь тайлбарлах. Удахгүй л дээ наадах чинь.

Бидний яриа явсаар байгаад татварын тухай яриа болоод байна. Яг энэ татварлаж авсан татварын нөгөө талд чинь төрийн зардал үүний цаана л оршоод байгаа юм. Төр, төрийн зардал үүний цаана.

Гэтэл өнгөрсөн хугацаанд зөвхөн төрийн зардлаас гадна... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Ч.Учрал: НӨАТ-ын буцаалт хэрэглээг дэмжсэн буцаалт олголт байхгүй юу даа. Чинээлэг нь илүү хожно. Тийм л бодлого шүү дээ.

Нэг “Лексус” авахад 2 дахин НӨАТ-ын буцаалт олголоо гээд 9 багшийн, 9 эмчийн цалингаа л алдана шүү дээ.

Харин хүн хөдөлмөрлөж байна. 3 саяын цалин авч байна. 792 мянгыг нь тэглэвэл 79200 үлддэг юм байгаа биз дээ.

Гэтэл 700 мянгаас НӨАТ-ын буцаалт нэмэгдүүлээд 37 мянган төгрөг л үлдээд байна шүү дээ. Ийм л бодлого байхгүй юу.

Тэгэхээр хувь хүний орлогын албан татвар буюу татварын бодлого гэдэг чинь өөрөө нийгмийн баялгийн тэгш хуваарилалт. Илүү орлого олсон нь илүү татвараа төлдөг. Түүгээр нь дамжуулж нийгмийн хүртээмжийг нэмэгдүүлдэг, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлдэг бодлого учраас хувь хүний орлогын албан татварын 20-иос 80 хувийг аймаг, орон нутаг төвлөрүүлж түүгээрээ хот,

нийтийн аж ахуйгаа удирдаж, үйлчилгээгээ явуулж, багш эмчийн цалингаа тавьж, сургууль цэцэрлэгээ засаж, засварладаг юм шүү дээ.

Гэтэл хувь хүний орлогын албан татварыг нэг болгоё гээд бүхэлд нь ингэхээр зүгээр л өндөр цалинтай хүмүүс л хожно.

Тэгээд энэ чинээлэг дундаж давхаргыг чинь хэн авч явах юм бэ.

- Монгол Улс цаашаа шаталсан татварын тогтолцоо руугаа явна.
- Хөдөлмөрийг дэмжинэ.

➤ Зүгээр сул сууж байгаа хэрэглээг огт дэмжихгүй.

Тийм учраас энэ бол олон улсынх нь ч жишиг нь энэ.

Түүнээс биш өнөөдөр НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлэх үү, нэмэгдүүлэхгүй юү гэж ярихаас илүүтэйгээр хөдөлмөрлөж байгаа хэн бүрээ дэмжье.

Би 180 мянган аж ахуйн нэгж яриад байна шүү дээ.

- ▶ 1.5 тэрбум төгрөгийн жилийн борлуулалтын орлогыг 2.5 болговол –
— **180 мянган компани.**
- ▶ НӨАТ-ын буцаалтыг суутган төлөгч 400 сая болговол –
— **23 мянган компани.**
- ▶ 6-аас 10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой уул уурхайн бус компаниудыг дэмжвэл –
— **300 компани.**

Энэ олон хүн ажлын байр бий болгоно шүү дээ. Ийм л зорилго.

Ж.Бат-Эрдэнэ: О.Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Үгүй л дээ. Наадах чинь. Та НӨАТ-ын буцаалт гээд. Зүгээр энэ бол дансны бичилт шүү дээ.

10 хувийн НӨАТ төлөөд 2-ыг нь буцааж авна гэдэг чинь манайх бодит байдал дээр 8 хувийн татвартай л орно. Гэтэл 10-ыг нь авчхаад 2-ыг нь өгөхийгөө элдэв дээд тансаг хэрэглээд хэрэглээд дэмжиж байна гэж. Энэ бол утга учиргүй яриа. Та дахиж наадах чинь ерөөсөө тийм хүүхдүүдийн хоорондын яриа шиг яриа шүү.

10-аас 5-ыг хасвал 5 хувийн татвартай л орон л болно. Аль эсвэл хасаж ч буцааж ч хэрэггүй. Бид 5 хувийн НӨАТ-тай орон гээд зарлаж болно. Наадах чинь энгийн үнэ биш үү.

Түрүүний асуулт. Энэ том төртэй холбоотой бид өнөөдрийн мэтгэлцээнээс сэдэв. Саяын яригдаад байгаа олон татвар хураамж, авлига, энэ олон зүйлийн чинь сүүдэрт нь өнгөрсөн 10 жилийг ярихад асар олон дутуу эхлээд хаясан. Одоо танай намын гэж хэлье. Засгийн газруудыг нь дутуу эхлээд хаясан том том төслүүдийг нь овоолго Монгол Улсаар дүүрлээ. Овоолго.

- **“Нефтийн үйлдвэр”** гээд түүхий эд нь хаана ч байгаа юм. Мэдэхгүй. Шугам хоолой хэдэн их наяд дээр нь татаад хаясан. Яаж ажиллах гэж байгаа юм бүү мэд. Нэг том овоолго.
- Хил рүү татсан **“төмөр зам”** гээд мухар. Одоо хүртэл ачаа ачдаг, ачдаггүй нь ч мэдэгдэхгүй. Ачаагүйгээсээ бараг илүү зардалтай төмөр зам.
- **“Туулын хурдны зам”** гээд километр нь хэдэн арав дахин ч өндөр өртөгтэй юм. Бүү мэд. Урьдчилгаа хэдэн зуун тэрбумаар нь төлөөд хаясан.

Монгол орон даяар яг саяын татварын нөгөө талд асар том төслүүдийн зүгээр л дуусашгүй том овоолго.

- ◆ Үүний цаана татварын дарамт.
- ◆ Үүний цаана зээлийн хүүгийн төлбөрүүд явж байна.

Одоо яг 2026 оны төсөв дээр байсан уу? Зээлийн хүү болоод зээлийн төлбөрт нийлээд 3.9 их наядыг Монгол Улс... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд.

Н.Учрал: Энэ том төрөөс ухаалаг төр лүү шилжих шилжилтийг бид бодитой хийнэ. Хийсээр ч байгаа. Би ажил аваад 2 сар болоогүй байна.

Тэгэхдээ бас хийсэн ажлууд байна. Юутай ч уул уурхайн 10 төрийн өмчит компанийг татан буулгалаа. 67 тэрбумыг шууд хэмнэж байна.

Баялгийн санг хөрөнгө оруулалтын сангийн зарчмаар ажиллуулах бодлогын шинэчлэлийг эхлүүллээ.

Хөрөнгө оруулалт, менежментийн хэд хэдэн компанитай холбогдлоо. Хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр ажиллуулж менежментээр нь олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар удирдуулна.

- Том төрөөс ухаалаг төр лүү шилжих алхмуудыг хийж байгаа.

Татварын хууль ч тэр. Энэ төсвийн бодлого, мөнгөний бодлогын уялдааг хангуулъя гэж ярьж байгаа ч таны яриад байгаа иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах арга хэмжээ.

Намайг ажил авахад 7.2 тэрбум долларын валютын нөөц байсан. 7.3 болсон. Манайд нийлүүлэлтийн гаралтай инфляцыг удирдах цорын ганц арга зам бол валютаа гөвөхгүй л байх. Үүнд гадаад зээл тусламж хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Манай орон өөрөө дунджаас дээш орлоготой орон болох статистик гарсан. 2023 онд.

Тэгэхээр **middle-income trap**¹ гээд байгаа энэ орон зайд байгаа улс өөрөө дараагийн шилжилтийг хийхэд зайлшгүй төсвийн бодлогыг шинэчлэх шаардлага үүсдэг.

Валютаа гөвөөд валютын нөөцөө алдах юм бол бид гадаад зээл, тусламж, тэр нийлүүлэлтийн гаралтай инфляцаа удирдаж чадахгүй.

Тийм учраас энэ явуулаад байгаа бодлогууд бид төсөв ч бай, мөнгөний бодлогыг ч бай зөв уялдуулаад нийлүүлэлтийн гаралтай инфляцаас иргэдээ хамгаалах бодлого. Бид эрэлтийн гаралтай инфляц дээр ч гэсэн арга хэмжээнүүдийг аваад явж байгаа. Цөөхөн хэдэн бүтээгдэхүүнээс хамааралтай.

Төсвийн бодлого ч үүнтэй уялдаж намар өргөн барина.

Ж.Бат-Эрдэнэ: Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энд минут Та хардаг болохгүй бол ерөөсөө баримжаагүйгээр тасарчхаад байна. Тэр харагдахгүй байна.

Түрүүний асуулт, түрүүний санаагаа гүйцээгээд хэлэхэд 3.9 их наядыг одоо манай төсөв дээр жил бүхэн зөвхөн зээлийн хүүгийн төлбөр л төлөгдөж байна.

Энэ чинь дахиад л татварын орлогоор л саяын тэр их том том бүтэлгүй төслүүдийн овоолгууд чинь эргээд татварын орлогоор л бид үүнийг төлж байгаа. Өнөөдрийн ч төлж байгаа. Ирээдүйгээс зээлсэн тэр татварын ачаалал чинь энэ дээр нэмэгдээд.

¹ Тухайн улс орон хөгжлийн тодорхой түвшинд хүрч, дундаж орлоготой (middle-income) орнуудын эгнээнд шилжсэн ч, бүтээмж болон инновацаа дараагийн түвшинд гаргаж чадалгүй гацаж, өндөр орлоготой (high-income) орнуудын ангилалд орж чадахгүй урт хугацаанд саатах үзэгдэл.

Тэгэхээр энэ бүхэн маань өөрөө наад нэг ийм буруу бодлогыг чинь гоё гоё, уриа лоозон шүтэж, улс төрийн уриа лоозонгоор амьдарч ирснийг чинь, улс төрийн том сонгуулиудад ялахын төлөө юу ч амлаж байсан яадаг юм.

Дараа нь аргалаад өөрөөр хэлээд гарна гэж явж ирсэн, саяын хэлж ирсэн 3, 4 сонгуулиудын чинь үр дүнд ийм л том өрийн занганд ороод, зөвхөн 4 их наядыг хүүгийн төлбөрт төлдөг. Өдөрт 10 гаруй тэрбум тэрбум төгрөг төлж байна гэсэн үг шүү дээ. Энэ чинь. Жилд 3.9 их наяд гэдэг чинь өдөрт 10 гаруй тэрбум төгрөгийг Монгол Улс хүүгийн төлбөрт төлж байна.

Ийм нөхцөл байдлууд үүний цаанаас гарна.

Тэгээд яг эхний улирлыг харахад Та нарын мэдээлж байснаар төсвийн орлого 1.4 их наядаар тасарлаа гэж байсан. 1.4 их наядаар төсвийн орлого тасарна гэдэг чинь үүний цаана Та нар болохоор эдийн засаг өсөж байна гээд байгаа юм.

Гэтэл яагаад тэр төсвийн орлого чинь тасраад байгаа юм. Төсвийн орлого гэдэг чинь эцсийн эцэст энэ улс оронд чинь бизнес хийж байгаа, татвар төлж байгаа, тэр цалин авч байгаа энэ хүмүүсийн чинь ахуй амьдрал орлого болохгүй байна л гэсэн үг. 1.4 их наядаар.

Үүний цаана аж ахуйн нэгжүүд нь ашиггүй болсон.

Тэгээд Та нар болохоор цаасан дээр өсөлт гаргаад байдаг. Амьдрал дээр... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Бид хэтэрхий их мега төсөлд хөрөнгө оруулсан. Би үүн дээр тантай санал нэг байна. Гэхдээ Та тоо хэллээ. 2016 оны 5 их наядын татвар өнөөдөр 29 их наяд болно гэдэг сайн мэдээ шүү дээ.

Энэ чинь эдийн засаг томорч байна л гэсэн үг шүү дээ.

Тийм учраас 2023 оны статистикаар Монгол Улс **Middle Income**² руу шилжээд байна шүү дээ.

Гэтэл бид 1986 оноос хойш бид огт төсвийн шинэчлэлийг хийж чадаагүй байхгүй юу. Төсвийн шинэчлэлийг хийж чадаагүй. Нөгөө GSS буюу Тийм ээ. **Government Structure Statistics**³ нэг ч шинэчлэгдээгүй шүү дээ. 40 жил болоход.

² Дундаж орлоготой улс орон.

³ Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх мэдлийн хуваарилалт болон үйл ажиллагаатай холбоотой тоон мэдээллийг цуглуулж, шинжилдэг статистикийн үзүүлэлт.

Нэг ёсондоо капитализмд шилжээд социалист арга барилаараа удирдаад байвал цаашаа бид өндөр орлоготой, хөгжиж байгаа орон болно гэдэг маш их бэрхшээлтэй.

Тийм ч учраас энэ болгоныг цэгцлэх үүрэг над дээр ирсэн учраас би хэт их попролгүйгээр үнэнийг яриад урагшилья л гэж ингэж зорьсон.

Юу ч амласан яах вэ гэдэг үгээ бас Та бодох ёстой. Сая ярьж байгаа дээрээ Та ярьж байх шиг байна. Нийгмийн баялгийн хуваарилалт татвар бүрдүүлэлт шүү. Илүү орлого олдог нь илүү л төлнө.

Түүнээс биш юу ч амласан яах вэ гээд ярьж болохгүй. Аймаг, орон нутаг модоо барьсан ч хамаагүй гэж ярьж болохгүй. Хувь хүний орлогын албан татварын 1 хувь 2.7 их наяд төгрөгийн орлого тасарна. Аймаг, орон нутаг бие дааж үйл ажиллагаагаа явуулах ямар ч бололцоогүй болно. Дундаж давхаргыг дэмжих сургууль, цэцэрлэг, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого чинь бүрэн тасарна.

Тийм учраас би яг тантай тэр мега төсөл дээр санал нэг байна. Би бүгдийг нь эрэмбэлсэн. Тэгэхдээ валютын нөөцийг хадгалахын тулд гадаад зээл тусламжийг явуулах ёстой. Харин гишүүд маань сая хууль баталж өгсөн. Талархаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: О.Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Дахиад л саяын том татварыг том төрийн тухай ярихад үүний цаана яалт ч үгүй бид төрийн өмчийн тухай, төрийн өмчит компаниудын тухай зайлшгүй ярьж таарна.

Өнөөдөр төрийн болоод орон нутгийн өмчит оролцоотой болоод нийлээд 400-аад аж ахуйн нэгжүүд бай байгаа гэж байгаа юм.

Тэгээд үүнийг бид Засгийн газар бүхэн гарч ирээд, Ерөнхий сайд бүхэн гарч ирээд олон нийтийнх болгоно, нээлттэй болгоно, хувьчилна, цөөлнө гэж бүгдээрээ ярьдаг. Үүний зөв буруугийн тухайд бүгдээрээ мэдэж байгаа. Би таныг ч бас үүнийг олон удаа ярьж байсныг санаж байна.

Гэтэл өнөөдөр Их Хурлаар хэлэлцэж байгаа жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр төрийн өмчит компанийг ингэж цөөлнө, ингэж нээлттэй болгоно, ингэж хувьчлах гэж байгаа гэсэн үг, өгүүлбэр 2027 оны төлөвлөгөө дээрээс би лав олж харсангүй. Аль эсвэл байгааг би олсонгүй юу? Энэ дээр тайлбар өгөөч? Аль эсвэл Та нар ээлжит шилний цаанаас чихэр долоолгоно гэдэг билүү. Тэрийгээ хийсэн гэсэн үг үү? Аль эсвэл энэ бодлогоосоо буцаж байгаа гэсэн үг үү? Энэ дээр надад тайлбар өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд Н.Учрал хариулъя.

Н.Учрал: Төрийн өмчит компаниудын бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг би ахалж боловсруулж Их Хуралд өргөн мэдүүлсэн. Жил болж байна.

Энэ хуулийг батлах хэрэгтэй байгаа юм. Төрөөс, Засгийн газраас төрийн өмчит компанийг хэрхэн нэгтгэх вэ, өөрчлөн зохион байгуулах вэ, хувь хувьцааг нь нээлттэй арилжаалах вэг Их Хурал өмчийн эзэн учраас шийднэ.

Тийм учраас хууль батлагдаагүй. Нэгд. Хоёрт, бодитой алхам хийж байгаа.

Манайд төрийн өмчийн компани 100 буюу 20 хэдээр буурсан юм билээ. Өмнөх жилүүдтэй харьцуулахад. Энэ тоог улам бууруулах ёстой. Бууруулахын тулд бид цаашдаа яаж зөв явах вэ гэхээр нэг компани дээр олон улсын үнэлгээ, аудит хийлгэх гэхээр бид маш их цаг хугацаа алддаг.

Тэгэхээр олон улсын жишгийг харахад сая Узбек бол бирж дээр хөрөнгө оруулалтын сангаа гаргаж байх шиг байна. Яагаад вэ гэхээр ашигтай ажиллаж байгаа компаниудынхаа тодорхой шэйрүүдийг нэгтгэж хөрөнгө оруулалтын сан болгоод үнэлгээ хийх, аудит хийх, андеррайтер авах, бирж дээр гаргах бүх процессыг олон улсын менежментэд өгч байгаа юм.

Тийм учраас энэ замыг сонгосон. Би танд хэлэхэд “Эрдэнэс Монгол” нэгдлээс 10 компанийг буулгаад, би зөвхөн ашигтай ажиллаж байгаа 2 стратегийн компани, хөрөнгө оруулалтын гэрээтэй 4 байна уу, компанийг үлдээсэн. Бусдыг нь татан буулгасан. Засгийн газар эрх хэмжээнийхээ хувьд.

Одоо их хааныхаа нэрээр ирсэн хөрөнгө оруулалтын сан дээр уул уурхайн бай, уул уурхайн бус ашигтай ажиллаж байгаа компаниудын шэйрүүдийг нэгтгээд сая манай Засгийн газрын зүгээс менежментийн компаниуддаа хэд хэдэн “call” хийсэн байгаа. Одоо хөрөнгө оруулалтын санг яг Узбектэй адилхан бид олон улсын менежментэд өгнө өө. Ингээд бирж дээр гаргах ажлыг тэд зохион байгуулна.

Түүнээс биш нэг компани дээр үнэлгээ аудит хийх юм бол маш их цаг хугацаа алдана. Энэ бол хамгийн зөв зам.

Тэгэхээр хийсэн ажлаараа харуулна л гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: О.Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Одоо тэгээд ээлжит хууран мэхлэлт, ухралтаа л хийж байна. Хувьчилна, олон нийтийнх болгоно, нээлттэй болгоно, 1072-ыг тэгнэ ингэнэ, төрийн өмчит компанийг тэгнэ гэж маш гоё гоё зүйлүүдийг ярьж байсан.

Одоо тэгсэн чинь ил тод байдал, бүтээмжийн хууль хүлээж байгаа. Тэгээд тэрний дараа гоё засаглал сайжруулна. Эцсийн эцэст төрийн өмчит компани хэчнээн мундаг менежер очоод тэр бүтээмжийг чинь сайжруулахгүй. Тэр ил тод байдал нь сайжрахгүй. Наадхыг чинь зүгээр л тэрийг хасаж танаад тэр зөв зүй зохистой менежмент хийдэг тэр секторт нь шилжүүлдэг чинь хүн төрөлхтний явж ирсэн хөгжлийн зам л байна шүү дээ.

Үүнийг энэ чигээр нь байлгана. Энэ чигээр нь байлгачхаад харин нэг гоё сайн хүн олж тавьж байгаад энэ сайн хүн нь их гоё бүтээмжтэй ажиллаад гэж хэлдэг чинь зүгээр л ээлжит тархи угаалт, ээлжит ухралт шүү дээ.

Яг ийм л замаар өмнөх Ерөнхий сайдууд бүгд л явж байсан. Болохоосоо өмнө яг ингэж ярьдаг. Болсон хойноо шалтаг хэлдэг. Эцсийн дүндээ яг төрийн өмчийн оролцоо нь явсаар байгаад эдийн засагт төр, төсөв, төрийн өмчит компани, тусгай зөвшөөрлүүд нь нийлээд 80, 90 хувь руугаа явсан. Яг энэ өнгөрсөн 10 жилийн уран бүтээл чинь яг л энд ийм байдалтай, наад татварын чинь нөхцөл байдал, ард иргэдийн чинь аж ахуйн нэгжүүдүүдийн чинь тэр татвараа төлж чадахгүй болж байгаа нөхцөл байдал чинь яг л ийм л үр дүнд л хүргэнэ шүү дээ.

Тэгсэн чинь Та бүтээмж, ил тод байдлыг сайжруулаад, байгаа юмыг байгаагаар нь сайхан сайжруулна гээд зогсож байгаа ээлжит их том ухралт хийж байгаа юм байна гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Та ухралт гэж ярих хэрэггүй байх.

“Эрдэнэс Монгол” компанийн 10 компанийг татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргасан. “Эрдэнэс Монгол” гэдэг компани одоо байхгүй. Бүртгэлийг нь явуулах гэж байна. Одоо.

Тэр компани “Чингис хаан” үндэсний баялгийн сан гэдэг менежментийн компанитайгаа нэгдээд одоо гуравхан чиглэлээр ажиллана.

- Хөрөнгийн удирдлага,
- e-mongol дээр байгаа хуримтлалын санг нэмэгдүүлье.
- Хуультай шүү дээ. Баялгийн санг.

Гуравт, үйлдвэр, технологийн парк буюу төслүүдийн санхүүжилтийг олгож хуримтлалын санг нэмэгдүүлэх. Зөвхөн энэ зорилгын дагуу, хуулийн дагуу

ажиллана. Бид хуультай орон. Улсаа хуулиар жолооддог. Тэр Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, тэр хуулийг батлах нь Их Хурлын бүрэн эрх. Тодорхой юм яриад байна шүү дээ.

261 оронтой зөвлөлсөн. Болсон ажил. Хуураад байгаа юм ерөөсөө байхгүй. Харин үе үеийн Ерөнхий сайд нар ингэж шууд буулгаад зохих арга хэмжээ авч байгаагүй байх. Би танд хэлж байна шүү дээ.

- ▶ “Franklin Templeton” (California, U.S.) гэдэг хүнээр би энэ сангаа удирдуулна.
- ▶ Яг түүн шиг олон компаниар удирдуулна.
- ▶ “Эрдэнэс Тавантолгой” дээр олон улсын аудит оруулна.

1072 хувьцааны чинь 62 тэрбум төгрөг буюу хувьцааг нь өвлүүлсэн. Одоо бүртгэл хийгдэж байна. 28 хувийг иргэд эзэмшиж байгаа.

933 төгрөгийн хувьцааны үнэлгээг багадаа 3 мянга хүргэнэ. Энэ чинь бодит ажил.

Сая харин 10 төрийн өмчит компанийг буулгах надад амар байгаагүй. Хүний, өөрийн намын олон хүмүүс над руу ярилаа. Танай бүтээмжийн менежерүүд ч над руу ярьсан.

Тэр компани дээр бүтээмжийн менежерүүд байсан. Тэд нар маань хүний өөрийн намгүй над руу ярьж байгаа. Гэхдээ түүнд би ямар нэгэн ухрал няцаад байх юм байхгүй.

Хүн яривал улс хөгжихгүй юм билээ. Компани тухайлан яриад зарчим ярьж байгаа хүн зарчмаасаа ухраад заримд нь өөрөөр үйлчилж эхэлбэл явахгүй юм билээ.

Тийм учраас зоригтой шийдэмгий энэ ажлуудаа эхлүүлсэн, үргэлжлүүлнэ дуусгана.

Ж.Бат-Эрдэнэ: О.Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: 10 аж ахуйн нэгжүүдийг татан буулгалаа гэж байна.

Би бас үүнийг ээлжит хууран мэхлэлт шиг л үг сонсогдож байна. Татан буулгалаа гэдэг нь яадаг юм. Тэр чинь энэ хорвоогоос алга болох юм уу? Хэлбэрээ өөрчилнө. Хэлбэрээ өөрчилнө гэдэг чинь Та 10-ыг нэгтгээд өөр нэр өгөөд өөр том аж ахуйн нэгжүүдийн хаяанд нийлүүл юм байна.

Ээ 10-ыг татан буулгаад 11 дэх дээр аваачаад нийлүүлэх юм байна. Ингээд төрийн өмч чинь хэвээрээ шүү дээ. Юу өөрчлөгдөх юм. Юу ч өөрчлөгдөхгүйгү шүү дээ. Зүгээр л хууран мэхлэлтэй шүү дээ.

Энэ 10-ыг би хувьчиллаа. Энэ 10-ыг нээлттэй болголоо. Энэ 10-ыг бирж дээр гаргалаа гэвэл энэ чинь жинхэнээсээ бодлого. 10-ыг татан буулгалаа гэдэг чинь зүгээр 11 дэхийн бөөрөнд нийлүүлээд зүгээр л нэр хаяг, нэрийн хуудас л солигдож байгаа шүү дээ. Тэр аж ахуйн нэгжийн чинь. Өөр энэ чинь юм алга байна шүү дээ. Бодлогын өөрчлөлт биш шүү дээ.

Тэгэхээр наадах чинь зүгээр л Та нарын ярьдаг нэг ээлжит... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд хариулъя. Минут дууссан уу? Мэтгэлцээн дууссан байна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учралаас “Данхар төр, дарамтат татвар” гэсэн сэдвийн доор асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Дараагийн гишүүдийн нэрсээ өгнө үү? Цөөнхийн бүлгийн гишүүдээс асуулт асууна. Монгол Улсын Ерөнхий сайдаас. Нийт 9 гишүүн нэр өгсөн байна.

Ганбатын Очирбат.

Г.Очирбат: Н.Учрал Ерөнхий сайдад төрийн эрх бариад 10 жил болж байна. 10 жилийн ойн баярын мэнд хүргэе.

2016 оноос хойш танай нам тасралтгүй 10 жил төрийн эрх барилаа.

Монгол Улсын төсөв 5 дахин данхайсан. Иргэдийн маань орлого 5 дахин өсөж чадсангүй. Татвар чинь 3-аас 4 дахин нэмэгдсэн. Өнөөдөр иргэдийн олж байгаа орлого 3-аас 4 дахин нэмэгдэж чадаагүй.

Мэдээж танд тоонууд чинь бага байх. Тийм ээ. 17 төрлийн татвар 2 дахин, 4 дахин, 50 хувь, 233 хувь, 30 хувь гээд 17 төрлийн татвар нэмэгдсэн байгаа. Та үүнийг олоод харчхаарай. Цаг бага болохоор.

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн 2016 оныхоос 3 дахин өссөн. Өнөөдөр иргэд маань цалин авч байгаа ч гэсэн авч байгаа цалин нь амьдралдаа хүрэхгүй байна.

Тэгэхээр 10 жил танай нам, Та эрх барьсан. Танай намын мөрийн хөтөлбөрөөс тодорхой гуравхан жишээ татъя. Би.

- Өрхийн бичил бизнесийг дэмжиж, хүүгүй, барьцаагүй санхүүгийн

дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ гэсэн.

- Зээлийн хүүг бууруулж сарын 1 хувиас хэтрүүлэхгүй болгоно гэсэн.
- Иргэдийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг 2 дахин бууруулна гэсэн.
- Бүсчилсэн хөгжлийг дэмжиж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 5 хувь болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэсэн.

Ингээд танай намаас сүүлийн 10 жил Монгол Улсын ард түмний тархийг угааж, төрийн эрх мэдлийг барих пропаганда явуулж өнөөдрийн эрх мэдэлд хүрсэн.

Бодит байдал, үнэн нүүр төрх чинь илчлэгдэж байгаа. Энэ удаа Ардчилсан намынхан 42 гишүүнтэй болж орж ирээд энэ мэтгэлцээний хэлэлцүүлгийн цагийг хүртэл гаргаж ирээд, яг Ерөнхий сайдтайгаа хоёр талаасаа нүүрээ харалцаад ярьж байна.

Тэгэхээр төр 2016 онд 110 гаруй мянган төрийн албан хаагчтай байсан. Өнөөдөр 220 мянга. 220 хүний чинь 21 мянга нь дарга болсон байна. 21 мянга нь дарга гэсэн албан тушаалтнууд гарсан.

Тэгэхээр үүнийгээ Та яаж цэгцлэх гэж байна аа? Мөнгө нь 5 дахин нэмэгдсэн. Энэ мөнгөнөөсөө яаж салах гэж байна?

Төр хамгийн том ажил олгогч болсон. Хамгийн их мөнгөтэй болсон хамгийн их эрх мэдэлтэй болсон. Үүнээсээ яаж... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 1 минут нэмье.

Г.Очирбат: Дараагийнх нь татварын дарамт.

Ардчилсан намынхан орж ирээд хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгоё. Танайхаас бас хуулийн төсөл өргөн барьсан. Хамтраад үүнийгээ дундын хувилбар гаргаад зөв зохистой арга хэмжээнд нь оруулъя гээд явсан. Одоо дэмжлэг авахгүй байна.

НӨАТ-ыг 5 хувь болгоё. Одоогийн 10-ыг нь бас дундаа зөвшилцөж яваад ажлын хэсэг гаргаад дундын шийдвэр гаргасан. Бас энэ шийдэл хэрэгжихгүй байна.

Тэгэхээр ер нь энэ ард түмнээ энэ татварын дарамтаас яаж салгах гэж байна аа? Яг бодитойгоор иргэн сая төгрөгийн цалин авлаа гэхэд өнөөдөр татварт 38-аас 40 хувь нь явж байна шүү дээ.

Тэр сая төгрөгийнхөө 400000-ыг нь татварт өгчхөөд 600 мянгаар яаж амьдрах юм бэ. Энэ дээр ямар бодлого байна танд. Энэ хоёр асуултдаа хариулт авчхаад тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Сүүлийн 10 жил Монголын эдийн засаг 6 дахин томорсон байхгүй юу. 29.9 их наяд 89.9 их наяд руу хүрсэн GDP (Gross Domestic Product) -тэй.

Тэгэхдээ өрхөөр орж чадаагүй.

Тийм учраас арга хэмжээ авахаар би ажиллаж байна.

Тийм учраас би энэ татварын хуулийг өргөн мэдүүлсэн. Яагаад гэхээр энэ хэрэглээг дэмжсэн бодлогоос салахгүйгээр үнийн өсөлтийг барьж чадахгүй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ёстой байхгүй юу.

Тэгэхээр хоосон улс төржилт, хийрхэл чинь биднийг энэ замд хөтөлсөн. Сонгууль болгоны циклийн өмнө янз бүрийн нийгмийн даатгалын шимтгэл бууруулсаар байгаад өдий хүргэсэн. GDP-ийн 32 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, татвар хоёр эзэлдэг. Татвар дангаараа 26 хувь.

Гэтэл нийгмийн даатгалын шимтгэл шимтгэж төсөв бүрдүүлдэг биш, тусдаа санд хуримтлагдаад хөдөлмөрлөснийхөө үр шимийг иргэн хүртэх ёстой байтал нийгмийн даатгалын шимтгэлийг татвар шиг санасаар өнөөдрийг хүрсэн. Татварыг зөвхөн төсөв бүрдүүлдэг хэрэгсэл гэж ойлгодог. Татвар гэдэг. өөрөө нийгмийн баялгийг хуваарилдаг бодлого байхгүй юу.

Тийм учраас өндөр орлоготой нь илүү төл гэдэг зарчмыг л би барьж байгаа.

Тийм учраас “Прогрессив такс”⁴ (Progressive Tax) руу шилжинэ. 2022 оны Хувь хүний орлогын албан татварын хууль бол энэ дэвшил. 12 саяын цалинтай хүн 10 саяасаа 10 хувийг төлөөд үлдсэн 2 саяасаа 15 хувийг төл. 18 саяын орлого олж байгаа хүн 5 сая дээрээсээ 15 хувь, үлдсэн 3 сая дээрээсээ 20 хувийг төл. Энэ шударга.

Ингэж байж тэр орон нутаг ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн чинь үйлчилгээ, ахуй амьдрал, хот нийтийн аж ахуйг авч явдаг.

Гэтэл Та нар 20 сая төгрөгийн орлоготой хүнийг 1 хувь болгоё. Үүнээс 200 мянган төгрөг авъя. 2 сая хүнээс нь 2 саяын цалинтай хүнээс бас 2 хувь авъя гээд. Ийм шударга бус юм яриад байж болохгүй шүү дээ.

⁴ Шаталсан орлогын албан татвар (Progressive Tax) буюу “илүү их орлоготой нь илүү өндөр хувиар, бага орлоготой нь бага хувиар татвар төлөх” зарчим.

Тийм учраас татварыг хэзээ ч нийгмийн баялгийн хуваарилалт шүү гэдгийг мартаж болохгүй. Чинээлэг дундаж давхаргыг бий болгоё гэвэл хөдөлмөрлөж байгаа хүнийгээ дэмжээд, өндөр орлоготой нь өндөр төлөөд чинээлэг дундаж давхаргыгаа дэмжиж авч явдаг. Үүнийг л хөгжлийн зөв бодлого гэж байгаа шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайд аа. Татварын бодлого чинь данхар төртэйгөө шууд холбоотой. Тийм ээ? Дундаж давхаргаа дэмжих чинь татварын бодлоготой шууд холбоотой шүү дээ. Тийм ээ. Микрофоноо нээчих. Хоёулаа ярьчихъя. Болно шүү дээ. Та болно гэж бодвол.

Х.Тэмүүжин гишүүний санаачилж байгаа энэ Ерөнхий сайдын тэр индрийг буулгаад яг энэ гишүүдийнхээ дунд парламентыг хянагддаг байх Засгийн газрын энэ хандлага өөрөө данхар төрийг буулгах, дээрээс нь иргэдийнхээ хандлагыг ойлгох, чих зөөлөнтэй гүйцэтгэх засаглал байх ийм агуулга байгаа. Та үүнийг дэмжиж байгаа юу? Энэ зүгээр хэлбэрийн асуудал биш, агуулгын хандлагын асуудал байгаа. Та үүнийг дэмжиж байгаа юу? Нэг асуулт.

Хоёрдугаарт, би бэлдсэн асуултаасаа өөр асуулт асууъя.

Өчигдөр “Улаанбатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дарга Х.Хэрлэн гэдэг хүн тэр Дархан-Уул аймгийн Хонгор сумын Салхитад очоод зарим Их Хурлын гишүүдтэй хамт төмөр замчидтай уулзаад нөхөн сонгуулийн өмнө улс төрийн агуулга бүхий уулзалтад ороод яваад байх юм.

Та энэ дээр хариуцлага тооцож өгмөөр байна.

Гуравдугаарт, танай хотын даргаар саяхан томилогдсон хүн залуу хүнийх нь хувьд дэмжиж байгаа. Гэсэн ч гэсэн гарч ирэнгүүтээ шөнөжин нойргүй хонолоо, хурим найраа хойшлууллаа, хэцүү байгаа юм шиг ялархсан, тунирхсан хандлага гаргаад байх юм.

Нэгэнт ажил хийнэ гэж байгаа бол бодлого, концепц, зорилго яриад явмаар байх юм.

Хандлагаараа нэг угсаа залгамжилсан хунтайж шиг нийгмээр баахан магтуулаад шалтаг тоочоод баймааргүй байх юм.

Ийм зүйлээс чинь данхар төрийн хандлага эхэлж байгаа юм. Ийм зүйлээс чинь болоод дундаж давхаргаа дэмжих, тэр татвар багатай орчин руу улс төрчид зоригтой шийдвэр гаргадаг байх хандлага эхлэх гээд байгаа юм. Та энэ гурван асуулт дээр товчхон хариулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Их Хурлын гишүүдийн санаачилсан хуулийг Улсын Их Хурал л шийднэ шүү дээ.

Засгийн газар шийдэхгүй. Тэр Та нарын асуудал. Би завгүй байгаа.

Төсөв хэрхэн төлөвлөх вэ гэж. Чинээлэг дундаж давхаргыг хэрхэн бий болгох вэ гэдэг дээр толгойгоо ажиллуулж байгаа.

Тийм учраас би нийгмийн баялгийн хуваарилалт татвар гэж яриад байгаа. Би маш тодорхой юм ярьж байгаа.

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 1 хувь 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтаас доош байсныг би 2.5-д хүргэснээрээ 180 мянган аж ахуйн нэгжүүдийн бий болгож байгаа.
- НӨАТ-ын суутган төлөгчийн босго 50 сая байсныг 400 сая болгосноороо 23 мянган суутган төлөгчийг дэмжих гэж байгаа.
- 6-аас 10 тэрбум төгрөг дээр шаталсан татварыг нэмж 25-ыг 15 хувь болгож бууруулснаараа би 300 уул уурхайн бус мөртлөө 6-аас 10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой компаниудыг түрүүлж гаргах гэж байгаа.

— Ажлын байрыг нэмэгдүүлж байгаа.

— Хөдөлмөрлөж байгаа хэн бүрийг дэмжих гэж байгаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийг татвар шиг битгий санаасай гэж би хүсэж байгаа.

- ▶ 2014 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүс 769 мянган төгрөгийн тэтгэвэр тогтоолгохдоо 1 сая 400-гийн цалингаас бодуулсан.
- ▶ 2018 оноос хойш тэтгэвэрт гарсан иргэд 2 сая 400 мянгын цалингаас бодуулсан. Энэ шударга бус тогтолцоог би өөрчлөх гэж байгаа.

Түүнээс биш тэтгэврийг 20 хувь нэмлээ гээд 769 дээр ч 29 хувь, 2 саяын ца тэтгэвэр дээр ч 20 хувь нэмэгдлээ гээд энэ шударга бус байна.

Тийм учраас үүнийг шийдэх гэж байгаа юм.

Төрийн албан хаагчийн цалинг 33 хуулиар зохицуулж байна. Их Хурлын Тамгын газрын референт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт өөр цалинтай.

- 33 хуулийг өөрчилж төрийн албан хаагчийн цалин хөлсийг шударга болгох гэж байгаа.
- Халамжийг нэгтгэж бууруулах гэж байгаа.
- Халамжийг зорилтот бүлэгт 26-хан хувь нь хүрэхгүй байна шүү дээ.

үүнийг бид 50 хувьд хүргэх гэж байгаа юм. Ийм л ажилтай байгаа юм.

Тэгээд сандал, суудал яах нь Та нарын асуудал.

Ж.Бат-Эрдэнэ: СүхбаатарынЭрдэнэболд гишүүн нэмэлт 1 минут. Болсон уу? Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд Ерөнхий сайд.

Би өнөөдөр төрийн өмчийн компаниудын давхардсан болон санаатайгаар сарниулсан бүтцийн чинь тухай ярина.

Тухайн аж ахуйн нэгж, төрийн өмчит компаниуд нь байсаар байтал төлөөлөн удирдах зөвлөл, яамдын оролцоо, Төрийн өмчит компани, бодлогын яам гээд бүтцүүдийг нь давхардуулдаг.

Тэгээд гурван хоногийн өмнө татан буулгасан “Эрдэнэс Монгол”, “Эрчис Монгол”. Оройтсон бороо гэдэг шиг нэг юм боллоо.

Шалтгаан нь юу вэ гэхээр төрийн өмчийн 100 компани, орон нутгийн өмчийн 429 компани бүртгэлтэй. Төрийн өмчийн хороо нь орон нутгийн өмчийн компаниудаа мэддэггүй.

30 их наядын өртэй. Эдгээр дээр нь бүгдийг нь намуудын томилгоо хийдэг. Намуудын зардал гардаг.

Төрийн өмчимт компаниудыг аваад үзье.

- | | |
|--|---------------|
| • Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр | - 32 компани, |
| • Эрчим хүчний яаман дээр | - 28 компани, |
| • Сангийн яаман дээр | - 5 компани, |
| • Зам, тээврийн хөгжлийн яаман дээр | - 6 компани, |
| • Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хороон дээр | -21 компани |

-байх жишээтэй.

Энэ нь өөрөө юу вэ гэвэл танай Засгийн газрын сайд нар эрх мэдлээ булаацалдаад байна гэсэн үг.

Манайхан чимээгүй бай даа. Танай яамны сайд нар эрх мэдлээ булаацалдаад, төрийн өмчийг үнэгүйдүүлээд, давхардуулсан бүтцүүдийг бий болгож байна гэсэн үг.

Та нар 100 хувь Төрийн өмчийн хороонд давхардуулсан бүтцээ арилгаж чадах уу?

- “Эрчис Монгол” гэж компани байгуулаад татан буулгахдаа 8 тэрбум төгрөг захиран зарцуулж үрээд, 4 тэрбумын өртэй үлдээсэн. Үүний зөвхөн 4 тэрбум нь удирдлагын зардлын зардал.
- “Эрдэнэс Монгол” гэж компани 2025 онд удирдлагын зардал нь 4 тэрбум байх жишээтэй. Сая татан буулгасан “Эрдэнэс Монгол” компанийг харъя. Борлуулалт, маркетингийн зардал нь –

- › 2024 онд 3.2 их наяд,
- › 2025 онд 2.5 их наяд.

Гэтэл Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Тавантолгойн зэс, нүүрсийг компаниуд очерлоод хүлээгээд байж байдаг.

3.2 их наядаар борлуулалтын зардал, маркетингийн зардал гаргах ямар ч шаардлага байгаагүй.

Зөвхөн “Эрчис Монгол” компанийн удирдлагын зардал –

- › 2024 онд 400 тэрбум,
- › 2025 онд 451 тэрбум.

Менежментийн төлбөрт –

- › 2023 онд 170 тэрбум,
- › 2027 онд 130 тэрбум.

Нийтдээ 357.0 тэрбумыг Та нар гарын салаагаар урсгажээ. Төрийн өмчийн... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Хийхээр оройтлоо гээд. Хийхгүй байхаар хийхгүй байна гээд. Зөв зүйлийг нь дэмжиж чадвал бидний залуучууд улс орноо зөв хөтөлж чадна гэж би боддог.

Түүнээс биш сөрөг хүчин заавал шүүмжлэхийн төлөө, хийж байгаа зөв ажлыг заавал шүүмжлэх нь утгагүй.

Тэгээд хийхгүй оройтсон. Би тэрийг хүлээн зөвшөөрч байна.

Тэгэхдээ “Эрдэнэс Монгол” компанийн 10 компанийг татан буулгалаа. Тэр компанийг дэргэд нь байсан менежментийн компанитай нийлүүлээд зөвхөн хуулийнх нь дагуу ажиллуулах шийдвэрт хүрсэн. Би 260 гаруй орон тоог цомхотгоод энэ арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Тэгэхээр хийхгүй оройтох юм бол бүр л оройтно. Хэн нэгэн хийхгүй байх н. Тийм учраас цаг алдахгүйн тулд хийж байна. Би яг тантай санал нэг байна. Төрийн өмчит компаниуд хэтэрхий хувийн хэвшлийн бизнесийн үйл ажиллагаанд оролцож байна.

Тийм учраас хувийн хэвшил хийж чадаж байгаа үйл ажиллагаануудаас төрийн өмчит компаниуд салах ёстой.

Тийм учраас нэг компани дээр үнэлгээ хийгээд, аудит хийгээд түүнийг бирж дээр гаргах гэвэл нэг компани дээр багадаа хамгийн хурдандаа 3 жил.

Тэгэхээр ашигтай ажиллаж байгаа компаниудынхаа шэйрийг нийлүүлээд хөрөнгө оруулалтын сан болгоод бирж дээр гаргах замыг сонгож байгаа.

Тийм учраас компанийн засаглал ил тод нээлттэй болно буюу засаглал ил тод болох, бирж дээр гарахын зорилго хяналтад орно л гэсэн үг.

Тийм учраас өнгөрсөн хугацаанд явж ирсэн тендергүй зохион байгуулагддаг. Таныг Тамгын дарга байхад тэтгэврийн зээл тэглэсний чинь өр төлбөрийг “Эрдэнэс Монгол” хойд хормойгоороо урд хормойгоо нөхөөд л тавьж байгаа. Тийм.

Тэгэхээр аль болох зөв болгох гээд явж байгаа шүү дээ.

Бие биеийнхээ зөвийг зөв, бурууг буруу гэж л урагшилья.

Ж.Бат-Эрдэнэ: Өлзийхүүгийн Шижир гишүүн 1 минут.

Ө.Шижир: Манай Н.Учрал сайд он, сараа андуураад байх шиг байна. Тухайн үед магадгүй л дээ. Шалтгаантай байсан.

Би тэр үед Ерөнхийлөгч Тамгын газрын дарга нэгдүгээрт байгаагүй.

Хоёрдугаарт, Та миний нэг асуултад хариулсангүй.

Сайд нар чинь эрх мэдлээ булаацалдаад, төрийн өмчит компаниуд чинь тал талаас нь булааж аваад байна гэдэг. Энэ бол сайд нарын чинь давхардуулсан бүтэц.

Яагаад би танд үүнийг хэлээд байна вэ гэхээр сүүлийн 10 жил энэ бүх төрд Та Цахим хөгжлийн яамны сайд байсан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга байсан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байсан, Тэргүүн Шадар сайд байсан, Улсын Их Хурлын дарга байсан. Одоо Та Ерөнхий сайд.

3 удаа сайд, 2 удаа дарга. Хамгийн том дарга нь. Монголын.

Та энэ төр данхайж байхад, төрийн бүтэц үр ашиггүй болж байхад, үйл ажиллагаа нь үр дүнгүй болж байхад Та энэ дундуур нүдэн балай энд өнгөрөөгүй. Бүгдэд нь таны оролцоо байсан.

Төр данхайхад таны Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шийдвэр хэрэгтэй. Төрийн өмчит компаниуд данхайрахад Эдийн засаг, хөгжлийн яамны сайдын шийдвэр хэрэгтэй.

Та энэ оролцоонд оролцоогүй байна гэж байхгүй. Мөнхийн оролцоотой байсан.

Тийм учраас сайд нар чинь эрх мэдлээ яагаад булаацалдаад... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би Хэрэг эрхлэхийн дарга байхдаа Төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг боловсруулж өргөн мэдүүлсэн. Нийтийн өмчийн хуулийг би өргөн мэдүүлсэн. Их Хурал дээр жил болж байгаа. Ажлаа би хийсэн.

Мөн би Эдийн засаг, хөгжлийн сайд байхдаа төсвийн тэнцвэржүүлсэн орлого GDP-ийн хувь хэмжээг 30 хувь хүртэл бууруулж төсвийн хүрээтэй дагуулж баталсан. Үүний хүчээр төрийн оролцоо буурч байгаа.

Зөвхөн энэ харьцаагаар.

Тийм учраас өөрийн хариуцах албан дээрээ байхдаа би хандлагын өөрчлөлт хийе гэж үргэлж хичээдэг байсан.

Би Цахим хөгжлийн сайд байхдаа төрийн 1200 үйлчилгээг цахим руу шилжүүлснээр 20 хувийн хэмнэлтийг бий болгосон. Энэ болгоныгоо одоо би угсарч үр дүн гаргахаар ажиллаж байгаа.

Тийм учраас тодорхой үр дүн гаргах болно.

Тэгээд ажлаараа харуулж байгаа. Хийсэн ажилд зөвийг зөв, бурууг буруу гэж дүгнэхийг хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Ерөнхий сайд аа. Хоёулаа хэдэн тоо хамтдаа үзье. Тийм ээ.

Ер нь 10 жил юу болоод өнгөрөв. 10 жил ч гэж дээ. 12 жил шүү дээ.

Одоогийн байгаа Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн хамтарсан 2 жилийг оруулах юм бол. Камер нь хаана байна вэ? Ийшээ гарч байна уу?

Нэгдүгээрт нь, 2016 онтой харьцуулсан байгаа. Манай улсын төсөв 5.8 их наяд. 2026 онд 31.9 их наяд. Улсын төсөв 5.5 дахин их өсжээ.

Хоёрдугаарт нь, татварын орлого 2016 онд 4.9 их наяд байсан байна. 2025 оны эцсээр 27.1 их наяд буюу 5.5 дахин өсжээ.

Татварын бус орлого. Татварын бус орлого их сонирхолтой байгаа юм. 2016 онд 884 тэрбум байсан бол бүр 3 их наяд болсон. Хамгийн гол нь энэ дээр, өөрөөр хэлбэл иргэдээ торгож хүү торгуулиас өнгөрсөн жил би 2025 оныхыг олсонгүй. 2024 оны гүйцэтгэлээр 410 тэрбум төгрөгөөр зөвхөн иргэдээ торгосон хүү торгуулийн орлогоор, татварын бус орлогоо бүрдүүлжээ.

Өнөөдөр дундаж орлого 3 орчим сая байна.

Гэтэл зарлага нь 3 сая 100. Энэ бол статистикаас гаргаж байгаа тоо. Гэхдээ статистик тоог яаж гаргадгийг би мэднэ. Өөрөөр хэлбэл хөдөлмөрлөөд байхад ядуураад, зээл авч амьдардаг иргэдтэй болжээ.

Энэ их сонирхолтой тоо. 2016 онд Монгол Улсын нийт өрхийн 54 хувь нь зээлтэй байсан. Өнөөдөр 10 жилийн дараа Монгол Улсын нийт иргэдийн өрхийн 71 хувь нь зээлтэй болсон байна. Энэ юуг харуулж байна вэ гэж. Өөрөөр хэлбэл 5.2 их наядын зээлтэй байсан бол зээлийнх нь үлдэгдэл өнөөдөр 2026 оны 3 сарын байдлаар... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя. 2 минутаар.

Н.Учрал: Тийм. Баярлалаа. Г.Ганбаатар гишүүн ээ.

Татварын хувь хэмжээ өсөөд татварын орлого өссөн биш, уул уурхайн салбарын өсөлтийг дагаад төсвийн орлого өссөн байхгүй юу. Бас нэг талаас хэт тэгж ярьж болохгүй байх. Уул уурхайн салбарын ил тод байдлын хууль санаачилгыг би “Нээлттэй засаглалын түншлэл”-д төлөөлж очихдоо дэмжиж энэ хуулийг батлалцахад оролцсон. Биржээр нүүрсээ арилжаалдаг болсноороо татварын орлого өссөн. Татварын орлого өссөн.

Тийм учраас 10 жилийн дотор GDP 29.9-өөс 89.9 хүрээд байна. Нэг хүнд ногдох pure capital чинь бараг 10 мянга хүрэх гээд байна. Харин бид хуримтлал үүсгэж чадсангүй. Энэ бол алдаа. Олсныхоо хэрээр үрсэн байна.

Тийм учраас бид олсныхоо хэрээр үрсэн алдааг засах ёстой.

Би 3 сарын 30-нд ажил аваад өнөөдрийн байдлаар чинь экспортын орлого бараг 2 дахин. Ингээд биржээ дэмжиж чадвал үр дүн гардаг. Намайг Эдийн засаг, хөгжлийн сайд байхад би боомт дээр 12 шат дамжлага байсныг 6 болгож байсан. Түүний үр дүнд логистик шийдэгдсэн.

Тийм учраас өнөөдөр валютаа бид гөвчхөөгүй яваа. 7.3 гэдэг бол муу тоо биш. Энэ байж нийлүүлэлтийн гаралтай инфляцаас иргэдээ хамгаалдаг.

Тэгэхээр төсвийн бодлого, мөнгөний бодлогын уялдаа гэдэг өөрөө энэ юм. Яг үүн дээрээ дамжуулаад татварын хуулиа хийж чадвал ажлын байрыг нэмэгдүүлэх боломжууд бий болох юм. Ажлын байрыг нэмэгдүүлэх. Хэдэн жил бид хэрэглээг дэмжиж явах вэ. Хэдэн жил. Хөдөлмөрийг дэмжиж ажлын байрыг дэмжсэн бодлого өөрөө эдийн засагт эерэг эффект өгдөг юм.

Тийм учраас татварын хууль хөдөлмөр эрхэлж байгаа хэн бүрийг дэмжих бодлого юм.

Ж.Бат-Эрдэнэ: Г.Ганбаатар гишүүнд 1 минут. Нэмэлт.

Г.Ганбаатар: Тэгэхээр бид хэдэн жил энэ данхар төрийг тэжээх вэ гэж танаас асуух гэж байсан юм.

Үндсэндээ төрийн үрэлгэн зардлыг яагаад бид татвар нэмэх замаар иргэдээс авах ёстой юм бэ? Та энэ тоон дээр их анализ хийх ёстой байхгүй юу? Татварын бус орлого ялангуяа. Энэ бол яах вэ иргэдээ хүү торгуул. Үндсэндээ энэ чинь 3 дахин өссөн байгаа байхгүй юу. Хэдий болтол иргэдээ Зөрчлийн хуулиар бусад хуулиар торгож татварынхаа орлогыг бүрдүүлэх вэ гэдэг асуулт байсан юм. Та энэ дээр хариулахгүй юу?

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулья.

Н.Учрал: Тийм. Бид арга хэмжээнүүдийг авч байгаа.

Тийм учраас би сая эхнийхийгээ хэллээ. 10 төрийн өмчит компанийг буулгалаа гэдэг шиг арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авна.

Зөвшөөрлийн хуулиар 110 зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд шилжүүлнэ. Би хуулиа хүлээж байгаа. Монгол хуультай орон учраас. Ингэж чадвал би 110 зөвшөөрлийн үйл ажиллагааг мэргэжлийн холбоонд зоригтоо шилжүүлнэ.

Дээрээс нь төрийн үйлчилгээний албан хаагчид 10 жилийн дотор хүн амын тоо чинь 400 мянгаар даваад байгаа учраас төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо өссөн.

Гэтэл “төрийн захиргааны албан хаагч” өсөөгүй юм билээ. Маш бага үзүүлэлттэй.

Тийм учраас цаашдаа бид энэ public service, CV service ангилж, төрийн албаны шинэчлэлийн эхний зам бол цалин хөлс, нэмэгдлийг нэг хуулиар шийдэх гэж байгаа.

Тэгээд ер нь миний явуулж байгаа, манай Засгийн газрын явуулж байгаа бүх бодлого уялдаатай шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Далайгийн Батбаяр гишүүн асуултаа асууя. 3 минутаар. Шууд.

Д.Батбаяр: Та түрүүн татвар төсөв бүрдүүлдэг гол хэрэгсэл биш гэж хэлсэн.

Тэгэхээр төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын маань 94 хувийг нь татварын орлого өөрөө бүрдүүлээд байгаа юм.

Тэгээд нарийн тодруулаад хэлэх юм бол 32.8 хувийг нь орлогын албан татвар бүрдүүлж байгаа.

- › 21.4 хувийг нь нэмэгдсэн өртгийн албан татвар,
- › 17.2 хувийг нийгмийн даатгалын орлого,
- › 6.5 хувийг нь гадаад үйл ажиллагааны орлого,
- › 4 хувийг нь онцгой албан татварын орлого,
- › 18.1 хувийг нь бусад төрлийн татвар хураамж эзэлж байгаа.

Тэгэхээр орлогын албан татварыг нь ахиад цаашаа задлах юм бол 71 хувийг нь аж ахуйн нэгжүүд, 29 хувийг нь хувь хүмүүс төлж байгаа гэсэн үг.

Тэгээд бусад орнуудтай харьцуулахаар яг энэ татварын орлогыг нь дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулах юм бол хөгжиж буй орнуудад ойролцоогоор 15-аас 20 хувийг нь төлдөг бол Монгол Улс дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 35 хувьтай тэнцэх хэмжээний татварыг иргэдээсээ, аж ахуйн нэгжүүдээсээ хурааж авч байгаа. Ямар нэгэн дотаци, ямар нэгэн татвар, төлбөр гэдэг хэлбэрээр авч байгаа гэсэн үг.

Тэгэхээр товчилж хэлэх юм бол Өмнөд Солонгос Улстай адил хэмжээний түвшний татвар татан төвлөрүүлдэг мөртлөө Филиппин, Вьетнам гэсэн улсуудтай адилхан хэмжээний цалин тэтгэвэр, аж ахуйн нэгжүүдүүдийн орлого нь хамаарагдаж байгаа байхгүй юу.

Өөрөөр хэлэх юм бол аж ахуйн нэгжүүдүүдийн орлого, иргэдийн цалин хөлс нь Вьетнам болон Филиппин улсуудын хэмжээнд байна.

Та өмнө нь Цахим хөгжлийн сайд байсан, Хэрэг эрхлэх газрын дарга байсан, Эдийн засгийн сайд байсан, Улсын Их Хурлын дарга байсан. Одоо Ерөнхий сайд хийж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Далайгийн Батбаяр гишүүнд 1 минут.

Д.Батбаяр: Тэгэхээр Та өмнө Цахим хөгжлийн сайд байсан, Хэрэг эрхлэх газрын дарга байсан, Эдийн засгийн хөгжлийн сайд байсан, Улсын Их Хурлын дарга байсан. Одоо Ерөнхий сайд хийж байгаагийн хувьд хангалттай хэмжээний мэдээлэлтэй байгаа.

Мөн хангалттай хэмжээний маш их хэмжээний оролцоотой байсан. Өдийг хүртэлх Монгол Улсын эдийн засагт.

Монгол орны татвар нь өндөр, төсөв нь хэтийдсэн, төр нь данхар байна.

Тэгэхээр өнгөрсөн 10 гаруй жилийн турш баримталж ирсэн татварын эдийн засгийн бодлого нь буруу байсан гэдгийг иргэдийн амьдрал ч тэр, аж ахуйн нэгжүүдүүдийн хаагдсан данснууд ч гэсэн харуулж байна.

Тэгэхээр Та 10 жилийн турш эрх барьсан намын даргын хувиар эдгээр татварын бодлого, эдийн засагт авч хэрэгжүүлсэн бодлого нь буруу байсан юм гэдгийг хүлээн зөвшөөрөх үү. Маш богинохноор хэлээч. Тийм үү, үгүй юу гэдэг дээр. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Үе үед мэдээж эрх барьж байгаа намыг удирдаж байсан дарга нар өнгөрсөн хугацааны амжилтаа ахиулаад алдааг нь засаад л урагшилдаг.

Тийм ч учраас би өнгөрсөн хугацааны алдааг засаж, амжилт ололтыг ахиулж л явахыг л эрмэлзэж байгаа.

Мэдээж эдийн засаг томроод, татвар сайн орохоор татвар их авлаа гээд байж болохгүй.

Тэгэхээр эдийн засаг томорсон. 2023 оны статистикаар бид чинь дундаж орлоготой орон руу шилжсэн.

Тэгэхээр одоо бид нар тийм том сорилтын өмнө байна. Тэр middle income дээр байна. Одоо цаашаа яах вэ. Цаашаа яах вэ гэхээр 40 жилийн өмнө батлагдсан стандарт. Тэр IMF (International Monetary Fund)-ээс гаргасан стандартаар 40 жил төсвийг барьж явна гэвэл явахааргүй болж байна.

Нэг ёсондоо 1986 оны тэр стандарт одоо ингээд 4 үе, 40 жил явсаар л байна.

Тийм учраас өнөөдрийн төсөв дээр реформ хийхээс өөр замгүй болжээ. Энэ Төсвийн тогтвортой байдлын хууль, төсвийн чөдөр тушаа болж байгаа зүйлс дээр илүү эдийн засгийг идэвхжүүлэх хандлагыг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байгаа учраас бид төсөв дээр реформ хийж эхлүүлнэ.

Тэгэхдээ ер нь энэ реформ үр дүнд хүртлээ бараг 5 жилийг давна.

Тэгэхдээ эхлүүлэх ёстой. Юу вэ гэхээр нийт хөрөнгө гэж ярьдаг. Тэр нийт хөрөнгөө үнэлье. Тэгэхгүй бол манай төсөв чинь өөрөө л орлого, зарлагын бүртгэл болоод байна шүү дээ.

Гэтэл Монгол Улс хэдий хэмжээний хөрөнгөтэй юм, үнэлгээ нь хэд юм гэдгээ мэддэггүй, тоолж чаддаггүй.

Тэгэхээр энэ төсөв чинь өөрөө хуучин арга барилаар өнөөдрийг удирдвал дундаж орлоготойгоос дээш явж чадахгүй. Миний барьж байгаа зарчим энэ байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд 1 минут авах уу? Болсон уу? Дараагийнх Ганбатын Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайдад.

Гадуур аж ахуйн нэгж, бизнесүүд хумигдаж байгаа, үйл ажиллагаа нь доголдож байна. Энэ талаар танд мэдээлэл байгаа байх гэж ойлгож байна.

Тэгээд аж ахуйн нэгж, бизнесүүд хумигдаад байгаа нь, үйл ажиллагаа нь доголдоод байгаа нь данхар төр, мөн татварын дарамтаас болж байгаа гэж Та бодож байна уу? Энэ бас нэг шалтгаан гэж ойлгож байна.

Тэгээд миний асуух гол асуулт бол салбарууд байгаа. Жишээлбэл, барилга, үйлчилгээ, хөдөө аж ахуй гээд хамгийн олон ажлын байр бий болгодог энэ салбарууд дээр татварын өөр хувь хэмжээтэй. Хамгийн их орлого олж байгаа экспорт хийж байгаа уул уурхайн салбарт өндөр татвар авдаг юм уу гэх жишээний салбаруудад татварын өөр өөр хувь хэмжээтэй бодлого хэрэгжүүлж, ийм арга хэмжээ авч ажиллах бодол байна уу? Танд.

Миний хувьд татварын хувь хэмжээн дээр харилцан адилгүй тогтоож, хамгийн олон ажлын байр бий болгож байгаа салбаруудаа дэмжиж ажилламаар байна. Ямар ч улс орон хүнд хэцүү цаг үед, эгзэгтэй цаг үед ажлын байр бий болгох, бүтээн байгуулалт хийх, ажлын байраа хадгалах гээд ийм зүйлүүдийг авч хэрэгжүүлдэг.

Тэгэхээр дэлхий нийтээр ч гэсэн бүтээн байгуулалтын зардал өсөж байна.

Тэгэхээр Монгол Улсад маш их хийх ажил байгаа. Энэ бүтээн байгуулалт, зам, барилга хийх ажлуудаа яг энэ хямралын үед, энэ эгзэгтэй цаг үед хийгээд явах нь дээр гэж харж байгаа.

Тийм учраас салбаруудыг дэмжсэн өөр өөр татварын хувь хэмжээ байх тал дээр ямар бодолтой байна гэдэг асуултыг асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Үндсэн хуульд заасан энэ ялгаваргүй байх зарчим буюу салбар салбарын татварыг өөр өөрөөр тогтоох нь би буруу гэж үздэг.

Хэрвээ харин өндөр орлоготойгоос нь илүү татвар авч тэр дундаж давхаргаа дэмжих нь л өөрөө зөв бодлого.

Тийм учраас энэ шаталсан татвар луугаа алхам алхмаар явах нь бид чинээлэг дундаж давхаргыг бий болгоход том нөлөөтэй байна.

Өнөөдөр топ 100 аж ахуйн нэгж татварын орлогын бараг 65 хувийг тэд л бүрдүүлдэг. Бид татварын орлогын 65 хувийг бүрдүүлдэг шиг олон олон компанид төрөн гараасай л гэж бодож байгаа.

Тийм учраас энэ “чөлөөлье” гээд байгаа бодлого, зөвшөөрөл, хүнд суртал, дүрэм журам, саад тээгийг арилгая, энэ цахимжуулъя гээд байгаа бодлого хувийн хэвшилд ээлтэй бодлого. Үүнээсээ гадна илүү олон баялаг бүтээгч нарыг төрүүлэн гаргахын тулд татварын саяын хуулиар, жишээ нь, одоогийн 2025 оны

байдлаар 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтаас доош орлоготой 4800 гаруй аж ахуйн нэгж бараг 91 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн юм билээ.

Нөгөө орон нутагт авч байгаа татварын хөнгөлөлтийг эдэлсэн 360 гаруй аж ахуйн нэгж 42 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн юм билээ. Энэ босгыг 2.5 тэрбумд хүргэвэл 180 мянга гаруй аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ гэж бодож байгаа. Маш олон компани төрөн гарна гэж бодож байгаа.

Дээрээс нь өмнө нь 6 тэрбум хүртэлх дээрээ бид 10 хувь аваад л шууд түүнээсээ дээш бол 25 хувь авдаг байсныг дунд нь 15 хувь гээд болгоод эхлэхээрээ бодитойгоор уул уурхайн бус мөртлөө 6-аас 10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой таны хэлж байгаа барилгын бусад салбарын бодит 300 компани илүү олон ажлын байрыг нэмэгдүүлнэ гэж бодож байгаа.

Тийм учраас –

- хөдөлмөр эрхэлж байгаа,
- баялаг бүтээж байгаа,
- ажлын байр нэмэгдүүлж байгаа –

-компаниудыгаа дэмжиж олноор нь гаргахын төлөө ажиллах нь... /минут дуусав/

Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Өдрийн мэнд хүргэе.

Нэг шаардлага байгаа. С.Бямбацогт даргыг Улсын Их Хурлын дарга учраас намаасаа түдгэлзүүлэхийг шаардаж байгаа.

Яагаад гэхээр Улсын Их Хурлын гишүүн болохдоо би нам намаасаа түдгэлзэхийг дэмжиж байна гэсэн. Энэ Улсын Их Хурал өөрөө бяргүй, дээрээс нь бүүр шүдгүй боллоо.

Та намын дарга. Улсын Их Хурлын дарга өөрийнхөө намын гишүүн байгаа учраас танаас асуулт асууж, шаардлага тавьж, иргэдийн нэрийн өмнөөс шаардаж чадахгүй байгаа учраас Улсын Их Хурлынхаа даргыг намаасаа түдгэлзүүлэхийг шаардаж байгаа юм.

Асуулт нь, 1992 оны өмч хувьчлал тухайн үеийн эрх мэдэлтэй байсан, мэдээлэлтэй байсан хүмүүс аваад хулгай болсон. Одоо тэгвэл өмч хувьчлал хийж тодорхой төрийн өмчийг хувьчлахдаа Та иргэдэд хэзээ хүртээлтэйгээр өмч хувьчлал хийж, иргэдийн амьдралд нөлөөлж чадах вэ?

Хоёрдугаарт, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд төртэй өрсөлдмөөргүй байна. Жишээлэхэд, Төрийн банк. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт нь, Та Монгол Ардын намын дарга. 2016 оноос хойш завсаргүй засаглаж байгаа намын дарга.

- Та гишүүн байсан,
- сайд байсан,
- Улсын Их Хурлын дарга байсан,
- Ерөнхий сайд байгаа учраас танаас асууж байгаа юм.

Төрийн банкны захирлын цалин 2021-2024 оны нийлбэр дүнгээрээ 2 тэрбум. Энэ бол төрөөс тэрбумтан төрж болдгийн нэг жишээ.

“Эрдэнэс Монгол” байна. Н.Наранцогт гэдэг даргатай байсан. Энэ даргыг Та Монголбанк руу Ерөнхийлөгч болгоод явуулсан. Дараагийнх нь дарга ирээд хүмүүсийг халж эхэлсэн. Нэг хүнийг халахдаа 100 саяас 300 сая төгрөгийн тэтгэмж өгч явуулсан.

Тэгтэл тэтгэмж өгч байгаа дарга нар төрийн өмчит аж ахуйн нэгжүүдүүдийн зардал бүртгээд өгөөд байгаа. Уг нь буруутай этгээд нь энэ зардлыг төлөх ёстой. Та үүнийг төлүүлж чадах уу?

Гуравт нь, ажилтнуудынх нь цалин жишээлэхэд “Эрдэнэс Монгол” дээр 5 сая байсан. Одоо 12 сая төгрөг болсон. “Эрдэнэс Монгол” төсвөөр бол 2022 онд 3 тэрбумын боловсон хүчний зардалтай байсан. 2025 онд 18 тэрбум буюу 6 дахин өссөн. Иргэдийн амьдрал ингэж өсөж чадсан уу? Энэ зөвхөн танай намтай холбоотой... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Өмч хувьчлалын талаарх иргэний боловсрол 90-ээд оныг бодвол эрс сайжирсан байна.

Гадаад, дотоодод өндөр боловсрол эзэмшсэн олон сайхан залуучуудтай баг болж ажиллаж гаднын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээр хийж нүүр дүүрэн суудаг баг олон залуучууд төрж гарсанд би баярлаж байгаа.

Тийм учраас итгэл үнэмшил байгаа. Монгол залуучууд хэнтэй ч хэлэлцээр хийж чадна гэдэг.

Тийм учраас өмч хувьчлалыг ч гэсэн өөр өнцгөөр харж чадах юм байна. Тэр 90-ээд оны өмч хувьчлалын үетэй харьцуулшгүй юм билээ.

Тийм учраас хамгийн зөв арга зам бол өөрөө ашигтай компаниудынхаа шэйрүүдийг нэгтгээд хөрөнгө оруулалтын сангаа байгуулаад, түүнийгээ хөрөнгө

оруулалт, менежментийн компаниар удирдуулаад тэд үнэлгээ аудит хийгээд мөнгө босгох арга зам.

Сая Узбек амжилттай боллоо гээд ярьж байна. Энэ зам руу сонголтоо хийсэн. “Эрдэнэс Монгол” компани гэж Та хэлж байна. “Эрдэнэс Монгол” компани хуультай. Үндэсний баялгийн сангийн хуулиар орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд буюу энэ төрийн эзэмшлийн 34 хувийн e-mongol дээр харагдаж байгаа 306 мянган төгрөгийг энэ компани байгуулагдсанаар хийсэн.

66 хувь нь төсөл хэрэгжүүлээд 34 хувиа нэмнэ шүү гэдэг зорилготой ажиллах ёстой. Хоёр дахь чиг үүрэг нь. Ийм л хоёр чиг үүрэгтэй.

Дээрээс нь хөрөнгөө удирдах ёстой.

Тэгэхээр яг энэ хуулийнх нь чиг үүрэг рүү бүрэн шилжүүлнэ.

Дээрээс нь компанийн засаглалын дагуу компани гүйцэтгэлээр санхүүжилт олгодог гүйцэтгэх захирлууд шаадаг. Тийм. Буруутай этгээдээр үнэхээр шаардлагатай бол төлүүлэх арга хэмжээнүүдийг авна шүү дээ.

Тийм. Тэгээд л явна. Тэгээд гол нь бид компанийн бие даасан байдлыг нь хангавал компанийн засаглалыг нь дэмжих ёстой.

Их Хурлын даргын асуудал дээр мэдээж хууль барьсан байгаа байх.

Тэгээд хуулиа баталбал хуулиа хэрэгжүүлнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Да.Цогтбаатар гишүүн 1 минут. Цаг дууссан.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Ерөнхий сайдаас асуулт асууна.

Сүүлийн 10 жилд тасралтгүйгээр Ардын нам Монгол орныг удирдаж байна. Сүйрүүлж байна.

Манжийн үеийн удирдаж байсан удирдлагаас Та нар долоон доор удирдаж байна. Манжийн үеийн мөнгө хүүлэлт одоо жаргал. Өнөөдөр Монголын ард түмэн аппликэйшнийхээ зээлд живсэн байна.

Та нар бодоод үз. 2016 онд 7-гоос 8 их наядаар улсын төсөв батлагддаг байсан бол одоо 33.9, 34 их наяд. Үндсэндээ 4-өөс 5 дахин нэмэгдсэн. Монголын ард түмний амьдрал 4-өөс 5 дахин нэмэгдээгүй. Харин эрх баригчдыг тойрсон тендерчин компаниуд Та нарын амьдрал 50, 100 дахин нэмэгдсэн байх.

Миний асуулт. Энэ их төсөв, энэ их тендер, найр наадам чинь үнэхээр Монголын ард түмэнд бүүр дээрэм болж байна. Нэгхэн жишээ хэлье. Та асуултад их тодорхой хариулаарай. Яагаад гэвэл Та үе үеийн Засгийн газарт байсан. Энэ сүүлийн 10 жилд.

Төсөвт өртөг нь 6.01 их наядаар газрын тосны үйлдвэрийн газар төсөвлөгдсөн. Би одоо урьдчилж асуултаа явсан учраас танд бүгдээрээ байгаа байх. Тэгэхээр тодорхой хариулт өгөөрэй.

2018 оны 1 дүгээр сарын тогтоол нь Энэтхэгийн –

- 1 тэрбум ам.долларын зээлээр газрын тос боловсруулах үйлдвэр барина.
- 760.0 сая ам.доллараар үйлдвэр барина.
- 240.0 сая ам.доллараар дамжуулах хоолой барина гэж заасан.

Засгийн газрын тогтоол. Яагаад энэ өнөөдөр 1.7 их наяд болов оо?

1 тэрбум байж байгаад 1 тэрбум 236.0 сая доллар болсон. Дараа нь 431.0 сая доллар нэмэгдсэн.

Энэ болгон дээр Их Хурал, Засгийн газар хүчиндэж орж ирж үүнийг батлуулдаг. Энэ дээр миний асуулт. Улс төрчид энэ дээр шийдэх ёсгүй. Мэргэжлийн хөндлөнгийн эксперт, шинжээчдийн дүгнэлт гарсан уу? Хэдэн хүний гарын үсэг зурсан бэ? Хэн хэн гэдэг эрдэмтэд байгаа вэ?

Хоёрдугаар асуулт. Минийх ийм хурдан явдаг юм даа. Яах вэ... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Таны асууж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэр барих нь Монгол Улсад хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй.

Бид 2.2 тэрбум долларын... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Ерөнхий сайдаас Ардчилсан намын бүлгийн гишүүд асуулт асууж дууслаа. Хугацаа дууслаа. /алх цохив/

Дараа нь Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн гишүүд асуулт асууна. Нэрс өгнө үү.

Отгоны Саранчулуун гишүүн. Энэ ирцийн дарааллаар орж ирж байгаа. Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд аа.

Өнөөдөр ээжүүд маань гадаа талбай дээр одноо энгэртээ зүүгээд хүүхдүүдийнхээ төлөө. Удахгүй хүүхдийн баяр болох гэж байна. Ээжүүд маань ч гэсэн саналаа хэлж байна.

Төр хүүхдүүдийг хамгаалах ямар бодлого хийж байна. Энэ тамхины асуудал юу болж байна гэдэг асуудлыг хэлж байна.

Ерөнхий сайд аа, электрон тамхины асуудлыг Та бид хүүхдүүддээ хугацаатай тэсрэх бөмбөг үүрүүлчхээд явуулаад байна гэдэгтэй санал нийлэх үү?

Тамхины хяналтын тухай хуулийг санаачилж оруулсан. Улсын Их Хурал дээр ажлын хэсэг нь хуралдаж чадахгүй гацсан. Үүгээр ч барахгүй Евразийн түр хэлэлцээр буюу худалдааны хэлэлцээрийг Монгол Улс 5 улсын Засгийн газартай байгуулж одоо 7 сарын 22-нд энэ хэлэлцээр хэрэгжиж эхлэх гэж байна.

Энэ хэлэлцээр дээр янжуур тамхины гаалийн албан татварыг тэглэж орж ирсэн. Үүнийгээ засах үүргийг энэ оны 4 сарын 15 гэхэд Засгийн газраас оруулж ирж дотоодын хууль тогтоомжоороо онцгой албан татвараараа нөхөж орж ир гэдэг үүргийг өгсөн боловч өдий хүртэл энэ зүйл орж ирээгүй байна.

Хямд өртөгтэй янжуур, хуулийн зохицуулалтгүй электрон тамхи энэ улсад үнэхээр хүүхдүүддээ үүрүүлсэн хугацаатай тэсрэх бөмбөг гэж Та үзэж байна уу?

Та энэ асуудал дээр намын дарга, Ерөнхий сайдын хувьд манлайлал үзүүлж хүүхдүүдийнхээ эрүүл мэндийг хамгаалахын төлөө Улсын Их Хурлаас гаргасан энэ үүрэг чиглэлийг биелүүлэх ажил дээр хэрхэн яаж ажиллах вэ гэдгийг асуумаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Евразийн эдийн засгийн холбоотой хийсэн чөлөөт худалдааны хэлэлцээрийн дагуу гаалийн тариф тэглэгдэж байгаа.

Энэ нэг талаасаа инфляцыг бууруулахад тодорхой нэгж хувиар хувь нэмрээ оруулах бодлого мөн. Дээрээс нь экспортыг дэмжих буюу дотоодын үйлдвэрлэгч нарыгаа олон улсын зах зээл дээр гарахад дэмжлэг үзүүлж байгаа.

Тэгэхээр таны тавьж байгаа асуудал зөв. Гаалийн тариф тэглэгдээд ороод ирэхээр электрон тамхийг дэмжиж байгаа бодлого болох вий гэж санаа зовж байгааг би ойлгож байна.

Тэгэхээр төсөвтөө дагалдуулж онцгой албан татварыг нэмж орж ирнэ. Тийм шийдэлд хүрсэн гэдгээ өмнө нь ч би илэрхийлж байсан.

Тэгэхээр одоо зөвхөн нэг улс дээр гэхээсээ илүү онцгой татвараараа зохицуулаад явах нь өөрөө зөв бодлого гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр хүүхдүүдийг электрон тамхинаас хол байх, электрон тамхинаас холдоход анхаарах ёстой. Үүнийг ч гэсэн нийгэм олон нийтэд бид ярьж таниулж ойлгуулах ёстой. Та үүн дээр тодорхой манлайлал үзүүлж ажиллаж байгаад би талархдаг.

Цаашдаа мэдээж хүүхдийн эрүүл орчинд амьдрах нөхцөл байдлыг бий болгохын тулд тодорхой арга хэмжээ авахгүй бол болохгүй байна. Ерөнхий сайд Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга байдаг. Би анхныхаа хурлыг хийсэн.

Гэтэл өнгөрсөн хугацаанд үүрэг даалгавар өгсөн биелэлт бараг 100 хувь биелээгүй гэж би дүгнэлт гаргасан. Сая тодорхой арга хэмжээнүүдийг авлаа. Үнэхээр нийгэмд үүсээд байгаа цочирдом олон нөхцөл байдлууд ээж, аавууд бид бүхний сэтгэлийг сэртхийлгэм үйл явдлууд өрнөж байна.

Тийм учраас хүүхдийн төлөө ажиллах нь манай Засгийн газрын бодлого байна.

Тэгээд танд би өмнө нь ч байр сууриа илэрхийлж байсан. Төсөв дагуулаад онцгой татвараа нэмээд оруулаад ирнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Дууссан. 1 минутын эрх байгаа билүү? Дууссан дууссан. 1 минутаа авах юм уу? 1 минут өгье. О.Номинчимэг гишүүнд.

О.Номинчимэг: Төсөв дагуулж орж ирэх юм бол Ерөнхий сайд аа, 7 сарын 22-ноос дараа оны 01 сарын 01 хүртэл ямар ч татваргүй тамхи орж ирэх нь. Энэ тамхинаас болж жилд Монгол Улс 4300 иргэн амь насаа өвчлөлийн улмаас алддаг. Өдөрт 13 хүн гэсэн үг.

Тэгэхээр үүнийг ингэж сул чөлөөтэй 6 сар татваргүй оруулж ирэх нь хэний эрх ашигт нийцэх юм бэ? Монгол Улсын нийт иргэдийн эрх ашигт нийцэхгүй. Цөөхөн хүний эрх ашигт нийцэж магадгүй. Энэ асуудал дээр түрүү жил 12 сард энэ Улсын Их Хурлын тогтоол гараад 4 сарын 15 хүртэл оруулж ирэх асуудал дээр эс үйлдэхүй гаргасан. Сайд нартаа Та хариуцлага тооцож чадах уу?

Энэ хүүхдүүдийнхээ эрүүл мэндийг хамтдаа уушги эрүүл мэндийг нь хулгайлж байгаа энэ асуудалтай бид тэмцэж хамтдаа Та зогсож чадах уу гэдэг дээр би хариулт авмаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Гаалийн татварыг тэглээд онцгой дээр нь ижил тогтоож оруулж ирж асуудлыг шийднэ.

5 дугаар сарын 31-нээр хөрөнгө оруулалтын тендерийн хугацаа дуусаж байгаа. Түүнээс шалтгаалаад төсөвт тодотгох уу, намар ирэх жилийн шууд төсвөө барих уу гэдгийг шийдвэрлэх юм.

Хэрвээ тодотгох шаардлагатай гэж үзвэл шууд авч орж ирнэ. Намар хүртэл тодотгол хийхгүй гэж үзвэл, 31-нээс шалтгаалаад хийхгүй гэж үзвэл дангаар нь өргөн мэдүүлэхэд бэлэн байна.

Тэгээд ингээд шийдвэрлээд явъя. Харин нөхдөдөө хэлэхэд тамхинд онцгой татвар нэмэхээр татвар нэмлээ гээд битгий шүүмжлээд байгаарай гэдгийг.

Дээрээс нь таны хэлдэг зөв. Зарим татварын бодлогууд чинь цөөхөн хүнийг дэмжээд байна шүү.

Тийм учраас тэр 1 хувийг анхаараарай. Тэр цөөн хүнд зориулагдсан хууль байна лээ шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Отгоны Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Сайн байна уу?

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр хоёр зүйлийг тодотгож асуух гэсэн юм. Монголд байгаа хүмүүс ер нь тэтгэвэрт гарсны эхний 10 жилийн дотор зүрх судасны өвчин их болоод, тэгээд эхний 10 жил харвалт маш их байдаг.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр 2.1.1.21 дээр ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлнэ. Энэ дээр төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ гэж заасан байгаа.

Тэгээд одоо энэ үйлчилгээ ямар байгаа тухай мэдээллийг авах хүсэлтэй байна. Иргэдэд мэдээлэл хэрэгтэй байгаа.

Хоёрт нь, боловсролтой холбоотой асуудал байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй 13 мянга орчим хүүхдүүдээс яг үнэндээ 20, 30 хувь хүрэхгүй нь л сургуульд сурч байгаа. Бусад нь ямар нэгэн байдлаар бид бусадтай адилхан боловсрол авч чадахгүй байгаа ийм хүүхдийн баярыг бид тэмдэглэх гэж байна.

Засгийн газрын хөтөлбөрт яг үүнтэй холбоотой хоёр зүйлийг тусгасан байгаа юм л даа. Нэгдүгээрт нь, сургалтын байгууллагын хүртээмжийг сайжруулна гэсэн байгаа. Дотуур байр гээд.

Тэгэхээр одоо шинээр ашиглалтад орох гэж байгаа сургууль, дотуур байрнуудын хүртээмжийн асуудал ямаршуу байгаа вэ гэдгийг тодруулах гээд байгаа юм.

Дараа нь бид орон нутгаар баахан явсан. Эцэг, эхчүүд хүүхдүүдээ яаж өсгөх вэ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ яаж хооллох вэ гэдэг дээр яаж бие даан амьдрахад нь сургах вэ гэдэг дээр үнэндээ л арга зүй хэрэгтэй байгаад байдаг.

Тэгэхээр тэр хүмүүст тусалдаг мэргэжилтнүүд нь юу байдаг вэ гэхээр сэргээн засахын мэргэжилтнүүд байдаг. Хөдөлгөөн засалч, хэл засалч, протез, ортез, тэгээд сэтгэл зүйч гэх мэтээр. Энэ хүмүүсийг боловсролыг дэмжих жилийнхээ хүрээнд уг нь сургалтын боловсролын эрэлттэй мэргэжилд оруулах саналыг би өмнө нь удаа дараа Засгийн газарт тавьж байсан. Энэ асуудал юу болсон тухай огт мэдээлэл авсангүй. Ингээд жил тойрон боллоо л доо.

Тэгэхээр энэ дээр яг тодорхой мэдээлэл авъя.

Хамгийн сүүлд нь тун удахгүй энэ саадгүй орчны тухай, хүртээмжийн тухай хууль өргөн барих гэж байна. Конвенцтой холбоотойгоор. Одоо бид хэчнээн барилга... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: 2024 онд Ахмад настны хуулийг баталж нэмэлт, өөрчлөлт оруулсан. 2025 оноос энэ хууль хэрэгжиж байгаа.

Тэгээд таны тодорхой мэдээлэл байна. 2025 онд өдрөөр асрах болон гэрээр асрах, байнга байрлуулан асрах үйлчилгээг 23 байгууллага үзүүлээд 2500 орчим ахмад настан хамрагдаж, 1 тэрбум төгрөгийг халамжийн сангаас зарцуулсан.

Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг 2025 онд 37 хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудад үзүүлсэн. Давхардсан тоогоор 65 мянган ахмад настан хамрагдаж 1.2 тэрбум төгрөг зарцуулсан.

Тасалгааны хувилбарт үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагуудаар мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлээд гэрээний үндсэн дээр явж байгаа.

Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд холбогдох хуульд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Тэр нь зорилтот бүлгүүд рүүгээ чиглэсэн нийгмийн үйлчилгээг ойртуулна.

Тэгээд яг таны хэлж байгаа зөв. Ерөөсөө манай халамж ихдээд байна гэдэг мөртлөө яг хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ, асаргаа хэрэгцээтэй иргэддээ хүрч байгаа нь 26-хан хувь. Тэр хөдөлмөрлөж байгаа, эрүүл саруул ажлаа хэвийн явуулж байгаа хүмүүсийг л халамжилдаг нь бараг 70 хувь хүрчхээд байдаг. Яг зорилтот бүлэгт халамж хүрэхгүй байна.

Тийм учраас сая Их Хурал, Засгийн газраас Халамжийн хууль, Гэр бүлийн хөгжлийг дэмжих хуулийг барьсан. Үүнийг ялгаатай авч үзнэ.

Мөн Та түрүүн хэлсэн. Боловсролын зээлийн санг бид Хөгжлийн сан болгоно. Хөгжлийн сан болгохын тулд яг таны хэлж байгаа нарийн мэргэжлийн ортипед, протезын их эмч, мэргэжилтэн, техникч, хэл засалч гээд нарийн мэргэжлүүдийг бид эрэлтийн мэргэжлийн жагсаалтад бичнэ. Шаардлагатай бид үүнийг зээлийн сангаас 100 хувь санхүүжүүлнэ.

Яагаад гэвэл үнэхээр мэргэжилтэн дутагдаж байгаа. Би өөрөө хөгжлийн бэрхшээлтэй цэцэрлэг байгуулж байсан учраас зовлонг нь ойлгож байна.

Тэгэхээр зээлийн сангийн шинэчлэлийн хүрээнд арга хэмжээг авна.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд 1 минут.

Н.Учрал: Дотуур байрны хэрэгцээ шаардлага зайлшгүй байна.

Тэгэхээр мэдлэг, ур чадварын хоцрогдлоос монгол хүүхдээ чөлөөлье гэдэг бодлогыг Засгийн газар боловсролын салбарт дэвшүүлж байгаа. Энэ хүрээнд бид “хотхоны бага сургууль” гэдэг концепцыг яг цэцэрлэгтэй адилхан шийдэж байна.

Тэгэхгүй бол сургууль барилаа, цэцэрлэг барилаа гээд багш олдохгүй, менежментийг нь авч явах хүн байдаггүй. Ийм байдалтай.

Хөгжлийн бэрхшээлтэй сургууль, цэцэрлэг, асаргааны төв, сувиллуудыг хувьсах зардлаар дэмждэг шиг хувийн хэвшил мэргэжлийн холбоод хийх боломжоор нь хангана.

Дээрээс нь бүс болгон нэг Кембрижийн сургууль, сургууль болгон нэг google-ийн сургууль, хүүхэд бүрийн ширээн дээр google chrome, тэгээд cloud орчноос нь удирдаад, хүртээмжийг нь нэмэгдүүлэх чиглэлээр контент, хөтөлбөр боловсруулах гээд зорилтот бүлгүүд рүү чиглэсэн арга хэмжээнүүдийг авч байгаа.

Тэгээд сум дундын ахлах сургууль, төрөлжсөн сургууль, суманд 9 жил, сум дунд 12 жил гэдэг концепц явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Сайн байна уу? Өмнө асуулгын цаг дээр хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой асуулт асуугаад хариулт авч амжаагүй юм. Тэр талаар асууя.

Манайд хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин нэлээн бага байгаа мөртлөө хөдөлмөрийн зах зээл дутагдалтай байдаг.

Тэгээд энэ чиглэлийн бодлогууд салбар салбараасаа хамаарсан өөр өөр байх шаардлагатай харагдаад байгаа. Тухайлбал, жишээлбэл уул уурхайн салбар гэхэд ээлжийн зохицуулалтыг 14/10 гээд хатуу зохицуулснаасаа болоод хүний нөөцийн нэмэлт хэрэгцээнүүд бий болгож байна. Үүнийг дахиад өөрчлөх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм.

Мөн аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалан, барилга гэх мэтчилэн салбарууд улирлын шинжтэй бизнесүүд дээр гаднаас ажиллах хүчин оруулж ирэх, энэ төлбөрийн зарим нь 50 хувь хөнгөлж бүрэн чөлөөлөх бодлого явуулбал, энэ зах зээлийг богино хугацаанд эрэлт үүсдэг салбарын хэрэгцээг нь гаднаас хангаад явбал бололцоо боломжууд байгаа харагддаг.

Тэгээд үүнээс гадна бас нэг том зах зээл бол оюутан болон тэтгэврийн насныхныг хөдөлмөрийн зах зээл дээр нэмэх боломж байгаа.

Тэгээд Ө.Шижир гишүүн нарын гишүүд оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн хуулийн төсөл санаачилж байгаа.

Саяын салбарын бодлогууд болон оюутан тэтгэврийн насныхныг хөдөлмөрийн зах зээл дээр бэлдэх. Үүнтэй холбоотой татвар, нийгмийн даатгалын хураамж, шимтгэлийг нь хөнгөлөх, чөлөөлөх иймэрхүү шинэ арга хэмжээ авах тийм бодол санаа байгаа юу?

Гол нь үүнийг асуугаад байгаа нь таны зөвлөх энэ талаар байр сууриа илэрхийлсэн байсан л даа.

Тэгэхээр үүнийг олзуурхаж. Хэрвээ ийм бодлого байгаа бол танилцуулаач ээ гэсэн ийм санаа байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ажиллах хүчний эрэлтийн тэр барометрийн судалгаагаар хувь нь 2025 онд ажил олгогчдын 23 хувьд 40 мянган ажиллах хүчний хомсдол үүссэн.

Тэгэхээр таны хэлж байгаатай би санал нэг байгаа. Яг ажиллах хүчний оролцооны түвшин бага байгаа. Дээрээс нь яг нийгэм дээр, зах зээл дээр эрэлттэй ажлын байранд шаардлага хангахуйц хүн олдохгүй болсон.

Тийм учраас ажиллах хүчний оролцооны түвшин хангалтгүй байгаа дээр бид дүгнэлт хийгээд барилга, хөдөө аж ахуй, аялал жуулчлал ч гэдэг юм уу салбаруудыг нь онцлоод дотоодын ажиллах хүчний нөөцтэй уялдуулах ийм бодлогыг барина.

Тийм учраас бизнесийн эрх чөлөөний өргөн барих гэж байгаа хууль дээр ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэхээр тодорхой өөрчлөлтийг би тусгасан байгаа гэдгийг хэлье.

Үүнийг шийдвэрлэхийн тулд алхмуудыг хийсэн. Сая Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 30 төвийг бид хувийн компаниудаар удирдуулах шийдвэрийг гаргасан. Менежментийг нь өгсөн гэсэн үг.

Тэгэхээр том аж ахуйн нэгж байгууллагуудад ТУЗ-ийнх нь даргыг өгөөд менежментийг нь Та нар хий гээд өгсөн. Бид нэг зүйлийг шаардаж байгаа. Хувьсах зардлыг өгөх дэмжлэг нь байж болно. Төрөөс. Бусад менежментэд тэр хувийн компани авч яв.

Гол нь эрэлтээ өөрсдөө зарла. Манай компанид хэдэн цахилгааны инженер хэрэгтэй байна, дулааны инженер хэрэгтэй байна гэдгийг зарлаад хувийн хэвшил бол зөвхөн тухайн МСҮТ-ийг төгссөн төгсөгчийг ажилд авах л үүргийг хүлээнэ.

Тэгэхээр нөгөө компанидаа хэрэгцээтэй мэргэжлүүдээрээ л зарлаад явах энэ ажил их дэвшилтэт ажил болж байгаа. Цаашдаа компанийн дэргэд МСҮТ байгуулах.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн асуулт асуух цаг дууслаа. /алх цохив/

Цөөнхийн гишүүдээс асуулт асууна. Нэрсийг өгнө үү. ХҮН намын зөвлөлөөс Баатаржавын Мөнхсоёлын нэр өгсөн байна. Б.Мөнхсоёл гишүүнийг урьж байна.

Б.Мөнхсоёл: Энэ өдрийн амрыг эрье.

Гурван гол асуудлаар асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт нь, төсвийн бодлогын шинэчлэлийн хүрээнд асуулт.

Үндэсний статистикийн хорооноос гарсан мөнгөний статистикийн мэдээллийн дагуу 2026 оны эхний 4 сарын урьдчилан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 8.9 их наяд төгрөг хүрсэн. Энэ нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 459.7 их наяд төгрөгөөр өссөн буюу төсвийн нийт зарлага эргэн төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 10.4 их наяд байгаатай харьцуулахад төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгт хүрсэн. Үүнийг бид зөндөө ярьсан байгаа.

Тэгээд нөгөө талдаа дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан төсвийн нийт зардлын эзлэх хувь 2024 онд 38.3 хувь, 2025 онд 35 байсан бол 2026 оны 4 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 45 хувьд хүрсэн. Бүр 45 хувь. Тийм ээ.

Тэгэхээр энэ хэмжээ дунджаар олон улсын түвшинд 25 хувьтай байвал сайн гэсэн ийм үзүүлэлт болж өгдөг.

Тэгэхээр Монголбанкны судалгаагаар төсвийн урсгал зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн 1 хувийн өсөлт нь хоёр улирлын дараагаас импортыг 0.2-оос 0.4 хувиар нэмэгдүүлдэг. Нөгөө талдаа Үндэсний аудитын газрын тайланд 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний 57.3 хувь нь үр дүнгүй, нийт санхүүжилтийн зөвхөн 37.9 хувь нь гүйцэтгэгдсэн гэж дүгнэлт гарсан.

Тэгээд яриад байвал маш олон юм байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг эдийн засгийн тооцоо бүрэн хийгдээгүй байна гэсэн дүгнэлт бас өгсөн байгаа.

Тэгээд ингээд олон энэ статистик үзүүлэлтүүд, төсвийн тогтвортой байдал болон үндэсний аудитын гаргасан дүгнэлтүүд бусад... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя. 1 минут нэмж өгье. Б.Мөнхсоёл гишүүнд.

Б.Мөнхсоёл: Баахан яагаад ийм асуулт асуух гээд байгаагаа урьдчилсан нөхцөл байдлаа хэлсэн.

Тэгэхээр Та өөрөө “чөлөөлье” гэсэн аяныг эхлүүлсэн. Засгийн газраас хэзээ яг төсвийн бодлогоо хумиад мөнгөний зөөлөн бодлого явуулж, хувийн сектороо дэмжих вэ? Хэрхэн энэ байдлаас эдийн засаг дахь төрийн оролцооноос бүгдээрээ хувийн сектороос чөлөөлөх вэ гэдэг эхний асуултыг тавья. Өөрийн чинь гол зорилго бас уг нь үүнтэй нийцэж байгаа. Бодит байдал дээр хараахан биеллээ олохгүй нөгөө талдаа цаг хугацаа алдаад байна.

Тэгээд өнөөдөр уур амьсгал ямар байгаа нь байна гэхээр хувийн сектор, аж ахуйн нэгжүүд, хувь иргэд сэтгэл хангалуун биш. Ямар сайндаа хүн амын орлогын албан татварыг 1 хувь болохыг бүгдээрээ нийтээрээ дэмжээд явж байх вэ дээ. Энэ бизнесийн орчин үнэхээр таагүй байна. Олон бага болон дунд орлоготой иргэдийн амьжиргаа улам уруудаж байна. Ядуурлын түвшин өндөр хэвээрээ, аж ахуйн нэгжүүд бас хаалгаа... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн яг таны хэлснээр 2024 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 36.8, нийт зарлага ба

цэвэр зээлийн дүн дотоодын нийт бүтээгдэхүүний 37, 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 33.4 гээд явж байна.

Тэгэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа ямар зорилгыг баримталсан бэ гэхээр тэтгэврийг инфляцтай уялдуулж нэмэх ёстой. Цалин хөлсийг бас инфляцтай уялдуулж нэмэх ёстой. Гэхдээ төрийн оролцоог хумих ёстой гээд.

Өнгөрсөн жил бид баталсан төсвийн хүрээнээр тэнцвэржүүлсэн орлого дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 37 байсан. Буурсан. Давуу тал болсон. Энэ удаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг мөн үе шаттай бууруулсан.

- 2027 онд - 31.9,
- 2028 онд - 30.4.

Энэ орон зайд бид татварын шинэчлэлийг хийх ёстой гэж зорьж байгаа.

Тийм учраас татварын хуулийг барихдаа хөдөлмөрлөж байгаа хэн бүрийг дэмжье.

Тэгээд энд нэг орон зайг бий болгоё. Ажлын байрыг нэмэгдүүлэхийг бий болгоё гэдэг зорилгоор энэ татварын хуулийг барьсан юм. Нөгөө нэг данс битүүмжлэх дээр хүртэл 20 хувийг нь үлдээгээд түүгээрээ урсгалаа санхүүжүүлээд явах. Хэдий өр төлбөртэй байлаа ч гэсэн гэдэг бодлого ч гэсэн үүн рүү чиглэсэн.

Жишээ нь, гаалиар бараа, бүтээгдэхүүн оруулж ирлээ гэхэд нөгөө НӨАТ төлөхийг нь 2 сарын дараа төлж болно ч гэдэг юм уу. Дээрээс нь нөгөө аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 1 болж байгаа. 2.5 болгохоор энд 180 мянга шүү. НӨАТ суутган төлөгчийн босгыг 400 болгохоор системээ эвдэхгүйн тулд e-barimt дээр бүртгэхээд 100 хувь буцаан олголт хийвэл ахиад 23 мянган компани шүү гээд.

Гэтэл өөдөөс яг таны хэлж байгаагаар 1 хувь гээд ороод ирэхээрээ энэ чинь төсвийн бодлогоо оруулж ирэхэд энэ нь өөрөө уялдахгүй байгаа юм.

Тийм учраас Засгийн газрын тэр “чөлөөлье” гээд байгаа бодлого чинь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого байхгүй юу. Хэрэглээг дэмжих биш. Тэгээд энэ болгон хоорондоо уялдаж байж намрын төсөв батлагдсан. Түүнээс өмнө... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулж дууссан уу? 1 минут өгье.

Н.Учрал: Түүнээс өмнө бид нийгмийн даатгалын шимтгэл, татвар хоёр чинь нийлээд 32 хувь болоод байна шүү дээ. Одоо GDP-ийн.

Гэтэл түүний чинь 26 нь татвар байдаг. Шимтгэл нь татвар шиг ойлгогдоод байдаг. Тэгээд шударга биш байгаад байдаг. Инфляцтай уялдуулж нэмнэ гээд байдаг. Нэмэхээр бага дээр нь бага нэмэгдээд, их дээр нь их нэмэгдээд байдаг. Ингээд явсаар байгаад шударга бус байдал байгаад байгаа учраас энэ болгоныг засах ажлуудыг ээлж дараатай хийж байгаа.

Тийм учраас халамжийн хууль, Гэр бүлийн хөгжлийг дэмжих хууль. Ирэх долоо хоногт би нийгмийн даатгалын хуулийг шударга тэтгэврийн тогтолцоо гээд шилжүүлээд энэ татварын хуулийг батлаад өгвөл намрын төсөв дээр энэ нийгмийн даатгалын хууль ч тэр, энэ батлагдсан татварын хууль ч тэр нэг мөр шууд хэрэгжих юм бол энэ зарлага, дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хэмжээ буурч байгаа орон зай дээр бид дэвшил гаргаж чадна.

Тэгвэл энэ 5 жилийн чиглэл дээр тавьсан тэр индикатор дээр хүрч чадна л гэж ингэж зорьж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Батын Батбаатар гишүүн. Та болсон. Тийм. Хоёр дээр нэмэх нь нэг болсон. Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Өнөөдөр 2026 оны 5 сарын 29-ний өдөр.

Та 2026 оны 3 сарын 30-ны өдөр энэ танхимаас томилогдсон. 107 гишүүн оролцож 82.2 хувиар Монгол Улсын 35 дахь Ерөнхий сайдаар томилогдсон. Долоо хоногийн өмнө Ерөнхий сайдад бид асуултаа явуулдаг. Дэг нь тийм.

Тэгэхээр миний асуултыг би товчхон хэлье. 60 хоног болж байна. Та томилогдоод. Энэ хугацаанд иргэдийн амьдралд бодитоор мэдэгдсэн ямар өөрчлөлт гарсан, иргэдийн хамгийн их ярьж байгаа үнэ, орлого, орон сууц, ажлын байр, түгжрэл хэвээр байна.

- 60 хоногийн бодит үр дүн 3 үзүүлэлтээр хэлж болох уу?
- Мөн 100 хоног хүрэхэд өөрөөр хэлбэл дараагийн 40 хоногт Монгол Улс 2026 оныг давах эдийн засаг, төсөв, нийгмийн бэлтгэлээ хангаж чадсан уу?
- Хэрвээ хангаж чадсан гэж бодвол, хэрвээ чадахаар ямар 3 хэмжигдэх үр дүнгээр батлах вэ? Тоо буюу хэмжээс ярина гэсэн үг.

Тэгэхээр хэрэв чадахгүй бол улс төрийн болон бодлогын ямар хариуцлагыг Ерөнхий сайдын хувьд манлайллаа гаргаж ямар хариуцлагыг, зарим тохиолдолд өөрийнхөө багт ажиллаж байгаа хүмүүст хариуцлага тооцох байх. Зарим тохиолдолд өөрөө хариуцлага өөртөө тооцуулах тухай асуудал болох байх.

Тэгэхдээ би Монгол Улсын Засгийн газар тогтвортой урт удаан хугацаанд ажилладаг байгаасай гэж хүсдэг. Энэ парламент 3 дахь Ерөнхий сайд, 3 дахь Их Хурлын даргаа даргынхаа нүүрийг харсан.

2004-2008 онд тэгж 3 хүний нүүр хараад 7 сарын 01 болсон. Бид бас бодох ёстой. Тогтвортой засаглалыг хүсэх ёстой. Тийм болохоор энэ асуултад маань хариулж өг.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Чи засаж засварлах асуудал олон байгаа.

Тэгэхээр төслүүдийг эрэмбэлсэн. Мөн төрийн албанд re-engineering-ийг хийж дууссан.

Тийм учраас төсөвтөө дагуулж энэ re-engineering хийх бодит шинэчлэлийг хийхэд бэлэн болсон.

Тоон дээр ярих юм бол би мэдээж нөгөө цахимын сайд байхаасаа авхуулаад гааль татварын систем, e-mongol системийг хариуцаж байсны хувьд гааль дээр байгаа яг нийлүүлэлтийн гарлын инфляцыг өдөөдөг логистикийн асуудлыг шийдвэрлэхээр Эдийн засгийн сайд байхаасаа хийсэн ажлын үр дүнд тодорхой дэвшлүүд гарч байгаа.

- ▶ Экспорт дээр 5 дугаар сарын 27-нд сард 2 тэрбум доллар болж өссөн үзүүлэлттэй байна.
- ▶ Нүүрс өнгөрсөн сараас 3.5 сая тонн нэмэгдсэн. Бодитой үр дүн гарсан. Сүүлийн сарын өсөлтийг мөн оны мөн үетэй харьцуулахад 5.3 сая тонноор сайжирсан байна.
- ▶ Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх дээр мөнгөний бодлого, төсвийн бодлогыг уялдуулсны үр дүнд 7.3 тэрбум доллар валютын нөөцөө барьж байна.

Эрэлтийн гаралтай инфляц эдээр арга хэмжээ авахын тулд хүнсний ногоо, инфляцыг өдөөж байгаа өргөн хэрэглэдэг мах болон бусад бүтээгдэхүүнүүдээр зохих арга хэмжээнүүдийг авч үнийн өсөлтийг хязгаарлаж чадлаа.

- Бензин шатахуун, нийлүүлэлтийн гаралтай инфляцыг өдөөдөг олон хэлэлцээрийн үр дүнд Оросын Холбооны Улстай хэлэлцээр хийсний дүнд бензин шатахууны үнийг өсгөхөөс урьдчилан сэргийлсэн.
- Бараг 2.2 тэрбум долларын Монголд хөрөнгө оруулалтыг татах гангийн

төслийн сонгон шалгаруулалтыг зарлаа.

- 700 гаруй сая доллароор бүрдэх зэс боловсруулах цогцолбор. Үнэлгээний хороо байгуулагдаад Хөрөнгө оруулалтын гэрээ рүү орж байна.

Олон олон ажлын байр нэмэгдүүлэх төслүүдийн эхлэлийг тавилаа.

Ж.Бат-Эрдэнэ: Батын Батбаатар гишүүнд 1 минут.

Б.Батбаатар: Сүүлийн үед Улсын Их Хурал 2027 оны хөгжлийн төлөвлөгөө, төсвийн төсөөлөл, төсвийн хүрээ хэлэлцэж байгаа учраас макро эдийн засгийн тоонуудыг маш олон удаа олон дахин давталттай эргэж сонссон байх.

Одоо би өөр зүйл. Илүү нарийвчлах ёстой. Бид илүү иргэндээ хүргэх ёстой гэж ойлгож байгаа. 60 хоногт мэдээж бүх асуудлыг шийдэх боломжгүй. Гэхдээ Засгийн газрын хандлага буюу чиглэл бодлого тодорхой болох хангалттай хугацаа.

Тэгээд өмнөх сайд хийж байх үеийн чинь ажлуудыг ер нь огт асуухгүй байгаа гэдгийг ойлгож тэр тухайгаа ярихгүй байвал сайн байна. Ерөнхий сайдын хувьд ажиллаж байгаа энэ 60 хоногийнхоо асуудлыг.

Монголын дундаж өрх 60 хоногийн хугацаанд юугаараа өөр болсон бэ? Өмнө нь би ярьж байсан. Тэд нарын хөргөгч дүүрсэн үү, түрээгүй юу? Үнэ ханш ямар болсон юм? Халаас нь зузаарсан уу: зузаараагүй юу? Тэд ажилтай болж чадаж байна уу? Энэ үлдсэн 40 хоногт тэрийг шийдэж болох ямар зүйл байна.

Ж.Бат-Эрдэнэ: Н.Учрал Ерөнхий сайд хариулья.

Н.Учрал: 3 сарын 30-наас хойш бид тулаад ирсэн сорилтуудыг давж чадсан.

Би хэллээ. Бензин шатахууны асуудал, бусад инфляц өдөөгөөд байгаа асуудлууд дээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авсны үр дүн бас гарч байна.

Дээрээс нь төр ард иргэддээ итгэвэл, компани, аж ахуйн нэгжүүдүүддээ итгэвэл тодорхой үр дүн гардаг гэдгийг харуулсан. Олон жил, олон сар хэл ам дагуулж байсан багш, эмч нарын цалин өчигдрөөс авхуулаад цалин хөлсөө аваад, нэг цалинтай болоод нэмэгдлээ тооцуулаад эхэлсэн байна. Бас л сайн жишиг.

Мөн бид компани, аж ахуйн нэгжүүдүүдийн дансыг нэг сар татварын өртэй ч гэсэн байсныг битүүмжилснийг нээсний үр дүнд 72 тэрбум төгрөг татвар төлсөн.

Төр иргэд, аж ахуйн нэгжүүдүүдээ итгэвэл үр дүн гардгийн тод илэрхийлэл эндээс харагдаж байгаа.

146 үйл ажиллагааг зөвшөөрөл шаардахгүйгээр эхэлдэг болсон. **license.mn** нээгдлээ. Хувийн хэвшил бүх сервисийг нь гаргаж өгсөн. Цаашдаа төрийн үйлчилгээ иргэдэд ойртох эхний том том алхмууд тавигдсан.

Ж.Бат-Эрдэнэ: Дууссан. Улсын Их Хурал дахь цөөн хэдэн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдад талархал илэрхийлье.

С.Бямбацогт: Гишүүдийг чуулганы танхимд урьж байна. Улсын Их Хурлын асуулгын цаг дууссан. 16.00 цагаас санал хураалттай.

Дараагийн асуудал. Гишүүдийг танхимд урьж байна.

Арван гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн
2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна.

Х.Баасанжаргал: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал 126 гишүүнтэй болсноор нийгмийн олон талт төлөөлөл бүхий парламент бүрдэх нөхцөл бий болсон.

Ингэснээр ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагад сонгогдон ажиллаж буй гишүүдийн хувьд өргөсөн тангарагтаа үнэнч

байж бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлага тэр хэрээр нэмэгдсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-д гишүүний нэр хүнд бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахыг хориглосон бол Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-д гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, улс төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баримтлан ажиллана гэжээ.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөрт нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.

Мөн зүйлийн 6.4-д албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болохуйц нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт 2.4-д төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно гэсэн болно.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 5 дугаар зүйлийн 3-д оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж тэмцэхэд нийцэхүйц байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээнд тогтмол дүгнэлт хийж байхыг чармайна гэсэн болно.

Монгол Улсын хувьд авлигалын төсөөллийн индексээр сүүлийн 9 жилийн хугацаанд тогтмол оноо буурч, 2024 оны байдлаар 180 орноос 114-д эрэмбэлэгдэж байсан бол 2025 оны байдлаар 124-д эрэмбэлэгдэж байгаа бөгөөд нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглах, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үзүүлэлтээр хангалтгүй үнэлэгдсэн хэвээрээ байна.

Парламент нийгмийн хөгжлийн үндсэн асуудлыг ардчилсан зарчмаар шуурхай шийдвэрлэхийн тулд үйл ажиллагааныхаа үр өгөөжийг дээшлүүлэх, тухай бүр боловсронгуй олгож байх ёстой институц төрийн эрх барих дээд байгууллагын хувьд бусад байгууллагын үлгэр жишээ байх учиртай.

Монгол Улсын Их Хурлын гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг илүү тодорхой болгож, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг

боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж энэхүү хуулийн төслийг миний бие Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат нарын хамт санаачлан боловсрууллаа.

Дэлхийн ихэнх улс орны парламент үйл ажиллагааны ил тод, шилэн байдлаа хангахын тулд өөрийн гишүүдийн ашиг сонирхлын мэдүүлэг, бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн.

Тухайлбал, Их Британи Улсын парламент ашиг сонирхлын бүртгэлд тогтмол хөтөлдөг бөгөөд тухайн чуулганаар хэлэлцэж буй асуудлын талаар гишүүдийн хийсэн мэдэгдэл, тухайн гишүүний цалин хөлс, шагнал урамшуулал, гадаад, дотоод томилолтод зарцуулсан зардал зэргийн талаар тогтмол мэдээлж хэвшжээ.

Евро парламент өөрийн гишүүдийн санхүүгийн ашиг сонирхлын бүртгэлийг тогтмол хөтөлдөг бөгөөд уг бүртгэл парламентын албан ёсны веб хуудаст нээлттэй байршдаг.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг “нээлттэй мэдээлэл” гэж үзнэ гэсэн ба Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна. 25.2-т энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан, иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй гэж заасан.

Иймд Улсын Их Хурлын гишүүдийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мөн тухайн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээд орлого олж байгаа, эсвэл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй тухай гишүүний мэдэгдлийг Улсын Их Хурал албан ёсны цахим хуудастай нэгэн адил нийтэлж, иргэдийн мэдэх эрх, парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана гэж үзлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар гишүүн тодорхой асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй бол хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг хориглосон.

Энэ хязгаарлалтыг хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мөн адил хамаарахаар зохицуулах нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23-д заасан гишүүн ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах үүрэг гийг бодитой хэрэгжүүлнэ гэж үзэв.

Дэлхийн ихэнх улс орны парламентад хэлэлцэж буй асуудлын талаар ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд санал хураалтад оролцохгүй байх замаар тухайн асуудлаарх байр сууриа илэрхийлдэг жишиг түгээмэл байна.

Энэхүү жишиг нь зөвхөн тухайн гишүүн өөрөө болон түүний гэр бүлийн гишүүдээр хязгаарлагдахгүйгээр эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, нэгдмэл сонирхолтой этгээдийг ч хамарч байна.

Гэвч өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн хэрэгжилт хангалтгүйн улмаас гишүүд ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед санал хураалтад оролцохгүй байх үүргээ санаатай болон санамсаргүй шалтгаанаар тухай бүр биелүүлж чадахгүй ирсэн байдаг.

Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан шаардлагад одоогийн зохицуулалтыг нийцүүлж, гишүүнийг зөвхөн өөрийг нь болон гэр бүлийн гишүүдээр нь хязгаарлахгүйгээр түүнтэй хамаарал бүхий этгээдийг хуулийн үйлчлэлд хамааруулахаар төсөлд тусгалаа.

Хэлэлцэж буй асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж санал хураалтад оролцоогүй гишүүн хуралдааны ирцтэй байх нь түүний бүрэн эрхийн асуудал ч ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж санал хураалтад оролцоогүй бөгөөд ирцээсээ гараагүй байгаа гишүүнийг эсрэг санал өгсөнд тооцсон тохиолдол гарч байв.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 11 дэх хэсэг тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсвэл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэсний дагуу бүртгэлээсээ гарсан ч эсрэг санал өгснөөр тооцох эрсдэлтэй байна.

Хуулийн төсөл батлагдсанаар парламентын ардчилсан, ил тод байдлыг хангах, гишүүдийг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа илүү боловсронгуй, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой, тодорхой болох, эерэг үр дүн гарч, хууль тогтоомж үйл ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын гишүүдийн ирц, идэвх оролцоо, сахилга хариуцлага, ёс зүй нэмэгдэж, ард түмний засаглах эрхийг бодитой хангахад эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн дэмжиж өгөхийг Та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Хууль санаачлагч Х.Баасанжаргал гишүүнд.

Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Ж.Баярмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдөр хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсанаас хойших 14 жилийн хугацаанд Улсын Их Хурлын гишүүн ашиг сонирхлын зөрчилтэй асуудлаар санал хураалтад оролцохгүй байх үүргээ биелүүлсэн хоёрхон тохиолдол байгаа нь хууль хэрэгжихгүй байгааг илтгэж байх тул Улсын Их Хурлын гишүүдийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтэд мэдээлэх, чуулганы хуралдааны өмнө болон явцад гишүүн хэлэлцэж буй асуудалд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэн ашиг сонирхлын бүртгэлд бүртгүүлж нийтэд нээлттэй мэдээлэх төсөл боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын гишүүн ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд санал хураалтыг хэрхэн явуулах, санал хураалтын системд ашиг сонирхлыг бүртгэх, шинэ товчлуурыг нэмэгдэх эсэх, мөн ашиг сонирхлын зөрчлөө урьдчилан мэдэгдээгүй гишүүнд ямар хариуцлага тооцох талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаач илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Их Хурлын тухай 3, 4 хууль байгаа. Их Хурлын. Энэ хуулиудаар асуултуудыг явуулаад саналаа хураая. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Би энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

Тэгээд хууль дээр дутуу зохицуулсан зүйл байсныг Х.Баасанжаргал нарын гишүүд олж засаж сайжруулсан ийм зүйл заалт оруулж ирсэн байна лээ.

Тэгээд Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7.5 дээр болохоор Үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой асуудлаас бусад тохиолдолд гишүүд хуралдаанд оролцох үүрэгтэй байгаа.

Гэтэл нөгөө талдаа хуралдаанд оролцоод санал хураалтад орохдоо дэмжсэн дэмжээгүй гэдэг хоёр л сонголттой.

Өөрөөр хэлбэл ашиг сонирхлын зөрчилтэй хүн энд ороод 7.5-аар үүргээрээ чуулгандаа оролцох үүрэгтэй.

Тэгээд чуулгад оролцоод санал өгөхгүй байх тийм сонголт байхгүй байсан. Зөвхөн энэ агуулгаараа болохоор дэмжсэн, дэмжээгүй гэхээр дэмжээгүй гэдэг агуулгаар өөрөөр хэлбэл кноп дарахгүйгээрээ өөрийнхөө ашиг сонирхлын төлөө санал өгөх ашиг сонирхлын зөрчилтэйгөөр эсрэг саналаар өөрийнхөө саналаа дэмжих ийм бололцоо боломж байсныг хааж зохицуулж байна.

Тэгэхээр энэ дээр өөрөөр хэлбэл чуулганд оролцоод санал өгөхгүй байх эрхтэй зохицуулалт шинээр бий болж байгаа юм.

Тэгэхээр үүнийг хууль санаачлагчаас үүнтэй холбогдуулж хэдэн асуулт асууя.

Хэрвээ ашиг сонирхлын зөрчилтэйгөө мэдсээр байж. Бараг хүн болгон мэддэг шүү дээ. Манай сайд ийм салбарт байдаг, тийм бизнес хийдэг гэдэг мөртлөө үүнийгээ мэдэгдэхгүйгээр санал хураалтад дэмжсэн, дэмжээгүй гээд гараад байдаг.

Тэгэхээр энэ тохиолдолд жишээлбэл тэр саналаас нь болоод тухайн ашиг сонирхол нь зөрчилтэй зүйл хууль нь дэмжигдэх магадлал байгаа. Энэ тохиолдолд хэдийгээр шийдэгдсэн ч гэсэн дэмжсэн саналыг нь хасдаг ч гэдэг юм уу, иймэрхүү зохицуулалт хийх бололцоо боломж байдаг уу, үгүй юу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, саяын ярьсан чуулганд оролцоод санал өгөхгүй байх өөр ашиг сонирхлын зөрчлөөс өөр тохиолдол байх эсэх талаар Та хэд бодож үзсэн үү гэсэн ийм хоёр асуулт байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Х.Баасанжаргал гишүүн. Хууль санаачлагч хариулъя.

Х.Баасанжаргал: Д.Энхтүвшин гишүүнд баярлалаа. Энэ маш чухал асуудал юм байна гэж олж харж байгаа гишүүддээ би талархаж байгаагаа илэрхийлье.

Яагаад гэвэл бид Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн асуудал гэдэг ёс зүйн босго гэдэг чинь юугаар хэмжигдэх юм бэ гэдэг бидний ойлголт нэг түвшин ахиж байгаа гэсэн үг.

Зөвхөн ирц төдийгөөр хэмждэг асуудал ерөөсөө биш. Үнэхээр өөрийнхөө бизнес, өөрийнхөө ах дүү, хамаатан садантайгаа хамаарал бүхий бизнес, үүндээ давуу байдал олгох төрлийн санал хураалтад оролцохгүй байх ёс зүйн үүрэг маш чухал ёс зүйн үүрэг байдаг. Дэлхийн бусад улс оронд.

Тэгэхээр бид үүнийг нэгэнт нэвтрүүлэх цаг нь болсон гэж хэлье.

Яг энэ ашиг сонирхлын зөрчилтэй атлаа дэмжсэн санал өгсөн байх юм бол үр дагавар нь яах вэ гэж байна. Дэлхийн улс орнуудын хувьд энэ дээр нэг хамгийн гол чухал баримталдаг зүйл нь юу вэ гэвэл энэ өөрөө ёс зүйгээ зөрчсөн гишүүний асуудал гээд тухайн гишүүний ёс зүйн асуудал дээр онцгой ач холбогдол өгдөг юм билээ. Яг асуудлыг шийдвэрлэсэн процессоос илүү энэ гишүүний ёс зүйн асуудал гэдэг дээр маш онцгой ач холбогдол өгдөг.

Энэ хуулийн төсөл дээр ямар агуулгаар орсон бэ гэвэл хэн ер нь ашиг сонирхлын зөрчилтэй атлаа ямар асуудалд санал өгсөн бэ гэдэг нь одоо болтол бид нарт ямар ч нээлттэй мэдээлэл огт байхгүй. Ийм төрлийн бүртгэлийг манай парламент өнгөрсөн 34 жилийн хугацаанд нэг ч удаа хийж байгаагүй.

Энэ хуулийн төслийг санаачлахдаа би Их Хурлын Тамгын газраас лавлагаа аваад өнгөрсөн. Энэ парламентын хугацаанд ашиг сонирхлын зөрчлөө илэрхийлж байсан тохиолдол байна уу. Хэчнээн хүн орж байгаагүй юм. Ямар тохиолдлууд байна гээд харахад ердөө хоёрхон тохиолдол байсан.

Тэгэхээр бид бүгдээрээ мэддэг хэрнээ, бүгдээрээ гадарладаг хэрнээ, бүгдээрээ харддаг хэрнээ энэ бүртгэл, энэ механизмыг ерөөсөө өнөөдөр амьд явуулж ирж байгаагүй юм байна гэдэг дүгнэлтэд хүрэх хэрэгтэй.

Хоёрдугаарт, өнөөдөр Х.Баасанжаргал ашиг сонирхлын зөрчилтэй гээд санал хураалтад ороогүй өол энэ бүртгэл нь нээлттэй байснаараа олон нийтийн хяналт үүн дээр бий болно гэж харж байгаа. Энэ хүн ашиг сонирхлын зөрчилтэй атлаа дэмжсэн санал өгсөн байна шүү дээ гэдэг энэ олон нийтийн хяналт, олон нийтийн шахалт, Их Хурлын гишүүдийн, төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүйн өндөрлөгийг өндөр болгоход маш чухал ийм механизм гэж бид хараад. Ингээд гишүүдийнх нь тухайн асуудалд санал өгсөн гишүүний ёс зүйн асуудлыг заавал Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр шийддэг байхаар хуулийн төсөлд оруулж ирсэн. Дээрээс нь үүрэгжүүлж орж ирж байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт, нэг зүйл дээр өөр санал өгөхгүй байх тохиолдол гарах уу гээд. Үүн дээр бид “түдгэлзүүлэх” байдлаар санал хураалтын кноп байж болох юм гэдгээр эхлээд судалгаа хийсэн. Гэхдээ “түдгэлзэх” гэдэг нь “дэмжсэн”, “эсрэг” өгсөн, “түдгэлзэх” гэдэг. Гурав дахь нь санал хураалтын дахиад горим юм билээ. Горим буюу нэг төрлийн санал.

Тэгэхээр энэ дээр ерөөсөө түдгэлзэх гэдэг асуудал ашиг сонирхлын зөрчил дээр огт байдаггүй. Бүр санал өгөхгүй байх гэдэг энэ... /минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа.

Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна.
Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя. Алга байна.
Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна.
Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна.
Чинбаатарын Анар гишүүн асуултаа асууя. Алга байна.
Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Алга байна.
Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя. Алга байна.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг нэгтгээд явуулъя. Их Хурлын тухай хууль байгаа. Хууль, тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж бүлэгт харьяалагддаг гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. /алх цохив/

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үгээ хэлье.

Х.Тэмүүжин: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

2008-2012 оны Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Ж.Энхбаяр гишүүн, Ж.Сүхбаатар гишүүн бид хэд “Авлигын эсрэг албан бус бүлэг” гэж анх Улсын Их Хурал дээр байгуулаад, тэгээд сонирхлын зөрчилтэй холбоотой хууль тогтоомжийг анх санаачлан батлуулж байсан юм.

Ер нь нийтийн албанд алба хашиж байгаа албан тушаалтан нийтийн ашиг сонирхлыг өөрийн хувийн сонирхлоос ангид, бие даасан байдлаар, тэрний төлөө ажиллах ёстой, хувийнхаа сонирхлыг хязгаарлах ёстой. Хязгаарлагдаж чадахгүй байгаа сонирхлоос зугтах ёстой. Зугтах ганц арга зам нь шийдвэр гаргалтаас түдгэлзэж, хойшоо сууж, өөр сонирхлын зөрчилгүй хүмүүсээр шийдвэрийг нь гарга гаргуулах нь шударга ёсны буюу хууль ёсны зарчмын гол агуулга байсан.

Тэгээд энэ агуулгатай холбогдуулаад Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой сонирхлын зөрчлийг ил тодорхой болгоё гэдэг санаачилга гаргаж байгаа хуулийг би дэмжиж байгаа.

Энэ сонирхлын зөрчилтэй холбоотой хууль тогтоомжтой холбоотойгоор бид бас дахиад сууриар нь том нэг зүйлийг харах ёстой юм.

Ер нь Зүүн Европын улс орнууд анх удаа улс төрийн соёлоороо төрийн албаны ёс зүйгээр хэмжигдэж болдог энэ сонирхлын зөрчил гэдэг ойлголт пост коммунист улс орнуудад хэмжигдэхгүй байна. Хэмжигдэхгүй байгаа учраас пост коммунист буюу захиргаадалтын аргаар нийгмийг удирддаг байсан социализмаас чөлөөт нийгэм рүү шилжсэн улс орнуудын төрийн байгууллагууд хувийн ашиг сонирхлоо хязгаарлах соёл алга байна. Нөгөөтээгүүр албаны ёс зүй гээд зүгээр субъектив байдал дээр найдаад орхиход бас учир дутагдалтай байна.

Тийм учраас хууль тусгайлан гаргаж ирээд шийдэх ёстой гэдэг байдлаар энэ сонирхлын зөрчлийг хязгаарлахтай холбоотой хуулиас анх гарсан юм.

Үүнтэй холбогдуулаад Зүүн Европын улс орнууд дахиад ямар асуудал хөндсөн бэ гэхээр парламентын хяналтыг бие даасан байдлаар хэрэгжүүлдэг Төрийн албаны зөвлөл гэдэг институцийнхээ дотор нийт төрийн албан хаагчдын сонирхлын зөрчлийг хязгаарлах, түүнд хяналт тавих механизмыг бий болгох

ёстой гэдэг зорилго тавиад парламентын дэргэд зүй ёс зүйн ийм омбудсмен маягтай төрийн албаны зөвлөлийн институцүүдийг бий болгосон юм.

Монгол Улс үүнийг хийж чадаагүй алдаа гаргаад Авлигатай тэмцэх газар дээр сонирхлын зөрчил болон энэ чиглэлийн мэдүүлгийг хянадаг бүтцийг бий болгоод “мөрдөн шалгах байгууллага” болон “соён гэгээрүүлэх” гэдэг энэ ёс зүйн үйл ажиллагаатай холбоотой юмыг холиод хийсэн.

Үүнээсээ болоод бидэнд маш том нэг алдаа гараад байгаа. Тэр нь юу вэ гэхээр төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчид мэдүүлгээ өгөхдөө өөрийнх нь эсрэг гэмт хэрэгтэй тэмцдэг байгууллагад мэдүүлгээ гаргаж өгдөг болоод хувирсан.

Тэгэхээр өөртөө итгэхгүй. Миний гаргаж өгсөн мэдээллийг буцаагаад тэр байгууллага миний эсрэг ашиглана гэдэг ийм сонирхлын зөрчил рүү ороод институцийнхээ хувьд жоохон зовлонтой болсон. Үүнийг Улсын Их Хурал нэг талаасаа бодох ёстой.

Хоёрдугаарт нь, дахиад биднийг нэг том алдаа юу вэ гэхээр Улсын Их Хурал хажуудаа байгаа хяналтын бүтцэд төрийн дээд албан тушаалтнуудын мэдүүлгийг аваад сонирхлын зөрчлийг нь хянах ёстой юм. Тэр дундаа –

- ▷ Ерөнхий сайд,
- ▷ Засгийн газар,
- ▷ Ерөнхийлөгч,
- ▷ Авлигатай тэмцэх газрын дарга,
- ▷ цагдаа,
- ▷ тагнуул,
- ▷ шүүх,
- ▷ прокурор –

-гэх мэтчилэн дээд албан тушаалтнуудын сонирхлын зөрчил үүсгэж болох хөрөнгө орлогын мэдүүлгийг парламентад дэргэдээ авч хянадаг тогтолцоо руугаа шилжих ёстой.

Дэлхийн бүх улс орон ийм байдлаар ажиллаж байгаа.

Тэгээд парламент өөрөө энэ хяналтаа хүчтэй хэрэгжүүлэхийн тулд парламентын гишүүд өөрсдөө сонирхлын зөрчилгүй байх ёстой, мэдүүлэг нь ил тод байх ёстой гэдэг манлайллыг өөрсдөө үзүүлж байгаа.

Одоо бид юу болсон гэхээр монопол эрхийг Авлигатай тэмцэх газарт бий болгосонтой холбоотойгоор –

- ▷ тагнуул,
- ▷ АТГ,
- ▷ прокурор,
- ▷ шүүх,
- ▷ Үндсэн хуулийн цэц –

-гэх энэ байгууллагуудын тэнд сонирхлын зөрчилтэй шийдвэр гарч байгаа, авлигад автаж байгаа, эд хөрөнгө... /минут дуусав/

С.Бямбацогт: Х.Тэмүүжин гишүүнд баярлалаа.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн саналаа хэлье, үгээ хэлье.

Р.Эрдэнэбүрэн: Их Хурлын тухай хуулийн талаар гишүүд тус тусдаа хуулийн төслүүд санаачлаад өөрчлөлтүүд хийгээд орж ирээд байна.

Тэгэхээр тус тусдаа явж байгаа санаачилсан хуулийн төслүүд, өөрчлөлтүүдийг нэгтгээд явж болдоггүй юм уу?

Энэ чинь одоо тэгээд бүгд л нэг зүйл, заалт, хоёр зүйл, заалт өөрчилсөн өөрчлөлт ярьсаар байтал хуулийн чинь концепц гэж юм байна. Энэ юм чинь өөрчлөгдөөд, цаашдаа ийм байдлаар яваад байх юм уу? Их Хурлын дарга аа. Үүнийгээ нэгтгэж базаад.

Одоо Ж.Бат-Эрдэнэ даргын санаачилсан бас нэг төсөл явж байгаа. Х.Тэмүүжин гишүүний төсөл явж байна. Одоо ингээд Х.Баасанжаргал гишүүний төсөл явж байна.

Эд нарыг бүгдийг нь нэгтгээд дахиж ярьж болдоггүй юм уу? Ингээд л тус тусдаа санаачлаад л, тэгээд дэмжигдэхгүй, дэмжигдсэн ийм байдалтай яваад байх юм.

Хоёрдугаарт, миний бодол бол бид ингээд авлигатай тэмцэх сонирхлын зөрчилтэй тэмцэх гээд л хуулиа учиргүй нарийсгаад байх тусам улам л авлигалын индекс чинь унаад л байх юм. Тэгээд энэ зөв явж байдаг юм уу, буруу явж байдаг юм уу?

Хуулиа нарийс нарийсгах тусам авлигалын индекс чинь улам унаад байна гэдэг чинь юун дээр байна? Энэ дээрээ сайн дүгнэлт хийж ярьж үзэх шаардлагатай байдаг юм болов уу гэж боддог юм.

Тэгээд ийм саналтай байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Р.Эрдэнэбүрэн гишүүн чухал санал гаргаж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны болон Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудад өөрчлөлт оруулахаар Н.Учрал дарга Их Хурлын даргын хувьд ажлын хэсэг байгуулсан. Ц.Сандаг-Очир гишүүн ахалж ажиллаж байсан.

Улсын Их Хурлын гишүүд санаачлаад өргөн барьсан байгаа. Өнгөрсөн долоо хоногт хэлэлцэх хэсгүүд нь бүгд шийдэгдсэн.

Энэ долоо хоногт Улсын Их Хурлын бусад гишүүдийн Улсын Их Хурлын тухай болон дэгийн тухай, Хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулиудын хэлэлцэх эсэхийг шийдэж байгаа.

Хэлэлцэх эсэх нь дэмжигдэх юм бол эдгээрийг нийлүүлээд нэгдсэн нэг ажлын хэсэг байгуулаад хаврын чуулгандаа эцэслээд баталъя.

Тэгээд нэгдсэн нэг ажлын хэсэг байгуулахаар хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулийн зүйл, заалтуудын хоорондын зөрчил, энэ бүх юм жигдрээд нэгтгэгдээд явна.

Энэ бодлогын хүрээндээ энэ асуудлууд шийдэгднэ. Тийм болохоор хэлэлцэх эсэхийг нь шийдээд нэгдсэн нэг ажлын хэсэг байгуулахаар төлөвлөж ажиллаж байгаа гэдгийг танд хэлье. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

Арван дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танилцуулна.

Хэн дараагийнх нь явж байя. Санал хураалт дээр хэдхэн хууль байгаа. Их Хурлын дэгтэй холбоотой. Үүнийг хэлэлцээд нэг мөсөн санал хурааъя. Улсын Их

Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх зарчим нь засгийн бүх эрх ард түмнээс эх сурвалжтайг илэрхийлэх бөгөөд иргэд өөрсдийн дундаа сонгогдож эрх мэдлийг нь шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгчөөрөө уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцдог.

Дээрх агуулгаар ард түмнээс эрх мэдлийг шилжүүлэн авсан төлөөллийн байгууллага, төлөөлөгч нь ард түмний хүсэл зоригийн илэрхийллийг дамжуулагчийн хувьд түүнд тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлж, өөрийн болон төрийн үйл ажиллагааг ард түмний хяналтад байлгах бүхий л бололцоог хуулиар нээж өгөх үүргийг энэхүү зарчмын хүрээнд хүлээдэг.

Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1-д Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэг, түүний үр дүн, төлөөллийн бүрэн эрхийг хэрэгжүүлж буй гишүүний саналыг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж байх нь төрийн үүрэг мөн.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх харилцааг хэт ерөнхий хуульчилсан бөгөөд уг зохицуулалтууд нь хэлэлцүүлгээс гарсан шийдвэр, санал хураалтын үр дүнг иргэдэд мэдээлэх бус нэвтрүүлэх, албан хэрэг хөтлөх, тэмдэглэлийг хадгалах л шинжтэй байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134.1-д чуулганы хуралдааныг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх, түүнчлэн телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулна гэж заасан ганцхан зохицуулалтаар л мэдээлэх ажлыг зохицуулж байна.

Энэ зүйлийн хэрэгжилт нь чуулганы хуралдааныг телевизийн суваг, парламентын албан ёсны, цахим хуудсаар шууд дамжуулах хэлбэрээр хэрэгждэг.

Харин иргэдийн гол анхаардаг асуудал аливаа хууль тогтоолын төсөл батлагдсан эсэх, хууль санал хураалтын үр дүнд өөрийн сонгосон гишүүн болон бусад гишүүдийн өгсөн саналтай танилцах байдаг.

Телевизээр шууд дамжуулах хэлбэр нь иргэдийн дээрх мэдэх эрхийг хангаж чаддаггүй, шууд дамжуулалтын бүтэн өдөр үздэг хүн ховор, үзсэн санал хураалтын үр дүнг танилцуулж байгаа дэлгэц бүрэн бус гараад өнгөрдөг учир санал хураалтын үр дүнтэй танилцах боломжгүй байдаг.

Улсын Их Хурлын гишүүд ч санал хураалтын дэлгэцийн зургийг авах байдлаар хуульд заасан санал хураалтын дүнтэй хязгаарлалтгүйгээр танилцах эрхээ хэрэгжүүлж байна.

2024 онд байгуулагдсан парламентын үйл ажиллагааны хугацаанд чуулганы хуралдааны санал хураалттай холбоотой хэд хэдэн асуудал үүссэн бөгөөд одоо ч гэсэн шийдвэрлэгдээгүй байдалтай байна.

Учир нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журмыг хуульчилсан. Тус зүйлийн 135.3.3 санал хураалтын дүн санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг 135.3.4-д заасан тухайн хурлын ирцийг хурлын тэмдэглэлд тусгахаар заасан.

Харин тэмдэглэл хөтлөх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 624 дүгээр захирамжаар баталсан журмаар зохицуулж байгаа бөгөөд тэмдэглэл нь бэлэн болоход урт хугацаа шаарддаг.

Тодруулбал, тус журмын 2.1 шинжээч хуралдааны товч тэмдэглэлийг тухайн хуралдаан дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор бэлэн болгоно гэж, 4.2-т референт бэлэн болсон хуралдааны товч тэмдэглэлийг ажлын 3 өдрийн дотор хянана гэж, 4.3-д нэгжийн дарга энэ журмын 4.2-т заасны дагуу хянагдсан чуулганы нэгдсэн хуралдааны товч мэдээллийг ажлын 2 өдрийн дотор хянана гэж, 4.8-д шинжээч энэ журмын 4.7-д заасны дагуу хянагдсан нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар албажуулахаар Ерөнхий нарийн бичгийн даргын туслахад ажлын 2 өдрийн дотор хүлээлгэн өгнө гэж тус тус заасан бөгөөд санал хураалтын үр дүнг агуулсан чуулганы хуралдааны товч тэмдэглэл боловсруулахад ажлын 12 өдөрт зарцуулахаар байна.

Мөн тус журмын 3.3-д шинжээч яриаг буулгах системийн тусламжтай дууны бичлэгээс хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл буулгах ба ажлын 5 өдрийн дотор эцэслэн хянаж бэлэн болгоно гэж, 6.1-д шинжээч нэгдсэн хуралдааны товч мэдээлэл албадсан даруйд дэлгэрэнгүй тэмдэглэлийн хамт ажлын нэг өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна гэж тус тус заажээ.

Дээрх журамд заасан хугацаануудыг нэгтгэж үзэхэд чуулганы хуралдааны санал хураалтын дүн нийт ажлын 13 өдрийн дараа буюу санал хурааснаас хойш гурав дахь долоо хоногийн сүүлээр Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршихаар байна.

Дээр дурдсан чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх хуулийн зохицуулалт, арга хэрэгсэл нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3.1-д Улсын Их Хурлын чуулганы хуралдаан нээлттэй, ил тод байх зарчимд үндэслэнэ гэж заасанд нийцэхгүй байна.

Иймд чуулганы хуралдааны чухал ач холбогдолтой хэсэг буюу хууль тогтоолын төсөл хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүн гишүүн бүрийн саналыг тухайн өдрөө товч мэдээлэл хэлбэрээр Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулан санал хураалтын ил тод, нээлттэй байдлыг хангах шаардлагатай байна.

Иймд энэхүү хуулийн төслөөр Монгол Улсын Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд заасан чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх журмыг боловсронгуй болгож, чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хуралдаанаар хууль тогтоомжийн төслийн хэлэлцэх хэсэг болон эцсийн хэлэлцүүлгийг явуулсан хуралдааны санал хураалтын дүн, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст товч мэдээлэл хэлбэрээр тухайн өдрөө байршуулахаар тусгалаа.

Хуулийн төсөл дэмжигдсэнээр Монгол Улсын Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1-д Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж, 27 дугаар зүйлийн 7-д Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ гэж зааснаар Улсын Их Хурлыг нээлттэй, ил тод байдал сайжрах, сонгогчид ил санал хураалтаар шийдвэрлэсэн асуудлын үр дүн богино хугацаанд авах, өөрийн сонгосон гишүүний байр суурь, өгсөн саналыг мэдэх эрхийг баталгаажуулж, ард түмний засаглах эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэхээс гадна иргэдийн төрд итгэх итгэлд эергээр нөлөөлнө.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүнд баярлалаа.

Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын Байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн гэж, 23 дугаар зүйлийн 1-д Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж тус тус заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэг, түүний үр дүн, төлөөллийн бүрэн эрхийг хэрэгжүүлж буй гишүүдийн саналыг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж байх нь төрийн үүрэг мөн гэж үзсэн тул төсөлд хууль тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүн, гишүүн бүрийн саналыг тухайн өдөр нь товч мэдээлэл хэлбэрээр цахим хуудаст байршуулан санал хураалтын ил тод, нээлттэй байдлыг хангах төсөл боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Э.Болормаа гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримттай холбогдуулан гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Дэгийн тухай одоогийн хуульд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хурлын үйл ажиллагааг ил тод байлгах, мэдээллийг олон нийтэд нээлттэй хүртээмжтэй хүргэх чиглэлээр ер нь тодорхой зүйл, заалт огт байхгүй юм билээ л дээ.

Тухайлбал, дижитал хүртээмж, харилцааны хүртээмж, биет орчны мэдээллийн хүртээмж гээд олон улсын контентын дагуу яаж хүргэдэг вэ, мэдээллийг яаж ил тод байлгадаг вэ гэдэг дээр зохицуулалт ерөөсөө байхгүй байгаа.

Тэгэхээр өнөөдөр Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй 2 парламентын гишүүн байна л даа. Нэг нь тэргэнцэр хэрэглэдэг. Нэг нь миний хувьд нэг хөл нь протез хэрэглэдэг.

Хэрвээ цаашдаа сонсголын бэрхшээлтэй хүн ч юм уу, Тийм ээ. Харааны бэрхшээлтэй хүн харилцааны хувьд бэрхшээлтэй хүмүүс хэрвээ Их Хуралд сонгогдож ажиллах бол бид ер нь хэр бэлэн байгаа вэ гэдгийг нэг эргэж харах хэрэгтэй юм шиг байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр жишээлбэл дэгийн тухай хуульд ямар зүйл, заалт оруулах боломжтой байдаг юм оо? Энэ дээр нэг тодруулга асуулт байна.

Ер нь бусад орнуудын парламентын хурал, Байнгын хороодын хурал, үйл ажиллагааг хүртээмжтэй болгохтой холбоотой ер нь ямар сайн туршлага жишээ байдаг вэ? Би ажлын хэсгээс нэмэлт мэдээлэл авахыг хүсэж байна.

С.Бямбацогт: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн. Асуулт асуусан байна. Хариулъя. Д.Энхтүвшин гишүүн хариулъя. О.Саранчулуун гишүүний асуултад.

Д.Энхтүвшин: Их Хурлын чуулганы дэгийн тухай болон Их Хурлын тухай хуулиудын шинэчлэн өөрчлөлтүүд нэлээн хийж байгаа, ил тод болгож байгаа, гишүүд саналаа яаж өгч байгаа тоо, биечилж өгч байгаа, эсвэл үүнтэй холбоотой хариуцлагын асуудлууд явж байгаа.

Яг ил тод гэдэг зүйлд нь хэлбэр гэхээсээ илүү агуулгын хувьд ил тод байх ийм зайлшгүй шаардлага байгаад байгаа. Өөрөөр хэлбэл бидний хэвлэлт яриа өгдөг ч гэсэн заримдаа ярьдгаасаа эсрэг кноп дардаг байхгүй юу. Одоо жишээлбэл хариуцлагагүй ч юм уу, эсвэл.

Ингээд ам ажил нь зөрдөг иймэрхүү байдлууд чуулганы ирц, идэвх дээр агуулга руу нь орж байгаа хуулийн өөрчлөлт байгаа. О.Саранчулуун гишүүнтэй санал нэг байгаа.

Тэгэхээр миний хувьд зөвхөн гишүүдийн ард түмний төлөөлөх эрхээ яаж хэрэгжүүлж, тэр ард түмний хүсээд байгаа санал зоригийнх нь эсрэг ямаршуу санал өгөөд байгаа гэдгийг нь гурван долоо хоногийн дараа биш, ач холбогдол нь өнгөрснийх нь дараа биш, яг тухайн өдөр нь өгдөг бол яг тэр агуулгаар л хуулийн төслийг өргөн барьсан байгаа.

Тэгэхээр таны зүйл, заалтууд дээр тусад нь хуулийн төсөл өргөн бариад явбал илүү зохимжтой болов уу? Миний хувьд тухайлан судлаагүй болохоор энэ талаар хэлж мэдэхгүй байна. Баярлалаа.

С.Бямбацогт: О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа.

Тэгэхээр манай 126 гишүүд бүгдээрээ өөрсдийн гэсэн ядаж фэйсбүүкийн хуудастай. Бүгдээрээ геел, видео бичлэг мэдээллүүд хийдэг.

Тэгэхээр бид өөрсдөөсөө хамаараад хүртээмжээ сайжруулах нэг арга байгаа. Тэр нь юу вэ гэхээр Та бүхэн оруулж байгаа бичлэгүүдийнхээ доор чадвал дохионы орчуулга байх, эсвэл хадмалтай оруулаад өгөөч ээ гээд байгаа. Тэнд таны тойрогт ч байна уу, ер нь сонсохгүй байгаа, сайн харж мэдэхгүй байгаа олон сонгогчид байгаа.

Тийм учраас гишүүд өөрсдөөсөө эхлээд хүртээмжийнхээ соёлыг, хүртээмжийн хариуцлагаа нэмэгдүүлээсэй гэж би хүсэж байгаа юм. Энэ асуудлыг хэлэлцэж байгаа дээр нэмээд санал байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Үзэл баримтлалын хувьд Д.Энхтүвшин гишүүн ээ, дэмжиж байгаа.

Таны хуулийн төсөл боловсруулахад Австрали, Герман гээд олон улсын жишгийн талаар үндэслэл хэсэгтээ оруулсан байсан. Жишээлбэл, Японы парламентын танхимын үйл ажиллагаатай танилцаж байхад, яг тухайн хуралдаан болж байгаа цаг мөчид Японы парламентын үйл ажиллагаанд оролцож байгаа, эсвэл тухайн төрийн үйл хэрэг эрхлэн явуулж байгаа ордонд байгаа хүмүүсийн ирц гараад ирдэг.

Манайд ямар асуудал байна гэхээр жишээ татахад эрүү шүүлтийн улмаас хохирсон иргэдэд нөхөн төлбөр олгох тухай Их Хурлын тогтоол баталдаг өдөр 126-аас 100 хүн чуулганы ирцэд өглөө орсон байгаа юм. Тэгэнгүүт яг санал хураалт дээр энэ танхимд 60 хүн байсан. 60 хүн байнгуут 40 хүн танхимд байхгүй. Танхимд байгаа 60 хүн 60-уулаа дэмжиж товчлуураа дарсан байгаа юм. Тэгэнгүүт тэнд яаж байна гэхээр үр дүнд нь тухайн тогтоол 60 хувийн саналаар батлагдаж

байгаа юм. Уг нь бол энэ танхимд байгаа хүмүүсийн саналаар батлагдаж байгаа ч гэдэг ч юм уу.

Тэгэхээр ерөнхийдөө энэ асуудлуудыг нарийсгаж зохицуулалт хийхгүй бол болохгүй байгаа. Нөгөө талаасаа зөвхөн танхимд товчлуур дарж амаар саналаа илэрхийлж байгаа нь манай Их Хурлын гишүүд чинь дахин сонгогдохоо бодоод ч юм уу маш их популизм хийдэг.

Тэгээд ажиглаж байхад нэг асуудал дээр 40, 50 хүн асуулт асуух, түүний араас 10, 20 хүн үг хэлэх тохиолдлууд байдаг. Ажиглаж байхад яг нэг асуусан асуултыг бусад гишүүд нь сонсоогүй байдлаар давтан давтан асуугаад. Тэгээд тэнд нь хариулж байгаа хүмүүс нь давтан давтан хариулаад явдаг.

Тэгэхээр энд шийдвэр гаргалтын үр өгөөж, шийдвэр гаргалт гаргалтыг чанартай болгох гэхээс илүүтэйгээр улс төрчдийн хувьд хууль тогтоогчид маань ямар нэгэн байдлаар үг хэлэх гэсэн агуулга нь давамгайлаад явдаг.

Тийм учраас санал өгөлтийг түрүүний таны энэ дээр байгаа шиг бичгээр ч юм уу, хуваагдмал санал ч гэдэг юм уу, яг энэ зүйлээр нарийсгах зайлшгүй шаардлага байгаа харагдаж байгаа юм. Энэ үүднээс парламентын үйл ажиллагааг үр өгөөжтэй. Нэмээд Байнгын хорооны үйл ажиллагааг үр өгөөжтэй зохицуулалтыг нарийсгахад дэгийн тухай хууль дэмжүүштэй гэж үзэж байгаа юм. Харин зүгээр хэлэлцэх асуудал нь дэмжигдээд явсны дараагаар дотор нь зарчмын шинж чанартай зүйлсүүд байна. Ялангуяа олон улсын парламентын засаглал хөгжсөн орнуудаас авах, Монгол орны онцлогт тохирсон байдлаар бас авах зүйлс байгаа.

Жшээлбэл. Нэг жишээ хэлээд дуусгая. Юу гэхээр яг энэ танхимд байхгүй хүмүүсийг л ажил хийхгүй байна гээд байдаг. Тэр ч үүднээс Ерөнхийлөгчийн Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах хууль орж ирэхдээ 30 хувь гэдэг санал өгөлтийн болон ирцийн квот ороод ирдэг.

Гэтэл зайлшгүй нөхцөл байдал дээр тойрог дээр ажиллах, тэр нь чөлөө авч амжаагүй болзошгүй ажиллах ч гэдэг юм уу зүйлүүд гардаг.

Тэгэхээр үүнийг яг танхимаар хэмжих гэхээсээ илүүтэйгээр яг ухаалгаар яаж хэмжиж болох вэ гэсэн. Жишээлбэл, онц байдал зарлах ч гэдэг юм уу, цагийн байдал үүссэн тохиолдолд яах вэ гэдэг ч гэдэг ч юм уу гэх мэт зүйлсийг ковидын үед бид зайнаас хуралдаж байсантай адилхан шийдвэр гаргалтад тийм оролцоо байж болох уу, үгүй юу гэдэг ч гэдэг юм уу гэдэг зүйлүүдийг нарийсгах хэрэгтэй юм байна гэж үзэж байгаа.

Тэгэхээр танаас асуух гэж байгаа асуулт нь яг энэ дээр бусад улсуудын парламентын жишиг хөгжсөн орнуудад ямар ямар зохицуулалт байгаа бөгөөд

Монгол Улсад зайлшгүйгээр энэ нь дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах үндэслэл болсныг тайлбарлаж өгөхгүй юү?

С.Бямбацогт: Үг хэллээ.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна.
Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя. Алга байна.
Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна.
Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Алга байна байна.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд би дэмжиж байгаа. Парламент олон нийтэд нээлттэй болохоос гадна гишүүддээ нээлттэй болгох шаардлага байна.

Яагаад гэвэл Байнгын хороогоор тухайн асуудлыг хэлэлцээд, зарчмын зөрүүтэй гарсан саналыг бид яг санал хураах тэр мөчид авдаг нь ямар ч тийм танилцах бололцоогүй байдаг. Ялангуяа төсөвтэй холбоотой халуун өдрүүд дээр энэ маш сайн мэдрэгдсэн шүү дээ.

Тэгээд сүүлдээ бүр нөгөөдүүл нь танилцаж амжихаа байгаад сүүлдээ улаан, ногоон лаазан дээрээ л тулсан шүү дээ.

Гэтэл бид татвар төлөгчдийн мөнгийг зарцуулж байж ийм ил тод биш, гишүүд нь тэрийгээ мэдэхгүй, ямар учир начиртай, ямар ач холбогдолтой санал өгөөд ухамсартайгаар, мэдлэгтэйгээр тэр асуудалд хандах боломж бололцоо завсар дундын хэлэлцүүлэг дээр огт байхгүй байна гэдгийг хэлье.

Тэгээд үүнийг хуулийн төслөөр яаж зохицуулж байгаа вэ гэж асууя.
Д.Энхтүвшин гишүүнээс асууя.

С.Бямбацогт: Хариулах уу? Д.Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн төсөлд хоёр асуудлыг хуралдааны дэмжсэн, дэмжээгүй санал хураалтын үр дүнг товчоор мэдээлэхээр заасан байгаа.

Нэг нь, Байнгын хороо болон нэгдсэн чуулган дээр тухайн асуудлыг хэлэлцэх эсэх болон эцсийн хэлэлцүүлэг дээр явцын дунд олон санал хураалтууд гардаг.

Тэр болгоныг мэдээлэх ажил олон санал хураалтууд явдаг учраас тэр болгоныг мэдээлэх ач холбогдол бага гэж үзсэн учраас Байнгын хороо нэгдсэн хуралдаан дээрх хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулж хэлэлцэх хэсэг болон эцсийн хэлэлцүүлэг дээрх саналуудыг ил тод болгох заалт оруулсан байгаа.

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Алга байна.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Мэдээж ил тод байдал маш чухал. Гишүүдийн өөрсдийнх нь сахилга хариуцлага, ямар чиг баримжаатай, ямар бодлогын чиглэлд байр суурьтай байна гэдгийг түүнийг сонгосон иргэд нь үнэлэлт, дүгнэлт өгөхөд маш чухал байгаа.

Энэ дээр мэдээж нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгох асуудал дээр дэмжиж байна. Зүгээр нэг юм энд жоохон орхигдсон юм шиг санагдаад байгаа юм.

Улсын Их Хурал дээр ажиллаад, Тамгын газар ч гэсэн байж байхад маш их зарчмын зөрүүтэй санал буюу концепцын хувьд өөрчлөх саналууд ажлын хэсэг дээр гардаг.

Байнгын хороо биш, чуулган биш. Байнгын хороо чуулган нээлттэй хэлэлцүүлэгтэй. Гишүүд мэдээж байр суурь, санал хураалт дээрээ орж байгаа. Тэгтэл ажлын хэсэг дээр хэн нь хаанаас нь ямар санал гаргаад хэд нь дэмжээд, хэд нь дэмжихгүй болоод тийм санал орсон гэдэг нь бараг мэргэжлийн байгууллагууд, stakeholder-ууд гэдэг юм уу, Тийм ээ. Иргэний нийгмийн байгууллагууд, эсвэл үүнтэй холбоотой асуудлыг харж байгаа хүмүүст маш тодорхойгүй үлддэг.

Тэгээд нэг ийм “А” гэдэг хууль оруулсан чинь дундаас нь “Б” гэдэг хууль ажлын хэсгээс гараад Байнгын хорооноос гарлаа. Энэ процесс ерөөсөө ил тод биш байгаад байна. Ажлын хэсэг дээрээ юу болов гэдэг их чухал байдаг.

Тэгэхээр үүнийг Д.Энхтүвшин гишүүн техникийн хувьд үүнийг бид хэлэлцээд явах юм бол ажлын хэсэг дээр гарч байгаа санал хэн дэмжсэн, дэмжээгүй гэдгийг бас тэмдэглэлээр гаргах, нээлттэй, ил тод болгох, эсвэл тэр тоон мэдээллүүдийг нь гаргах байдаг юм уу. Энэ асуудал бас орж болох уу? Үзэл баримтлалын хувьд таны дэвшүүлж байгаа хуулийн төсөлтэй үзэл баримтлалын хувьд зөрчилдөх үү гэдгийг тодруулж асууя.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Энэ бас их чухал. Яг бодит байдал дээр ёстой нөгөө танигдахгүй болоод өөрчлөгдөх магадлалууд байдаг. Ажлын хэсэг дээр.

Цаана нь тэр дотор нь юу ажиллаад байгаа нь мэдэгдэхгүй битүү байдаг. Үүнтэй холбогдуулж үзэл баримтлалын хүрээнд чуулганы санал хураалттай холбоотой үр дүнгүүдийг ил тод болгох үзэл баримтлал байгаа учраас энэ үзэл

баримтлалын хүрээнд хөндсөн заалтууд дээр саяын хэлсэн зарим ажлын хэсэгтэй холбоотой зүйл заалтуудыг хэлэлцүүлгийн явцад ярилцаад тодорхой хэмжээгээр санал тусгах бололцоотой гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе.

Хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна. Нэгдүгээрт.

Тэгээд хэд хэдэн зүйлүүд дээр тодруулга авъя. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бусад хуулиудтай уялдсан байдлыг Та бүхэн маань судалсан уу? Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хувь хүний мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг хуулиудтай хэр нийцэж байгаа вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хариуцлагын механизмыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан бэ? Таны дэвшүүлж байгаа санал эерэг санал байгаа юм.

Гэтэл Улсын Их Хурлын чуулган дээр мөн Байнгын хороодын хурал дээр, тэгээд зарчмын зөрүүтэй санал дэвшүүлэх, нэг, хоёр санал дутлаа. Энэ болгоныг Та бүхэн статистик байдлаар яаж мэдээлэх юм бэ?

Маш олон удаагийн тохиолдлоор Улсын Их Хурлын чуулганы санал хураалтаар, өнөөдрийн жишээгээр төсвийн хүрээний мэдэгдэл 64-өөр батлагдах байтал 63 хүрээгүй. Гэгээр дутсан. Гэх мэтийн.

Тэгээд шууд илэрхий байдлаар олон нийтийн өмнө ил тодоор тэр гишүүнээ, тэр сайдаа зарчмын зөрүүтэй санал гаргачих гээд энэ кейсүүдээ Та бүхэн маань яаж олон нийтэд танилцуулах юм? Хэвлэл, мэдээллийн оролцоо, тэдгээрийн эрэмбэлэх асуудлуудыг яаж албажуулж байгаа юм? Арилжааны телевизүүд. Одоо дээрээс нь сайтууд гэхэд маш олон байгаа. Эдгээрийгээ бүгдэд нь нийтэд нэг эх үүсвэрээс өгөх юм уу? Эсвэл хэвлэл мэдээллийнхэн ямар зарчим горимоор авах юм бэ гэдгийг асуумаар байна.

Тэгээд сүүлд нь хэрэгжилтийнхээ үе шатуудыг тодорхойлсон уу? Одоо хаврын чуулган болох гэж байна. Яг хэзээнээс хэрэгжиж эхлэх юм бэ? Таны төсөөлж байгаа тэр үе шатын төлөвлөгөөг сонсоод тодруулъя.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Ер нь ил тод байдал гэдэг дээр гишүүд, иргэдээс гадна хэвлэл мэдээллийнхэн гишүүдээс байнга байр суурь асуудаг. Та энэ асуудал дээр ямар байр суурь илэрхийлсэн бэ? Дэмжсэн үү, дэмжээгүй юу гэдэг.

Тэгэхээр тухайн өдрөө Их Хурлын албан ёсны мэдээллийн сувгуудаар энэ мэдээллийг тавих учраас бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ч гэсэн энэ дээр үндэслээд тодорхой хэмжээний байр суурийг нийцэл талаас нь, Улсын Их Хурлын гишүүдийн зарчим талаас нь уялдуулж асуулт асуух бололцоонууд нээгдэнэ.

Мэдээлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулахаар заалт байгаа. Улсын Их Хурлын тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хэсэг дээр нь энэ ажлыг одоогийн хуулиараа ч гэсэн хэвлэл мэдээлэл дээр мэдээлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцаж байгаа.

Тэгээд үүнтэй холбоотой мэдээлээгүй асуудал үүсвэл Тамгын газар холбогдох хариуцлагаа хүлээхээр зүйл байгаа.

Бусад хуулиудын нийцлүүдийг үзсэн. Энд зөрчилдөөн байхгүй. Хуулийн хэрэгжилтийн хувьд батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөр байдлаар тусгасан байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Тодруулъя. Д.Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Тэгэхээр ингээд байгаа байхгүй юу. Хууль зүйн хувьд уг асуудал дээр Тамгын газар хариуцлага хүлээнэ гээд тэгж байна шүү дээ.

Тэгэхээр тодорхой хувьд. Заавал хөндлөнгийн хараат бус хяналт ч гэдэг юм уу, ийм зүйл байхгүйгээр өөрийн өөрсдийнхөө алдааг ил тод болгоно гэж байхгүй. Ялангуяа Их Хурлын Тамгын газар, Байнгын хороод.

Тэгээд я түрүүний жишээ байгаа шүү дээ.

Батаа, Дулмаа, Дондог оо, зарчмын зөрүүтэй санал гаргаадаа даа гээд л нэгэн рүүгээ шууд. Тэрийг чинь сэтгүүлчид болгон харж байгаа шүү дээ.

Тэгээд энэ бүхэн чинь яг яваандаа таны санаачилсан зөв зүйл чинь жижиг элементээс болоод хэрэгжихгүй болно.

Тэгэхээр хариуцлагын системийг уялдуулаад. Би болдог хөндлөнгийн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл... /минут дуусав/

С.Бямбацогт: Хэлэлцүүлгийн явцад анхаараад оруулах юм байвал оруулъя. Тийм ээ. Үг хэллээ. Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Оройн мэнд хүргэе.

Ер нь дэмжиж байгаа. Тэгээд хоёрхон санал байна. Тухайн хэлэлцсэн асуудлын товч мэдээллийг тухайн өдөрт нь байршуулна гээд байгаа.

- Тухайн өдөр нь хэлэлцээд дамжвал яах вэ?
- Тухайн өдөр нь шөнө болвол яах вэ?

Тийм учраас үүнийг зүгээр 24 цагийн дотор байршуулна гэдэг байдлаар өөрчлөөд явуулах боломжтой юу?

Хоёрдугаарт, Их Хурлын чуулган нийтийн хяналтын төв талбар гэдэг яалт ч үгүй зөв. Харин Байнгын хороо уг нь мэргэжлийн ажлын талбар байх ёстой.

Ер нь ардчилсан парламентын засаглал хөгжсөн улсуудын жишиг яг л энэ утга, концепцоор явдаг. Өөрөөр хэлбэл Байнгын хорооны үйл ажиллагааг хэт улс төржилт, популизмд автах нөхцөлийг бүрдүүлэх вий дээ гэсэн болгоомжлол байна.

Тэгээд ер нь Их Хурлын чуулган ч гэсэн өөрөө бүрэн нээлттэй байх нь нөгөө гаднаас шүүмжлээд байгаа олон нийтийн, сошиалын, нийгмийн массын шуугиж байгаа тэр нөлөөлөлд автаад энэ шийдвэр гаргалтууд тэр тал руугаа ханд вий дээ гэсэн болгоомжлол байгаа.

Үүнийг Та яг юу гэж үзэж байна? Энэ хэт нээлттэй байх, ялангуяа мэргэжлийн Байнгын хороод нь олон нийтэд хуралдааныхаа чуулган болгоныг нээлттэй байлгах нь зөв үү?

Гурав дахь асуудал бол яаж хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг үр ашигтай үр дүнтэй хэлэлцдэг болох вэ гэдэг асуудал их чухал. Өнөөдөр энд үг хэлж байгаа болон асуудалд оролцож байгаа хүмүүсийн бараг 50-иас дээш хувь нь зөвхөн телевизээр шууд явдаг учраас л үгээ хэлж байгаа. Хэлэх ёстой, харагдах ёстой ганц талбар нь ч тэр байгаа байх.

Эндээс болоод Их Хурлын чуулган өөрөө хэт их сунжирдаг. Ач холбогдолгүй олон зүйлүүд яригддаг. Олон нийт рүү хандсан үг хэлээр ярианууд дамжиж явдаг болоод хэлэлцэж байгаа асуудлын гол агуулга алдагдаад, сунжраад, ач холбогдол нь багасдаг. Энэ асуудал дээр ер нь олон улсын жишиг ямар байдаг юм? Та ямар судалгаа хийв? Таны хууль батлагдаад явсан тохиолдолд энэ эрсдэлүүд яаж хаагдах вэ гэдэг асуултыг асууя.

С.Бямбацогт: Д.Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Б.Түвшин гишүүний асуултад хариулъя.

Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүдэд эрх мэдэл нь ард түмнээс эх сурвалжтай байгаа. Өөрөөр хэлбэл ард түмнийг төлөөлж байгаа. Нийт иргэн, ард түмний эрх ашгийг илэрхийлэх үүрэгтэй байгаа.

Тэгэхээр сонгосон Улсын Их Хурлын гишүүн ямар байдлаар эцсийн үр дүн буюу санал хураалтыг тухайн хуулийг дэмжсэн, дэмжээгүй энэ үр дүнгээ мэдэх нь ард түмний эрх мэдлийнх нь эх сурвалж болсон ард түмнийгээ төлөөлөх зарчимд нийцнэ гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ утгаараа оролцож байгаа, чуулганд хэлэлцэж байгаа асуудлаас илүү яг товч байдлаар эцсийн үр дүнг нь дэмжсэн, дэмжээгүй үр дүнгүүдийг ард түмэн мэдэхэд илүү хялбар болгож өгч байгаа.

Энэ нь нэг талаасаа Улсын Их Хурлын гишүүдийн зарчим барих, зарим асуудал дээр ард түмнийх нь, сонгогчдынх нь дэмжиж байсан, санал болгож байсан зүйлийнх нь эсрэг ч юм уу, эсвэл өөрийнхөө ярьдаг зүйлийнхээ эсрэг идэвхгүй үйлдлээрээ чуулганы хуралдаанд оролцдоггүй байдлаар ч гэдэг юм уу, иймэрхүү эсрэг үр дүнгүүд гаргадаг.

Тэгэхээр энэ нь илүү шууд тухайн өдрөө гарахаар илүү хариуцлагатай болох, энэ дээрээ ач холбогдол өгөх иймэрхүү байдлууд нэмэгдэх болов уу гэж бодож байгаа юм.

Одоогийн Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар Их Хурлаар шууд нээлттэй явж байгаа. Байнгын хорооны мэдээллүүд ч гэсэн нээлттэй явж байгаа учраас энэ нь улс төржүүлэх гэхээсээ илүү ард түмний мэдэх эрх гэдэг дээр илүү ач холбогдол өгч энэ нь зөв байх гэсэн бодолтой байна.

Таны хэлсэн тухайн өдөр гэдгийг хэлэлцүүлгийн явцад өдөр сунгавал гэдэг асуудал орвол 24 цагийн дотор ч гэдэг юм уу иймэрхүү байдлаар найруулж болох боломжтой гэж бодож байна.

Ер нь Улсын Их Хурлын чуулганы дэг болон Улсын Их Хурлын тухай хэд хэдэн хуулийн төслүүд явж байгаа учраас хэрвээ хэлэлцэх эсэх нь дэмжигдвэл нийлүүлээд хуулийн төслүүдийг хэлэлцүүлээд сайжруулаад явах бололцоонууд байгаа гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Б.Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Нэгэнт ийм хууль санаачилж байгаа юм чинь би ч угаасаа хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа учраас дараагийн нэг санал байгаа.

Чуулганыг болон Байнгын хороодын хурлыг илүү үр ашигтай болгох талын санаачилгуудыг энэ дээр гаргах ёстой. Илүү хэлэлцэж байгаа асуудалдаа.

Байнгын хорооны хурлыг тэр олон нийт рүү хандах гэхээсээ илүү мэргэжлийн түвшний асуудлуудыг ярилцдаг, шийдвэр гаргахад илүү түлхүү ханддаг болгохгүй бол бүх зүйл олон нийт рүү хандсан байдлаар хуралдаанууд яваад байгаа шүү гэдгийг танд хэлье.

Тэгээд үүнийг цаашдаа анхаарч ажиллана биз дээ.

С.Бямбацогт: Хэлбэрт биш агуулгад анхаарах ёстой. Банзрагчийн Түвшин гишүүн хэлж байна. Их чухал шүү. Үүнийг хэдүүлээ хэлэлцэхийг нь шийдсэний дараа анхааръя.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя.

Р.Эрдэнэбүрэн: Гишүүд санал хураалтдаа яараад байгаа учраас нэрээ татлаа.

С.Бямбацогт: Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүд байна уу? Үзэл баримтлалтай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй. Алга байна.

Санал хураалтыг нэгтгээд явуулна. Хойшлууллаа.

Арван тав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явна.

Хууль санаачлагч илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна.

Да.Цогтбаатар: Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал нь улсын төсөв, түүний гүйцэтгэлийг батлах, хуулийн биелэлтэд хяналт тавих онцгой бүрэн эрхтэй байхаар заасан.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэх журмыг зохицуулж байгаа.

Гэвч өнөөдрийн мөрдөж байгаа зохицуулалтаар төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үеийн асуулт хариултын хугацаа ердийн хуулийн төслийн хэлэлцүүлгийн нийтлэг хугацаагаар явагдаж байгаа нь төсвийн зарцуулалт, үр ашиг, аудитын дүгнэлт, сахилга хариуцлагын асуудлыг гүнзгий хэлэлцэх дутагдалтай байгаа юм.

Иймээс энэхүү хуулийн төслөөр төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед гишүүний асуулт асуух болон хариулт авах хугацааг нэмэгдүүлж, тусгайлан зохицуулахаар тусгасан.

Тухайлбал, Байнгын хороо болон нам, эвслийн бүлгийн түвшинд гишүүний асуулт асуух хугацааг 10 минут, асуултад хариулах хугацааг 6 минут болгож нэмэлт тодруулга хийх боломжууд өргөжүүлж байна.

Мөн нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн үед асуулт хариултын хугацааг нэмэгдүүлж, төсвийн гүйцэтгэлийг илүү дэлгэрэнгүй бодитой хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлд илүү үр нөлөөтэй хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч надаас тодорхой хариуцлагатай тайлбар авах, аудитын дүгнэлтийн хэрэгжилтэд бодитой анхаарал хандуулах боломж нээгдэнэ гэж үзэж байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүдээс энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

С.Бямбацогт: Баярлалаа.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан ердийн хуулийн төслийн хэлэлцүүлэгт хэрэглэгддэг нийтлэг

хугацааны зохицуулалт нь ердийн хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэгт тохиромжтой боловч олон их наяд төгрөгийн төсвийн зарцуулалт, төсвийн сахилга, үр ашиг, аудитын дүгнэлт, санхүүгийн тайлангийн асуудлыг тал бүрээс нь хэлэлцэхэд хангалтгүй байна гэж үзжээ.

Иймд нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэг итгэсэн тайланг хэлэлцэхэд ердийн хуулийн төслийн хэлэлцүүлгийн нийтлэг хугацаагаар явуулж байгаа гишүүн үндсэн асуултыг 10 минутаас илүүгүй хугацаанд, асуух, нэмэлт асуултыг 3 минутаас илүүгүй хугацаанд асуух, хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар дахин тодруулга хийх, гишүүний асуултад 6 минутаас илүүгүй хугацаанд хариулах, нэмэлт тайлбарыг Байнгын хороо, бүлгийн хуралдаанд 2 хүртэл удаа тус бүр 4 минутаас илүүгүй байх, чуулганы нэгдсэн хуралдааны үеэр 2 минутаас илүүгүй хугацаатай байхаар төсөл боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурал төсвийн зарлагад хяналт тавих асуудлыг хэлэлцэх үед хуульд заасан цагийн хязгаарлалтын зохицуулалттай холбоотойгоор хэлэлцүүлэг өрнүүлж амжихгүй байгаа учир хэлэлцүүлэг явуулахад хангалттай хугацаатай болгох нь зүйтэй талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар төсвийн асуудлыг хэлэлцэх үед нэгдсэн чуулган болон Байнгын хорооны хуралдаан дээр асуулт 3 минут, тодруулга 1 минут, нийт 4 минутын хугацаанд томсгосон тойргоос сонгогдсон гишүүд сонгогдсон аймгуудын талаар асуулт асуух хугацаа хүрэлцдэггүй.

Улсын төсвийн 34 их наяд төгрөгийн зарцуулалт, түүнд тавигдсан хяналт, хийхээр төлөвлөсөн ажил биелсэн эсэхийг илүү тодорхой хэлэлцэхийн тулд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргын хувиар уг хуулийн төслийг санаачилсан талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Э.Болормаа гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөл үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн нэрээ татлаа.
Гомбын Ганбаатар гишүүн нэрээ татлаа.
Батын Батбаатар гишүүн. Алга байна.
Равжихын Эрдэнэбүрэн гишүүн. Алга байна.
Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн нэрээ татлаа.
Энхбатын Болормаа гишүүн асуултаа асууя.
Байнгын хороо санал, дүгнэлт танилцуулсан учраас нэрээ татлаа.

Одоо үг хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд алга байна.

Асуулт асууж үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтыг нэгтгэж явуулна. Дараагийн асуудалдаа оръё.

Арван зургаа.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн
2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт гаргах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танилцуулна.

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын бусад эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Мөн зүйлийн 7 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль бусад хуульд заасан эсвэл хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн нууц санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурал хуралдааны дэгээ өөрөө тогтооно гэж заасан нь Монгол Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хэлэлцэхдээ хуралдааны дэгийг өөрөө тогтоох эрхийг олгож өгсөн байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиар Монгол Улсын Их Хурал хуралдааны дэгийг өөрөө тогтоох эрхийг олгосонтой холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр нийт 16 бүлэг, 137 зүйлтэйгээр баталж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байдаг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг, дэгээр тусгайлан зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгийг Улсын Их Хурал өөрөө тогтооно.

Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсвэл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэж зааж өгсөн байдаг.

Гэтэл хуулиар олгосон эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурал дэгээ өөрөө тогтоож, чуулганы хуралдааныг зохион байгуулахад дэгийн томьёололтой холбоотойгоор зарчимд үл нийцэх үр дүн гарч эхэлсэн.

Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар санал хураалт явуулах ерөнхий журмыг нарийвчлан зохицуулаагүй улмаас үр дүн муутай томьёоллоор санал хураалтыг явуулж байна. Монгол Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгосон бүрэн эрх хийгээд бусад холбогдох хуулийн зарчимтай нийцэхгүй байгаа гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын чуулганы хуралдаан хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх, асуудлыг хэлэлцэхэд чөлөөтэй, эрх тэгш оролцоог хангах, цөөнхийн эрхийг хүндэтгэх, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой тодорхой байх, олонхын саналаар шийдвэр гаргах зарчимд үндэслэнэ гэж заасан.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны санал хураах журмыг холбогдох хуулиар нарийвчлан тодорхойлж өгөөгүйгээс үүдэн зарим тохиолдолд зарчимд харшилж, ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг чуулганд оролцож буй гишүүдийн хувьд төдийгүй ард иргэдэд үүсгээд байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт олонхын саналаар шийдвэр гаргах зарчимд үндэслэнэ гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын үндсэн зорилт нь ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оршино гэж тус тус заасанчлан улсын хэмжээний асуудлыг бүрэн эрхийнхээ хүрээнд хэлэлцэх шийдвэр гаргаж буй ард түмнээс сонгогдсон төлөөллийн хувьд асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ дэгээ ойлгомж муутай тогтоосны улмаас асуудал ул суурьтай шийдвэр гаргах боломжгүй нөхцөлд хүргэх эрсдэлтэй юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэгт тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантай мэдэгдэлгүй хурлыг орхиж гарсан, эсвэл бүртгэлээс гарсан түүнийг хуралдааны ирцэд орвол тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэж зааснаас үзвэл Байнгын хороогоор хэлэлцэж дэмжсэн, эсвэл дэмжээгүй санал авсан асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хэлэлцүүлэхдээ дэмжсэн саналыг дэмжих, эсвэл дэмжихгүй эсэх, мөн дэмжээгүй саналыг дэмжих эсвэл дэмжихгүй эсэх гэх байдлаар санал хурааж байна.

Тус дэгийг хуулиараа нарийвчлан тогтоох шаардлагатай байгааг харуулж байна гэж үзэж байна.

Эс тэгвээс хуралдаанд оролцоогүй, эсвэл бусад шалтгаанаар хуралдааныг орхиж гарсан гишүүд саналаа өгөөгүйн улмаас эсрэг саналд тооцогдох байдлаар санал хураах нь олонхын саналаар шийдвэр гаргах зарчимтай нийцэхгүй байна гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 6 зүйлтэй байхаар боловсрууллаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд, Засгийн газрын гишүүнээр томилох тухай асуудал болон Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, түүнтэй холбогдуулан шинээр томилох асуудлын талаарх Ерөнхий сайдын танилцуулгыг хүлээн авснаас хойш уг асуудлыг ажлын 5 хоногийн дотор чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан байхаар товыг тогтоох.

Мөн хуулийн холбогдох зохицуулалт болох 26.1 дэх хэсэг, 103.1 дэх хэсэгт Улсын Их Хурал уг танилцуулгыг ажлын 5 хоногийн дотор сонсохоор тусгалаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор Байнгын хороон дээр дэмжигдээгүй саналыг тухайн санал гаргасан этгээд нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж санал хураалгах хүсэлт гаргасан чуулганаар санал хураалгахаар өөрчлөхөөр тусгалаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд санал хураалт явуулах ерөнхий журамд өөрчлөлт оруулж чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоолын төсөлд тодорхой асуудлыг хэлэлцэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг нь дэмжих эсэхээс санал хураах агуулгатай зохицуулалт нэмэхээр тусгалаа.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26.1 дэх хэсэг, 103.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнээр томилох тухай асуудал болон Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, түүнтэй холбогдон шинээр томилох асуудлын талаарх Ерөнхий сайдын танилцуулгыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор сонсохоор тусгалаа.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хугацаанаас зөрүүтэй тусгасныг Үндсэн хуульд нийцүүлж өөрчлөхөөр тусгалаа.

Түүнчлэн хуулийн төслийн 4 болон 5 дугаар зүйлд чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоолын төсөлд тодорхой асуудал хэлэлцэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцон нийт гишүүд дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг нь дэмжих эсэхээр санал хураахаар тусгахтайгаа холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Байнгын хорооны саналаар санал хураахаар заасан зохицуулалтуудад тодорхой өөрчлөлт оруулахаар бэлтгэлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхэд холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл Хууль зүйн Байнгын хорооны санал, дүгнэлтээр эхэлж санал хураах, Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэхэд холбогдох Байнгын хороо болон Хууль зүйн Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураах зохицуулалтыг хүчингүй болгохоор тусгасан болно.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчим болон Улсын Их Хурлын чуулганы хуралдаан хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх, асуудлыг хэлэлцэхэд чөлөөтэй, эрх тэгш оролцоог хангах, цөөнхийн эрхийг хүндэтгэх, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой, тодорхой байх, олонхын саналаар шийдвэр гаргах зарчимд үндэслэнэ гэсэн үндсэн зарчимтай нийцэж, Монгол Улсын Их Хурлын гишүүдийн ирцтэй холбоотойгоор олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх зарчим хийгээд төрийн хууль дээдлэх, засаглах эрхийг хангахад чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Та бүхнийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсье.

С.Бямбацогт: М.Бадамсүрэн гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хороо санал, дүгнэлтийг Энхбатын Болормаа гишүүн танилцуулна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч чуулганы нэгдсэн хуралдаанаар асуудлыг шийдвэрлэхдээ Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг нь дэмжих, эсэхээр санал хураах, Ерөнхий сайд Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүнийг танилцуулах хугацааг нарийвчлан заах, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан зарим хугацааг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэх зохицуулалтыг тусгасан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим систем байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар ажлын хэсэг, Байнгын хорооноос гаргасан саналыг анх гаргасан санал гэж үзэх эсэх, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх хугацааг хуулиар тусгайлан заасан хугацаанд багтаан шийдвэрлэж чадахгүйтэй холбоотой зохицуулалт өсөлд туссан эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр парламент нь хэлэлцүүлгийн дэгээ өөрөө тогтоох эрхтэй учир Байнгын хороо санал хураадаггүй зарим орны жишгийг төсөлд тусгах боломжтой эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин чуулганы ирцэд бүртгүүлээд санал хураалтад орохгүй байгаа гишүүдийн асуудлыг санал хураалтын хэлбэрийг өөрчлөх замаар шийдэх нь оновчгүй бөгөөд санал хураалтад биечлэн оролцуулах механизмаар шийдэх нь зүйтэй талаар болон мэргэжлийн Байнгын хороодод түшиглэн үйл ажиллагаа явуулдаг өнөөдрийн загварыг үгүйсгэсэн зохицуулалт туссан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал уг хуулийн төсөл нь Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн төслийн санал хураалтын өмнө ирц үүсгэх, эс үйлдэхүйгээр биш биеэрээ санал өгөх зохицуулалтаар агуулгын хувьд шийдэгдсэн талаар,

Ерөнхий сайдыг огцруулах асуудал Үндсэн хуульд тусгайлсан зохицуулалттай байхад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд оруулаагүйгээс Үндсэн хуулийн зөрчил үүссэн, Улсын Их Хурал бол мэргэжлийн Байнгын хороодод ажил нь төвлөрдөг парламент учир энэ зарчмаа барих нь зүйтэй.

Хууль санаачлагч өөрөө зөвшөөрвөл хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай нэгтгэн хэлэлцээд явах боломжтой талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Э.Болормаа гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуулт асуух гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асууя.

Батын Батбаатар гишүүн. Алга байна.
Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Алга байна.
Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн, Алга байна.
Банзрагчийн Түвшин гишүүн нэрээ татлаа.
Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн. Алга байна.

Асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалтууд явна. Тийм ээ.

Санал хураалтад бэлтгэх хооронд би гишүүдийг танхимдаа цуглахыг хүсэж байна. Санал хураалтууд явна. Гишүүд өнөөдөр хууль эцэслэн батлах санал хураалтаар эхэлнэ. Төсвийн хүрээний мэдэгдэл. Тийм үү. Тийм болохоор 64-өөс дээш ирцтэй эцэслэн батлах ёстой.

Гишүүдийг чуулганы хуралдааны танхимдаа хүрэлцэн ирэхийг урья.

Энэ хоорондох мэдээлэл өгье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороо, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хороог эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар нарын 16 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан.

Гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Гишүүд танхимдаа цуглана уу.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг,
санал хураалтаар үргэлжлэв./

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн дөрөв дэх хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар материалыг гишүүд тараасан байгаа. Гишүүд санал хураалтаа бэлтгэе. /алх цохив/

104 гишүүн өнөөдрийн чуулганы хуралдааны ирцэд орсон. ирц, бүртгэлийн санал хураалт явуулна. 104 гишүүнээс ирц бүртгэлийн санал хураалт явуулаад. Би ороогүй явж байна шүү дээ.

Дэмжсэн гэж гарч байгаа гишүүд бол чуулганы хуралдаандаа сууж байгаа ажлаа хийж байгаа гишүүд. Дэмжээгүй гэж гарч байгаа гишүүд ирцдээ орчхоод санал хураалт, ажлаа хийхгүй явсан байна гэж ойлгож болно шүү. Дэгийн тухай хуульд ингэж орж байгаа юм.

Ирц бүртгэлийн санал хураалт. 84 гишүүн ирц бүртгэлд орсон байсан. 79 гэж гарч байна. Гишүүд анхааралтай хандана уу.

Танхимд 86 гишүүн байна уу? 89 гишүүн байна. Ирц аягүй сайн байна.

Санал хураалт явуулах уу? Санал хураалт.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 77 гишүүн буюу 74.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төслийг эцэслэн баталлаа.

Улсын Их Хурал Нийт гишүүддээ талархлаа илэрхийлье.

Монгол Улсын ирэх 3 жилийн төсвийн хүрээг Улсын Их Хурал эцэслэн баталлаа.

Тоон үзүүлэлтийг харах юм эдийн засаг ирэх жилүүдэд дунджаар 6 хувь өсөхөөр байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүнүүд дэлхийн зах зээл дээр өндөр, экспорт нэмэгдэж байгаа таатай дүр зураг харагдаж байгаа хэдий ч ард иргэдийн амьдрал бодит байдал дээр бага орлоготой иргэд хэцүү байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудын бизнес хэцүү байгаа.

Үнийн өсөлт үнэхээр ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг нэрвэж байгаа.

Тийм болохоор цаашдаа Засгийн газар инфляцыг бууруулах, үнийн өсөлтийг зогсоох тал дээр бодитой ажлуудыг хийж хэрэгжүүлэх хэрэгтэй.

Төсвийн үрэлгэн байдлаас танаж, мөнгөний бодлоготойгоо уялдуулах, аж ахуйн нэгжид очих зээлийн хүүг бууруулах талд анхаарах ёстой байна.

Үнийн өсөлтөд хамгийн их өртөж байгаа бага, дунд орлоготой иргэд, ахмад настан, тэтгэвэр, тэтгэмж авч байгаа иргэдийнхээ тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх бодлогод анхаарах хэрэгтэй байна.

Халамжийг хавтгайруулах биш яг зорилтот бүлэгт нь хүрдэг болгох тодорхой ажлууд хийх хэрэгтэй байна шүү гэдгийг хэлье.

Эдийн засгийн өсөлт гэсэн жоохон гоё тоон дээрээ анхаарах. Иргэдийн халаасанд үлдэж буй орлого, амьдралын чанараар асуудлыг хэмжих ёстой.

Ирэх оны төсөв оруулж ирэхдээ энэ талд анхаарах ёстой шүү гэдгийг чиглүүлж хэлье.

**Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

/Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр
өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, **санал хураалтаар үргэлжлэв.**/

Дараагийн санал хураалт. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Ингээд орлогын хэт ялгаа үүсгэж болохгүй. Тэнгэр шиг орлоготой улсуудын татварыг 1 хувь болгож болохгүй.

Бага орлоготой иргэддээ бид 1 хувь болгох, Засгийн газрын өргөн барьсан–

- 792 мянга хүртэл орлоготой бол татварыг нь тэглэх,
- 792 мянгаас 1 сая 500 мянга бол 1 хувь болгох,
- 1 сая 500-аас 3 сая бол 5 хувь болгох,
- 3 саяас 5 сая бол 10 хувь болгох гэдэг орлогоос нь хамаарсан шатлалтай.

Их орлоготой иргэд нь татвараа илүү төлдөг. Бага орлоготой иргэд нь бага төлдөг шударга зарчим үйлчлэх ёстой шүү.

Орлого өндөртэй улсууд нь 1 хувь төлөх чинь шударга бус шүү. Үүнийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх Төсвийн байнгын хороо, Засгийн газрын хууль, Ж.Баярмаа гишүүдийн хуулийг хамтарч нэгтгэж, ажлын хэсэг байгуулж, энэ талд нь анхаарч ажиллаарай гэдгийг чиглэл болгоё.

Санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Конвенц соёрхон батлах тухай санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Конвенц соёрхон батлах тухай хуулийн төсөл

/"Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай" ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх, санал хураалтаар үргэлжлэв./

Санал хураалт. “Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай” ЮНЕСКО-ийн конвенцыг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 80 гишүүн буюу 76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо. /алх цохив/

**“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг,
санал хураалтаар үргэлжлэв./**

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Зарчмын зөрүүтэй 50 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хуулийн хугацаатай.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Ажлын хэсэг нэлээн сайн ажилласан. Өнгөрсөн долоо хоногт 203 саналыг цөөлж нэгтгэсэн. Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлж саналуудыг оруулж ирсэн байх гэж найдаж байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан санал хураасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Тогтоолын төслийн 1 дэх дэд заалтын “төсөл, арга хэмжээг” гэсний дараа “эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлэн өндөр үр өгөөжтэй төсөл, арга хэмжээг тэргүүн ээлжид” гэж нэмэх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцож, 57 гишүүн 54.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

С.Эрдэнэболд гишүүнийг дэмжсэнээр тооцлоо. Х.Баасанжаргал гишүүнийг дэмжсэнээр авлаа. Бүртгэе.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх;

“3/Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлал, үнэлгээний үзүүлэлтийг боловсруулж, 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;”

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцож, 68 гишүүн буюу 65.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх;

4/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-ийг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө болон улсын төсвийн төслийг боловсруулахдаа бүрэн тусгасан байх;

Санал гаргасан ажлын хэсэг. Энэ чухал санал байна. Г.Лувсанжамц нарын гишүүд ажлын хэсэгт ажилласан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 66.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

5/“Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотод Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулж, бүс нутгийн түвшинд хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт манлайлан, хүний эрхийн салбарын хамтын нийгэмлэг, үндэсний хүний эрхийн байгууллагууд /NHRI/, иргэний нийгэм, эрдэм шинжилгээ, судалгааны зангилаа төв болон хөгжиж, аялал жуулчлалын шинэ урсгалыг бий болгож, эерэг үр дүн гарна.” гэж нэмэх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 67.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-6.4.7, 6.4.9, 6.4.11, 6.4.16, МУХТЖҮЧ-6.2.1.1, ЗГҮАХ-3.4.2.1, 3.4.2.2”, Төсөл, арга хэмжээ “Айл өрхийн сууцны дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид зориулсан ногоон зээлийн хүүгийн татаас олгох” гэж, Шалгуур үзүүлэлт “Дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл нэвтрүүлсэн айл өрхийн тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “5,000” гэж, Зорилтот түвшин “38,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “300,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 60.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.8 дахь дэд заалтын “Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ” гэснийг “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, МУХТЖҮЧ-1.2.1.8, ЗГҮАХ-2.3.1.1” гэснийг “АХ-2.2.3, 2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.1, 1.2.1.8, ЗГҮАХ-2.2.1, 2.3.1.1” гэж өөрчлөх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 69 гишүүн 66.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3.3 дахь дэд заалтын “Гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах ажиллагаанд хүнгүй техник хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээний Суурь он “2025” гэснийг “2024” гэж, Суурь түвшин “102” гэснийг “10” гэж, Зорилтот түвшин “112” гэснийг “20” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,650.0” гэснийг “3,300.0” гэж өөрчлөх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалта 104 гишүүн оролцож, 69 гишүүн буюу 66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.6.1 дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “Хүний эрхийн боловсрол, судалгаа шинжилгээний бүс нутгийн хамтын

ажиллагааг хөгжүүлнэ.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.5, 5.1.8”, “МУХТЖҮЧ-7.6.1”, “ЗГҮАХ-4.1.1.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “900.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “900.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гадаад харилцааны яам” гэж, Хамтран хариуцагч “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн санал хураалт.
/алх цохив/

Санал хураалтад 104 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 67.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “6-9 дүгээр ангийн нийт 263808 хүүхдийг “Үдийн хоол” хөтөлбөрт хамруулах /хичээллэх хоног 180, нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 3500 төгрөг/” гэж, Шалгуур үзүүлэлт “6-9 дүгээр ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “228,300.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “228,300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн санал хураалт.
/алх цохив/

Санал хураалтад 104 оролцсоноос 73 гишүүн буюу 70.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

